

**ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-58
1.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нарын 78 гишүүн 2025.09.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	6-42
2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай/	42-58

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
11 дүгээр сарын 25-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Б.Найдалаа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 49 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Баясгалан, Б.Бейсен, Б.Түвшин;
Чөлөөтэй: Ц.Баатархүү, М.Нарантуяа-Нара, Г.Хосбаяр;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут, М.Сарнай.

Нэг.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нарын 78 гишүүн 2025.09.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Цэцэгсайхан, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Л.Баттөр, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэд захирал Н.Алтанзул, Сангийн яамны Татварын бодлогын газрын ахлах мэргэжилтэн Т.Анхбаяр, Гаалийн ерөнхий газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чимгэрэл, мөн газрын Төв лабораторийн дарга С.Цэрэнчимэд, Тагнуулын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын татварын улсын байцаагч Б.Отгонбаяр, Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч Э.Чойсүрэн, Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Д.Будзаан, мөн газрын Гэмт хэрэг, зөрчил шалгах албаны чиглэлийн ахлах байцаагч Э.Саруул, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Суурин төлөөлөгчийн газрын Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, хяналтын асуудал хариуцсан мэргэжилтэн С.Болормаа, Анагаахын Шинжлэх ухаан Үндэсний Их Сургуулийн Захиргаа, хүний нөөцийн газрын дарга Т.Ариунтуяа, хуульч Э.Сэлэнгэ, эдийн засагч Т.Баасанжав, Хүний их эмч, Нийгмийн эрүүл мэндийн судлаач Б.Лхам-Эрдэнэ, зөвлөх Ц.Чулуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх

Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Ц.Долгормаа, Н.Монголмаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, М.Ганхүлэг, Т.Мөнхсайхан, С.Эрдэнэбат, А.Ганбаатар, Б.Найдалаа, Ө.Шижир нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Цэцэгсайхан, Сангийн яамны Татварын бодлогын газрын ахлах мэргэжилтэн Т.Анхбаяр, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Л.Баттөр, Гаалийн ерөнхий газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чимгэрэл, мөн газрын Төв лабораторийн дарга С.Цэрэнчимэд, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Суурин төлөөлөгчийн газрын Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, хяналтын асуудал хариуцсан мэргэжилтэн С.Болормаа, эдийн засагч Т.Баасанжав нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Ц.Мөнхтуяа, М.Ганхүлэг, Х.Болормаа, О.Саранчулуун, Ж.Галбадрах, Л.Энхнасан, М.Энхцэцэг, Ө.Шижир, Да.Цогтбаатар, Б.Найдалаа нар үг хэлэв.

Б.Найдалаа: 1.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Б.Найдалаа: 2.Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Б.Найдалаа: 3.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Б.Найдалаа: 4.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Б.Найдалаа: 5.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Б.Найдалаа: 6.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Б.Найдалаа: 7.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Б.Найдалаа: 8.Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Б.Найдалаа: 9.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн

хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Б.Найдалаа: 10.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Должинсүрэн, Мэргэжлийн боловсрол болон техникийн боловсролын газрын дарга Н.Нарангэрэл, Сургалтын хөтөлбөр, үнэлгээ, хүний нөөцийн бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан шинжээч Э.Батсэлэм, Сургуулийн өмнөх боловсрол, боловсролын удирдлагын байгууллагын төсөв, санхүүгийн бодлого, төлөвлөлт, эдийн засгийн шинжилгээ хариуцсан шинжээч Д.Гансүмбэрэл, Бодлогын газрын шинжээч Э.Чойсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Ц.Долгормаа, Н.Монголмаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа нар байлцав.

Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны дарга, С.Зулпхар тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа, М.Ганхүлэг, О.Саранчулуун, Д.Рэгдэл нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Ц.Мөнхтуяа, М.Ганхүлэг, О.Саранчулуун нар үг хэлэв.

Б.Найдалаа: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 5

Бүгд: 15

66.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 59 минут үргэлжилж, 29 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 88.4 хувийн ирцтэйгээр 15 цаг 48 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.НАЙДАЛАА

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
12 цаг 49 минут.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Найдалаа: Сайн байцгаана уу? Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Өнөөдрийн Байнгын хорооны хуралд ирсэн гишүүдийг танилцуулъя.

Аюушийн Ариунзаяа, Амгаланбаатарын Ганбаатар, Сархадын Зулпхар Бадрахын Найдалаа, Лутаагийн Энхнасан, Хөххүүгийн Болормаа, Даваасамбуугийн Ганмаа, Тогтмолын Мөнхсайхан, Дүгэрийн Рэгдэл, Мөнхчулууны Энхцэцэг, Жанчивын Галбадрах, Мөнгөнцогийн Ганхүлэг, Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Мөнхчулууны Энхцэцэг, Сүхбаатарын Эрдэнэбат нарын 16 гишүүн буюу 55.2 хувь нь хүрэлцэн ирсэн тул Байнгын хорооны өнөөдрийн хуралдаан эхэлснийг мэдэгдье. Уучлаарай Отгоншарын Батнайрамдал гишүүн. Отгоны Саранчулуун гишүүн мөн хүрэлцэн ирсэн байна. Сая ирц орсон чинь гээд нэрс гүйгээд урьд хойноо орчихлоо уучлаарай.

Ингээд гишүүд хүрэлцэн ирсэн учраас хуралдаан эхэлснийг мэдэгдье. Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Асуудал 1.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төсөл, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нарын 78 гишүүн 2025 оны 9 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн төслийн хэлэлцэх эсэхийг хэлэлцүүлэг явуулна.

Хоёрт нь Байнгын хорооны тогтоолын төсөл “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолын төсөл байгаа. Энийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн үзэл баримтлалыг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг танилцуулна. Номинчимэг гишүүний микрофоныг нээе. Микрофон 3.

О.Номинчимэг: Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

2012 оны Эрүүл мэндийн яамнаас санаачилж батлуулж байсан Тамхины хяналтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт сайн эрх зүйн орчныг бий болгож, бодит үр дүнг гаргасныг бид бүгд мэднэ. Тухайн үед бид тамхи гэдгийг нэг ижил зүйлээр ойлгож төсөөлдөг байсан. Харин өнөөдөр тамхины хэлбэр, хэрэглээ шинэ хэв маягт орсноор одоо мөрдөгдөж байгаа хууль шинэ сорилттой нүүр тулаад байна.

Иймээс Улсын Их Хурал өмнө гаргасан амжилт дээрээ тулгуурлаж, хүндээ ээлтэй, хүн төвтэй хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд нийгэмд шинээр үүсээд буй зорилт буюу хүүхэд, залуучуудын тамхины хэрэглээг бууруулах, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зүй ёсны шаардлага үүссэн тул Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа. Хуулийн төслөөр шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүнийг хуулийн зохицуулалтад оруулж хяналт тавина. ДЭМБ-ын 2022 оны тооцооллоор Монгол Улсад тамхины хэрэглээ нийт хүн амын 28.4 хувьд хүрч, Номхон далайн баруун бүсийн орнуудын дунд хамгийн өндөр тархалттай орны 7 дугаарт жагсаж байна.

2024 онд импортолсон 3.5 тэрбум ширхэг янжуур тамхийг нийт хүн амын тоонд харьцуулахад 1 хүнд жилд дунджаар 1000 ширхэг янжуур тамхи буюу 50 хайрцаг янжуур тамхи ноогдож байна. Гаалийн ерөнхий газрын мэдээгээр 2024 онд импортолсон янжуур тамхины хэмжээ 2012 оноос 2 дахин, электрон тамхины шингэн болон төхөөрөмжийн хэмжээ 2020 оноос 175 дахин буюу 2020 онд 47000 ширхэг электрон тамхи Монгол Улсын гаалиар орж ирж байсан бол энэ тоо 2024 онд 8.2 сая ширхэг болж өсжээ.

ДЭМБ-ын Монгол Улсад хийсэн судалгаагаар 2019 онд 13-15 насны сурагчдын 14 хувь нь утаат тамхи, 3.5 хувь нь электрон тамхи хэрэглэдэг байсан бол 2023 онд энэ үзүүлэлт 20 хувь, 25 хувь болж огцом өссөн дүнтэй судалгаа гарчээ. Үүнийг энгийнээр хэлбэл 13-17 настай сурагчид тутмын нэг нь сурагчдын 5 хүүхэд тутмын нь 1 янжуур, 4 хүүхэд тутмын 1 нь электрон тамхи хэрэглэж байгааг харуулж байна.

Шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүн болон электрон тамхин хүн ам зүйн хүрээнд хор багатай гэдэг нь нотлогдоогүйгээр үл барам хүүхэд залуусын дунд өргөн дэлгэрч, ирээдүйн хорт зуршлуудад хөтөлдөг нь олон судалгаагаар нотлогдсоор байна. Олон улсын судалгаагаар шинэ электрон тамхин бүтээгдэхүүн нь хорт бодис агуулдаг, амьсгалын замын үрэвсэл үүсгэх, зүрх, судасны системд сөргөөр нөлөөлөх, никотинд донтуулах эрс л өндөртэй байхыг тогтоосон. Мөн электрон тамхи нь тамхинаас гарах үр дүнтэй хэрэгсэл биш бөгөөд өсвөр үеийнхэн, залуус донтох шинэ зам болж байгаа буюу янжуур тамхи татах магадлал нь 3-5 дахин ихэсдэг талаар олон судалгаа баталж байна. Ийм ч учраас Сингапур, Норвег, Чили, Энэтхэг, Турк зэрэг дэлхийн 46 улс электрон тамхийг бүрэн хориглосон. 82 улс хууль тогтоомжоор эдийн засгийн болон эдийн засгийн бус зохицуулалтыг хийсэн. Үүний дотор Эстони, Финланд, Австрали, Герман, АНУ БНХАУ, Нидерланд, Шинэ Зеланд зэрэг 20 улс хүүхэд, залууст татагдаж байгаа амт үнэрийг нь хориглосон байна.

Гэтэл Монгол Улс хуулийн ямар ч зохицуулалтгүй цөөхөн хэдэн улсын байсаар байна. Иймд бид электрон тамхи ба уламжлалт янжуур гэж ялгалгүйгээр ижил хуулийн зохицуулалтад оруулахыг эрмэлзсэн нь энэ хуулийн төслийн чухал зорилтын нэг юм.

Хоёрдугаарт, тамхин бүтээгдэхүүний татварыг үе шаттай нэмэгдүүлнэ. Тамхи татах нь хувь хүний сонголт ч үр дагаврыг нь нийгэм хүртдэг. Нийгмийн эрүүл мэндийн асуудал байдаг. Нийгмийн эрүүл мэндийг төрийн бодлогоор хамгаалж, хуулиар зохицуулах зайлшгүй шаардлагатай. Үүний үндсэн бөгөөд хамгийн үр дүнтэй хэрэгсэл бол эдийн засгийн арга болохыг тамхидалтын түвшнээ амжилттай бууруулж байгаа дэлхийн олон улсаас бид харж болно. Тиймээс

янжуур, халаадаг, дүнсэн болон электрон тамхин бүтээгдэхүүний онцгой албан татварыг үе шаттайгаар нэмэгдүүлж, 2026-2030 оны хооронд үе шаттай өсгөх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

Манай улсын хувьд тамхин бүтээгдэхүүний дундаж үнэ 1 хайрцаг янжуур тамхи 3850 төгрөг. Энэ үнийн 40 орчим хувийг татвар эзэлж байгаа нь дэлхийн хамгийн хямд тамхитай улсын жагсаалтад багтаж, улмаар тамхины хэрэглээг дэмжих нөхцөл болж байгаа юм. Тамхины хяналтын суурь конвенцод дурдсанаар тамхины хэрэглээг бууруулах хамгийн үр дүнтэй бодлогын нэг нь тамхинд ноогдуулах татварыг нэмэгдүүлэх бөгөөд ДЭМБ-ын судалгаагаар тамхины үнийг 10 хувиар нэмэхэд хэрэглээ хамгийн багадаа 4 хувь, хөгжиж буй улсуудад 5-7 хувь буурдаг бөгөөд ялангуяа өсвөр насныхны хувьд илүү амархан татгалздаг гэсэн судалгаа байдаг.

Энэ хууль гарснаар тамхины үнэ нэмэгдэнэ. Гэхдээ энэ нь татварын орлогыг бүрдүүлэх зорилго ер өвөртлөөгүй. Нийгмийн эрүүл мэнд тэр дундаа өсөн нэмэгдэж байгаа хүүхэд, өсвөр үеийнхний тамхидалтыг бууруулж, эрүүл мэндийг нь хамгаалахад чиглэж байгаа гэдгийг онцлон дурдъя. Маш товчоор хэлэхэд тамхины онцгой албан татварыг тамхины эсрэг тэмцэлд зориулна. Үүнд сурагчдын үдийн хоолны шим тэжээлийг дээшлүүлэх, хүүхэд залуусын чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэхэд буюу спортын дугуйлан, хөтөлбөр, барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгд дүүлэхэд зарцуулна. Мөн тамхинаас урьдчилан сэргийлэх, гарах бодитой, тогтвортой арга хэмжээг санхүүгийн эх үүсвэрээр хангах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Хуулийн төслийн гол зорилго бол хүүхэд, өсвөр насныхны тамхидалтыг бууруулахад чиглэж байгаа. Тамхи татах нь хувь хүний сонголт гэж бид ярьдаг. Гэвч хувь хүн болж төлөвшиж амжаагүй хүүхэд, өсвөр үеэ бид хувь хүний сонголт гэдэг нэрийн доор орхигдуулж байна. Та бидний заримд нь байгаа хор багатай гэж ташаа ойлголт нь элдэв төрлийн амт, үнэртэй хослохоороо өнөөдөр дөнгөж 10 настай балчрууд хүртэл электрон тамхины хэрэглэгч болж байгаа сэтгэл эмзэглүүлэн баримтуудыг багш, аав, ээжүүд ярьж байна. Иймээс хуулийн төсөл тусгасан эдийн засгийн бус зохицуулалтыг дурдвал янжуур болон электрон тамхины амт, үнэрийг хязгаарлана. Тамхи бол жимсний амттай зайрмаг биш. Тамхи бол эрүүл мэндэд хортой бүтээгдэхүүн. Бүх төрлийн тамхийг ил байршуулж худалдаалахыг зогсооно. Хүүхэд ордог хүнсний дэлгүүр тамхи сурталчилдаг үзэсгэлэн биш. Тамхийг гудамж талбайд алхангаа ил татахыг хориглож дам тамхидалтыг хор хөнөөлөөс иргэдээ хамгаална. Эдгээр зохицуулалт нь уламжлалт янжуур болон шинэ төрлийн электрон тамхинд ижил үйлчилнэ. Ингэснээр огт зохицуулалтгүй явж ирсэн тамхины шинэ тутам хэлбэрүүд хуулийн зохицуулалт үйлчилж эхлэх нөхцөл бүрдэх юм.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Бидний өнөөдөр хэлэлцэх хуулийн төсөл зөвхөн Номинчимэг, эсвэл ажлын хэсгийн гишүүдээс дэвшүүлж байгаа санал, санаачилга биш юм. Энд иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалах тангараг өргөсөн эмч нар, сурагчдынхаа ирээдүйд санаа зовоод хичээлийн завсарлагаагаараа сургуулийн ариун цэврийн өрөөнд манаа хийж байгаа багш нар, электрон тамхи үнэртдэггүй болохоор хүүхдийнхээ төлөө санаа зовж халаасыг нь тэмтчиж байгаа аав, ээж нар, асран хамгаалагчийн хүсэл зориг, нийгмийн захиалгаас төрсөн хуулийн төсөл юм. Олон 10 мянган эцэг эх, эмч, багш нар энэ хуулийг батлагдахыг итгэл тавин хүлээж байгаа. Хуулийн төсөл

өргөн барьсантай холбоотойгоор тамхи, тамхин бүтээгдэхүүн импортлогчдын зүгээс зохион байгуулалттай лобби компанит ажил өрнүүлж эхэлсэн нь нэгэнт тодорхой болсон. Чөлөөт нийгэмд хуулиар хориглоогүй бизнес эрхэлж ашиг олох нь эдийн засгийн эрх чөлөөний үндэс гэдэгтэй хэн ч маргахгүй. Гэхдээ төгс бус зохицуулалттай, өрсөлдөөнгүй зах зээлийн үр дүнд онцгой бүтээгдэхүүнээс огцом олсон ашгаа төөрөгдүүлсэн мэдээлэл гүтгэлэг түгээхэд зарцуулах нь ёс зүйгүй хэрэг мөн.

Нөгөө талаар тамхины лоббины мөнгө нь ирээдүй хойч үеийнхээ эрүүл мэнд, амь насыг золиосолж олсон мөнгө гэдгийг анхааруулах нь зүйтэй. Нийгмийн эрүүл мэнд бол нэг хэсгийн бизнесийн орлогоос эрхэм зүйл. Янжуур тамхины татварыг нэмэгдүүлэхгүй байх нь жилд 4300 хүн буюу бүхэл бүтэн 1-2 сумын иргэдээ үхэл рүү түлхэж байгаатай яг адил зүйл юм.

Нөгөө талд электрон тамхийг хуулиар зохицуулахгүй байх нь хүүхэд, залуусаа бүх төрлийн хорт зуршилд донтох эрсдэл рүү бид сайн дураараа хөтөлж байгаатай ижил явдал юм. Эцэст нь хэлэхэд ямар ч төрлийн тамхи хортой нь үнэн. Хортой бүтээгдэхүүн зохицуулалттай байх ёстой нь ч үнэн. Харин тамхины эсрэг тэмцлийг бид хожимдож эхлүүлж байна. Гэхдээ үүнийг засаж залруулах арга хэмжээ авах нь улс үндэстэн, үр хүүхдийнхээ өмнө хүлээсэн ард иргэдийн төлөөлөл болсон та бидний үүрэг юм.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Найдалаа: Танилцуулга хийсэн Номинчимэг гишүүнд баярлалаа.

Хуралдаанд хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн ажлын хэсгийг танилцуулъя. Нэр нь дуудахаар босоод байгаарай. Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Цэцэгсайхан, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Л.Баттөр, Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн дэд захирал Н.Алтанзул, Сангийн яамны Татварын бодлогын газрын ахлах мэргэжилтэн Т.Анхбаяр, Гаалийн ерөнхий газрын төв лабораторийн дарга С.Цэрэнчимэд, Гаалийн ерөнхий газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чимгэрэл, Тагнуулын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын татварын улсын байцаагч Б.Отгонбаяр, хуульч Э.Сэлэнгэ, Эдийн засагч Т.Баасанжав, Хүний их эмч, Нийгмийн эрүүл мэндийн судлаач Б.Лхам-Эрдэнэ, Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Будзаан, Цагдаагийн ерөнхий газрын Гэмт хэрэг, зөрчил шалгах албаны чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч Э.Саруул, зөвлөх Ц.Чулуун ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Одоо хуулийн төсөл санаачлагчийн илтгэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Нэрсээ өгнө үү.

Мөнхсайхан гишүүнээр тасалъя. Ариунзаяа гишүүнээс эхэлнэ. Ариунзаяа гишүүний микрофоныг өгье.

А.Ариунзаяа: 78 гишүүн Номинчимэг гишүүнтэй хамт энэхүү хуулийг өргөн барьсан. Би түүний нэг. Номинчимэг гишүүн сая яг сошиал энэ давлагаанд харлуулах гэдэг юм уу, муулах гэдэг юм уу, сөрөг мэдээлэл өгөх гэдэг юм уу ийм тамхины лобби бүлэг маягийн энэ хүмүүсийн зохион байгуулалттай гүтгэлэгт өртсөн гэдгийг хэлж байна. Үнэн. Тэгэхээр энэ маш харамсалтай. Бид зүгээр Номинчимэгийн эрх ашгийг хангаж Номинчимэгийн хуулийг батлах гээд байгаа асуудал огтоос биш. Насанд хүрсэн хүн тамхи татаж байгаа нь өөрийн ухамсарт сонголт мөн. Энэ хуулийн гол агуулга нь ердөөсөө л бид бас насанд хүрээгүй хүүхдүүдийг хамгаалах зорилго агуулагдаж байгаа. Шууд болон шууд бус аргаар.

Шууд аргаараа яаж бид нар хамгаалах гээд байна вэ гэхээр нэгдүгээрт сургуулийн орчинд нээлттэй борлуулагдаж байгаа ямар нэгэн зохицуулалтгүй гэдэг энэ шалтгаанаар, шалтгаар худалдаачид хүүхдүүдэд цахилгаан электрон тамхи борлуулж байгааг хориглох, нүдэнд нь ил нээлттэй гоё жимсний зурагтай, гоё гоё үнэр, амттай ийм тамхийг нүдэнд нээлттэй байгааг нэгдүгээрт болих. Амт, үнэрийг ер нь хориглох гэсэн ийм зорилгыг агуулж байгаа.

Тэгэхээр хүүхдүүд томчуудыг л ер нь хардаг. Тамхи татах анхны сэдэл нь өсвөр насныхны хувьд юу байдаг вэ гэхлээр өө би ер нь том хүн болж байгаа шүү. Би ер нь ийм cool залуу, cool эмэгтэй шүү гэдэг. Эс үгүй бол өөрийнхөө зурагтаар харж байгаа өөрийн тэр шүтэн биширдэг одууд хэрхэн яаж биеэ авч явж байгаа. Кинон дээр юу гарч байгаа гэдгээс харж би энэ хүн шиг том хүн болж байна гэдэг. Эс үгүй бол дээд ангийн ах, эгч нарыгаа даган дуурайдаг. Ийм л үйлдлээр анхны энэ тамхи татах сонирхол нь бий болдог.

Монгол Улсад ер нь энэ хүүхдүүдийн тамхины хэрэглээг бас гаргасан байдаг. Монгол Улсын хэмжээнд 13-15 насны сурагчдын 11 орчим хувь нь электрон тамхи хэрэглэж байгаа талаар 19 онд судалгаа гаргаж байсан. Гэтэл 19 оноос хойш яг энэ тамхины зохицуулалтыг бид нар хийж чадахгүй байсаар байгаад одоо 25 хувь болж нэмэгдсэн байгаа. Тэгээд бид нар энэ электрон тамхийг хориглох тухай, электрон тамхи хүнд хэцүү байна шүү гэдгийг ярьж бараг 2, 3 жил боллоо. Энэ хугацаанд харин ч эсрэгээрээ бид нар бараг сурталчилгаа маяг.../минут дуусав./

Б.Найдалаа: 1 минутаа нэмж авъя.

А.Ариунзаяа: Сурталчилгаа маягийн юм хийгээд өгчхөж байгаа юм. Тэгэхээр энэ өөрөө янжуур тамхи болон цахилгаан тамхи аль нь илүү хортой вэ гэдэг асуудал огтоос биш. Аль аль нь хортой. Цахилгаан тамхийг бүүр хориглох гээд байгаа юм шиг нийгэмд буруу мэдээлэл өгөөд байна. Үгүй шүү дээ бид нар хориглох гээд байгаа ийм асуудал огт байхгүй. Харин адилхан зохицуулалтад оруулъя. Тамхи татах цэгтэй нэгэн адил янжуур тамхи ч тэр, электрон, цахилгаан тамхи ч тэр цэг дээр татдаг байя, олон нийтийн газар татдаггүй байя. Адилхан татвар авдаг болъё гэж байгаа юм. Тэгэхээр хэдэн хувийн татвар авах гээд байгаа юм. Шууд маргааш нэмэгдэх гээд байгаа юм уу, ямар үе шаттай нэмэгдэх гээд байгаа юм, ямар нэгэн байдлаар цахилгаан, энэ электрон тамхийг хориглох гээд байгаа юм уу, үгүй юм уу гэдэг дээр Номинчимэг гишүүн бас нийгэмд мэдээлэл өгөөд явсан нь зүйтэй байх гэж бодож байна.

Б.Найдалаа: Номинчимэг гишүүн хариулна. Микрофон 3.

О.Номинчимэг: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Баярлалаа. Энэ асуудлыг бид үнэхээр хойноос нь бас зохицуулах гээд явж байгаа. Энийг нийгэм даяараа манай Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн энийг ойлгоод энэ өмнө, урьд хожид байгаагүй ийм дэмжлэгтэйгээр энэ тамхины хуулийг Улсын Их Хуралдаа бид 78 гишүүн хамтарч өргөн барьсан байгаа юм. Тэгээд яг энэ асуудал дээр үнэхээр урьд нь ч гэсэн Эрүүл мэндийн яам маань арга хэмжээ авах гээд хамгийн их иргэдтэйгээ ойрхон ажилладаг Засаг дарга нар, хөдөө орон нутгийн Засаг дарга нар маань ч гэсэн арга хэмжээ авах гээд хууль, эрх зүйн орчин ерөөсөө байхгүй удсан учраас нэг бол шүүхэд дуудагддаг, нэг бол тэр ажлыг санаачлаад явж байгаа төрийн албан хаагчдыг улс төрчдийг гүтгэж харлуулаад энэ ажлыг нь мохоогоод дуусгадаг ийм л нөхцөл байдалтай явж ирсэн.

Тэгээд ийм ч учраас энэ электрон тамхи байдаг юм уу шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүн ямар нэгэн хуулийн ямар ч зохицуулалт байхгүйгээр одоо та бүхний хэрэглэж байгаа энэ цаас байдаг юм уу, утас байдаг юм уу, компьютертой адилхан ер нь зохицуулалттай л байгаа гэсэн үг. Тэгээд гаалийн албан татвар дээр электрон бараа гэдгээр зарим бүтээгдэхүүн нь орж ирээд тамхи гэж үзэгддэггүй байсан учраас ямар ч зохицуулалт байхгүй маш цахим орчинд маркетинг өндөр явдаг, маш өндөр ашиг, орлогоороо энийгээ сурталчилдаг. Ингээд түрүүн хэлсэн 2020 онтой харьцуулахад импортын хэмжээ 175 дахин буюу 47 мянгаас 8.2 сая ширхэг болж энэ маань өөрөө Монголын үр хүүхдүүд, дунд сургууль, ахлах сургууль байж байгаад одоо бага сургууль руу орж байна. Ийм асуудал болоод байгаа юм. Тэгэхээр энийг Ариунзаяа гишүүний яг хэлж байгаачлан бид нар эдийн засгийн аргаар, зохицуулалтын аргаар өмнөх тамхин бүтээгдэхүүнүүдтэй адилхан болж л хуульчилъя гэж байгаа. Тэрнээс нэгийг нь хааж хориод, нөгөөг нь дэмжих гээд байгаа зүйл ер байхгүй. Нийтээрээ тамхин бүтээгдэхүүний хэрэглээгээ багасгахын тулд адилхан зохицуулалтад оруулъя гэсэн ийм л зорилт тавьж байгаа.

Татварын хувьд онцгой албан татварыг бас үе шаттайгаар энийг нэмэгдүүлэхээр тооцоолсон байгаа. Энийг манай Эрүүл мэндийн яамныхан, татварынхан, гаалийнхан, ажлын хэсгийнхэн маань Женевт дэх ДЭМБ-ын татварын бодлогын газрынхантай хамтарч Монгол Улсынхаа нөхцөл байдал, худалдан авах чанар, инфляц гээд бүх энэ үзүүлэлтүүдийг оруулж байгаад тооцоолж гаргасан. Үе шаттай нэмэх 26-30 он хүртэл аажмаар нэмнэ. Ингээд 30 он хүртэл нэмж байж бид нар одоогийн байгаа тамхидалтын хэмжээгээ 14 хувиар буулгаж чадахаар ийм тооцоолол гарсан байгаа.

Тэгээд электрон тамхины хувьд ч гэсэн яг энэ дээр дүйцүүлэх маягаар дүнсэн тамхи, янжуур тамхи энэ бүгдийг 26-аас 20, 30 он хүртэл үе шаттай нэмнэ. Ингэж байж бид нар эдийн засгийн энэ зохицуулалтаар хэрэглээг багасгах энэ улс орнуудад хамгийн сайн үр дүн гаргаж байгаа энэ жишгийг Монгол Улсдаа ч гэсэн бас нэвтрүүлж үр дүнг нь үзэх ийм боломж бүрдэнэ гэж харж байгаа юм. Нарийвчилсан тоон мэдээллийн талаар манай Сангийн яамнаас юм уу, эдийн засагчдаас бас нэмэлт мэдээллийг өгөөд ямар ач холбогдолтой гэдгийг бас нэмээд тайлбарлах уу?

Б.Найдалаа: Сангийн яамны мэргэжилтэн хаана байгаа билээ? Микрофон руу дөхье. Микрофон дээр сууна даа. Сая Ариунзаяа гишүүн тодорхой асуусан. Татварыг яг яаж нэмж байгаа, ямар хугацаатай шатлалтай нэмж байгаа вэ? Тэгээд огцом нэмж байна гэсэн шүүмж, яриа гараад байгаа. Микрофон 5 дээр суугаарай тэр нөгөө талд. Тэгэхээр татварыг ямар үе шаттайгаар яг хэдээр нэмж байгаа юм

тэр нь тийм огцом юм уу, аажуу юм уу гэдгийг тодорхой мэдээлэл өгөөрэй. Микрофон 5.

Т.Анхбаяр: Сангийн яамны Татварын бодлогын газрын ахлах мэргэжилтэн Анхбаяр. Гишүүний асуултад хариулъя. Яах вэ татварыг түрүүн Номинчимэг гишүүний хэлсэнчлэн яг ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу 2030 он гэхэд тамхины ширхэг тамхины үнийн татварын эзлэх хувийг 75 хувьд хүргэх тийм зорилтыг ер нь дэвшүүлж байгаа. Тэгэхээр энэ зорилтод хүрэхийн тулд бид нар шууд ерөөсөө дараа жилээс эхлүүлээд л асар өндөр хэмжээгээр нэмэгдүүлэх боломжгүй. Тэгэхээр тодорхой түвшинд яг аргачлал хийгээд ДЭМБ-ын мэргэжилтнүүдтэй зөвлөсний үндсэн дээр татварыг тооцооллыг хийж гүйцэтгээд бүх талын тооцоо судалгаануудыг үндэслээд тодорхой хэмжээнд мэдээж дараа жилийн тэр төсвийн дараагийн төсвийн жилээс 2 дахин орчим нэмэгдэхээр байгаа юм. Гэхдээ.../минут дуусав./

Б.Найдалаа: Гүйцээж хариулъя 5.

Т.Анхбаяр: Яг Сангийн яамны зүгээс яг энэ ажил дэд ажлын хэсэгт орж ажиллахдаа бас нэг тооцооллыг хийж гүйцэтгэсэн. Энэ нь ер нь ойролцоогоор хайрцаг тамхины 20 ширхэг тамхины үнэ ямар хэмжээгээр нэмэгдэх вэ гэдэг ийм тооцоолол хийсэн. Энэ дээрээс аваад үзэхэд дунджаар 12-17 хувийн нэмэгдэлтэй байхаар ер нь бол 3500 төгрөгөөр зарагддаг хайрцаг тамхи 4000 гаран, орчим болж нэмэгдэнэ гэсэн ийм тооцоолол байгаа 2026 онд.

Б.Найдалаа: Аажим нэмнэ гэсэн үү? Хэдэн жилийн хугацаатай ямар шатлалдаа нэмэх юм? Тэрийг жоохон тодруулаад хэлчих хэрэгтэй байна. 30 он хүртэл юм уу 40 он хүртэл юм уу?

Т.Анхбаяр: 2030 он хүртэл үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

Б.Найдалаа: Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

А.Ариунзаяа: Тэгэхээр өчигдөр билүү уржигдраас ер нь бараг тамхи 30 мянган төгрөг болох нь гэх мэтчилэн хуурамч мэдээ яваад байгаа нь хуурамч мэдээ шүү гэдгийг онцолж хэлмээр байна. 26 оны хувьд, 27 оны хувьд, 28 оны хувьд, 30 онд хүртэл бас 30 мянган төгрөг 1 янжуур хайрцаг болно гэдэг бас худал мэдээлэл шүү дээ. Тэгэхээр ердөөсөө энд автаж болохгүй. Угаасаа Монгол Улсын хувьд татвар маш бага байгаа. Тэгэхээр татварыг нэмэгдүүлэх нь зүйтэй. 1 жилийн үнэ 15-20 хувиар нэмэгдэнэ гэсэн л ийм тооцоо яваад байгаа юм байна шүү дээ. Энэ хүртэл өөрөө бага байхгүй юу. Бид нар бусад улс оронтой харьцуулах ёстой. Нийгмийн эрүүл мэндэд үзүүлж байгаа хор хөнөөлийг ч гэсэн бид нар бодох ёстой. Тэгэхээр энэ дээр онцолж авах нь зүйтэй.

Хоёр дахь нь болохлоор тэр гаатай холбоотой жимс, амтны хоригийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөөч.

Б.Найдалаа: Хариулт Номинчимэг гишүүн. Микрофон 3.

О.Номинчимэг: Энэ жимс жимсний үнэр, амттай асуудалд өөрөө ийм гоё үзэмжтэй, бусад юмтай андуурагдахаар ийм бүтээгдэхүүн манай Монгол улсад маш их орж ирсэн байна. Дараа нь манай гаалийнхан ч гэсэн мэдээлэл өгөх байх. Тэгээд энэ маань өөрөө 2020-оод оноос хойш дэлхийн улс орнуудад энэ

бүтээгдэхүүн чинь өөрөө донтолтын арга зам, хүүхдүүдийг багаас нь янжуур тамхины тамхины хэрэглэгчийг бэлдэх ийм арга зам болоод байна. Хүүхэд, өсвөр насныхны хэрэглээг үнэхээр энэ үнэр, амтаараа, гоё жимсний үнэр, амтаараа хоргүй гэдэг сурталчилгаатайгаа нийлээд хийгээд байна гэдэг ийм судалгаанууд гараад дэлхийн бидний хардаг өндөр хөгжилтэй орнууд аль хэдийн 20 улс энийг хорьчихоод байгаа юм. АНУ Канад, Нидерланд, Дани, бид нарын ойрхон гэх юм бол Австрали, Шинэ Зеланд нийгмийн эрүүл мэндээ хамгийн их хамгаалж ирдэг Финланд, Эстони гээд. БНХАУ ч гэсэн энийг ингээд хорьчихоод байгаа. Тэгтэл бид нар нийт орж ирж байгаа.../минут дуусав./

Б.Найдалаа: Гүйцээж хариулъя.

О.Номинчимэг: Манай Монгол Улсад орж ирж байгаа жилд 8.2 сая ширхэг орж ирж байгаа энэ бүтээгдэхүүний их дийлэнх нь буюу 95- 98 хувь нь энэ дотооддоо үнэр, амтлаг нь хорьчихсон Хятадын тусгай бүс буюу Шэньжэньд зөвхөн экспортын зорилготойгоор үйлдвэрлэдэг ийм газруудаа 5-10 үйлдвэрээс орж ирдэг ийм судалгаа байгаад байгаа юм. Тэгэхээр энэ өөрсдөө хэрэглэдэггүй бүтээгдэхүүнээ гадагшаа зарах зориулалттай тусгай бүсэд үйлдвэрлэдэг ийм бүтээгдэхүүн. Тэгэхээр бид нар энэ хүүхдүүдээ дараа дараагийн донтолтын зам болгохгүй, дараа дараагийн тамхины үе бэлдэхгүйн тулд л энэнээс хамгаалахын тулд бусад улсын энэ сайн туршлагыг судалгаан дээр үндэслэсэн туршлагыг аваад Монгол Улсдаа бас оруулах нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байгаа.

Тэгээд түрүүн Ариунзаяа гишүүний бас асуусан энэ тамхины татвартай холбоотой асуудлыг манай ДЭМБ-аас ажлын хэсэгт байгаа Болормаа зөвлөх бас нарийвчилж мэдээлэл өгье.

Б.Найдалаа: Микрофон 1.

С.Болормаа: Та бүхний өдрийн мэндийг эрье. Татварын тооцооллыг маш тодорхой хийсэн байгаа. Одоогоор 20 ширхэгтэй янжуур тамхинд 836 төгрөгийн татвар оногдуулж байгаа. Энэ татварыг ирэх жил 2000 төгрөг 26 онд, 27 онд 4000, 28 онд 6000, 29 онд 8000 ингээд 30 онд 10000 төгрөгт хүргэхээр байгаа. Ингэснээрээ ДЭМБ-ын зөвлөөд байгаа тамхины татвар нь жижиглэнгийн үнийн худалдааны 75 хувиас доошгүй байх ёстой гэсэн зөвлөмжид хүрч байгаа. Ингэснээрээ 2030 онд энэ тооцооллоор тамхины хэрэглээг 14 орчим хувиар бууруулна гэсэн тооцоолол байгаа. Манайд одоо байгаа энэ тамхины үнэ 3500 орчим төгрөг байгаа гээд зах зээлээр худалдагдаад байгаа энэ тамхины үнэ бол маш хямд, татвар нь ч хямд, үнэ нь ч хямд. Хамгийн наад зах нь энэ хөрш орнуудтай харьцуулахад 3-4 дахин хямд. Монгол Улс дэлхийд тамхи нь хямд, татвар нь.../минут дуусав./

Б.Найдалаа: Баярлалаа. Ганхүлэг гишүүн асуулт асууна.

М.Ганхүлэг: Байнгын хорооны гишүүддээ ажлын хэсгийнхэндээ өдрийн мэндийг хүргэе. Маш чухал хуулийн төслийг санаачилж орж ирж байгаа Номинчимэг гишүүндээ бас талархал илэрхийлье. Миний бие бас хамт өргөн мэдүүлсэн гишүүдийн нэг байгаа. Монгол улс тамхины төрлийн бас бизнес эрхлэхэд хамгийн таатай улсуудын тоонд зүй ёсоор орж байгаа. Үнэ ханшийн хувьд ч тэр, бусад энэ хууль тогтоомжийн тодорхойгүй байгаа байдлын хувьд ч тэр. Та бүхэн маань бас тодорхой мэдээллүүдийг өгч байна. Шинэ тутам гарч байгаа нийгмийн тодорхой өөрчлөлтүүд, энэ сорилтуудтай Монгол Улсын

парламент бас цаг үеэ олсон энэ хууль тогтоомжуудыг бас дор бүр нь баталж, бид бас яг иргэдийнхээ өдөр тутмын амьдрал, эрүүл мэнд, амь насыг бас хамгаалах ийм үүрэгтэй. Тэр утгаараа энэ цахим тамхитай холбогдолтой, электрон тамхитай холбогдолтой зохицуулалтыг сайжруулах гэж байгаа бидний санаачилга би зөв өө гэж ингэж бас үзэж байгаа юм.

Мөн дээрээс нь нэгэнтээ маш олон жил тамхины хамааралтай болчихсон хүмүүсээс илүү өсвөр үеийнхэн, шинэ үеийнхэн рүүгээ хандаж бас тодорхой үйл ажиллагааг бас явуулах нь илүү үр өгөөжтэй байх болов уу гэсэн ийм бас бодолтой байна. Тэгэхээр ерөнхий концепц, агуулгыг бас бүрэн дэмжиж байгаагаа бас илэрхийлье.

Хэд хэдэн бас мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод ойлгуулах зорилгоор би хэд хэдэн асуултыг асууя. Ялангуяа эрдэмтэд, эрүүл мэндийн салбарын судлаачид маань бас хариулах нь зөв байх. ДЭМБ-ын 2024 оны тоо статистикийг та бүхэн маань танилцуулаад байх шиг байна. Бид нийт нас баралтын 17 хувь нь энэ тамхинаас хамааралтай гэдэг ийм тоог танилцуулж байх шиг байна. Жил болгон 4300 орчим хүнийг бид нар энэ тамхины хамаарлаас болж амь насаа алдаж байна гэж ингэж тогтоож байна. Ер нь бидний энэ судалгаа тооцооллууд хэд хэр бодитойтой вэ? Яг ямар байдлаар бид бүхэн бас энд тоо мэдээллүүдээ гаргадаг юм, хор хөнөөлийг бас хэрхэн тооцдог юм гэдгийг бас илүү дэлгэрүүлээд саяын миний хэлж байгаа агуулгууд дээр үнэхээрийн бас аюултай ийм тоо, мэдээллүүд байвал та бүхэн нэмж бас үндсэндээ танилцуулаач гэдгийг бас хэлье.

Үүний цаана бас бид нар нэг талдаа хатуу аргаар тэмцэж байгаа нь зөв. Эдийн засгийн аргаар, бусад улсын жишгээр. Нөгөө талаасаа бас энэ Монгол улсын маань энэ нийгмийн байдал, нийгмийн стресс, бухимдал, түүнтэй холбогдолтой асуудал үүний цаана бас байна уу? Энэ асуудлуудаа бас бусад улс орнууд болон олон улсын байгууллагууд маань бас ямар зөвлөмжүүдийг өгдөг юм бэ? Тамхины энэ хамааралтай байдал, тамхи татаж байгаа энэ байдал нь нийгмийн цалин хөлс, нийгмийн баталгаатай бас шууд хамааралтай ер нь байдаг уу? Энэ талаарх судалгаа, мэдээллүүдийг бас дэлгэрүүлээд асууя.

Б.Найдалаа: Микрофон 4.

Л.Баттөр: Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Баттөр байна. Тэгэхээр энэ тооцооллуудыг бид нар эрүүл мэндийн үзүүлэлт хамгийн сүүлд 2024 гэсэн ийм ном байгаа. Энэ дээр Эс Ти Жи-гийн тогтвортой байдлын үзүүлэлтийн 1 үзүүлэлт болж гардаг. Энд тодорхой аргачлалаар бодсон тоон мэдээллүүд гардаг байгаа. Дэлхий нийтээрээ бас хийдэг Монгол улсад өвчлөлийн энэ дарамтын судалгаануудыг тодорхой хугацаанд хийж гүйцэтгэдэг. Хамгийн сүүлд гарсан мэдээллээр өвчлөл ялангуяа нас баралтад 2 үндсэн шалтгаан байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр зүрхний шигдээс, тархины цус харвалт гээд. Эдгээр нас баралтад нь ямар хүчин зүйл нөлөөлөөд байгаа вэ гэдэг ийм эрсдэлийн судалгаа хийдэг. Тэнд 1-рт нь артерийн даралт ихсэлт, 2, 3 дугаар шалтгаан нь эрэгтэйчүүдэд тамхи, архи гэсэн ийм шалтгаан байгаа. Тэгэхээр та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа Монгол хүмүүсийн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн насны дундаж насны ялгаа 9.2 байгаа.

Гэтэл энэ архи гэдэг, тамхи гэдэг энэ зүйл маань эмэгтэй хүйст үзэх юм бол эрсдэлт хүчин зүйлийн бүүр 7, 8 дахь шалтгаан болж байгаа. Тэгэхээр энэ үнэхээр

энэ нас баралтын өвчлөлийн гол шалтгаан болж байгаа гэдгийг тодорхой харуулж байгаа ийм тоон мэдээлэл байгаа. Үнэндээ судалгаа, статистик дэлхий нийтээрээ Монгол улсад хангалттай хэмжээнд байгаа. Нийгмийн бас магадгүй нийгмийн стресс юм уу, цалин хөлс, амьжиргааны түвшинтэй холбоотой ийм тамхи хэрэглэдэг, архи хэрэглэдэг ийм хандлага байдаг юм биш үү гэдэг ийм зүйлүүд байдаг. Энийг бас тодорхой хэмжээгээр бид нар судалж үзэхэд ингэж батлагдсан, мэдээж нөлөөлсөн гэдэг зүгээр судалгааны түвшинд иймэрхүү ийм ийм нөлөөлөл байна гэж байгаа болохоос биш үнэхээр гол шалтгаан нь ийм нийгмийн стресс юм уу, хүний хувь хүний ийм стрессээс болж тамхинд ордог юм гэсэн ийм батлагдсан судалгаа ерөөсөө байхгүй гэдгийг хэлье.

Түрүүний асуулт дээр бас нэмээд хэлэхэд татвар яагаад огцом нэмэгдсэн бэ гээд гайхаад байх шиг байна. Цахилгаан тамхи өөрөө татваргүй, онцгой албан татваргүй явж ирсэн байхгүй юу. Тийм учраас онцгой албан татвар тавиад эхлэхээр энийг огцом нэмэгдэж байна гэж хүлээж аваад байгаа юм. Тэгэхээр энэ хуулийг олон жил ингээд 2, 3 жил хойшлуулах тусмаа тэр цахилгаан тамхины асар их татвараас зайлсхийж байгаа ийм зүйл болоод байгаа гэдгийг хэлмээр байна. Тамхины тэр 2000, 4000, 6000, 8000 болгоод ингээд жил болгон нэмж байгаа энэ зүйл ч гэсэн инфляцыг тооцоолоод үзэх юм бол бараг нэмэгдээгүйтэй адилхан болж магадгүй хувирна 3, 4 жилийн дараа.

Тийм учраас магадгүй энэ зүгээр энэ хууль хэлэлцэгдээд батлагдсан ч гэсэн дараа дараагийн тооцоолол хийж, дараа дараагийн арга хэмжээнүүд тасралтгүй үргэлжлэх байх гэж найдаж байгаа. Баярлалаа.

Б.Найдалаа: Нэмж хариулах өөр ажлын хэсгийн гишүүн байгаа юу болсон уу? Тэгвэл Ганхүлэг гишүүн. Хаана хэн билээ, аль байгууллага? Микрофон руу суугаарай. Микрофон 5 дээр юм уу, 1 дээрээ оч, 2 дээр. Микрофон 2-ыг нээе.

Ч.Чимгэрэл: Түрүүн бас Ариунзаяа гишүүний асуулт нь нэмэлтээр хариулт өгье. Зөвхөн онцгой албан татвараас гадна бас гаалийн

Б.Найдалаа: Нэрээ хэлээрэй тэмдэглэлд тусгах учраас.

Ч.Чимгэрэл: Гаалийн ерөнхий газрын барааны ангилал, үнэлгээний хэлтэс хариуцсан дарга Чимгэрэл байна. Түрүүн онцгой албан татвараас гадна мөн бас гаалийн тарифын хувь, хэмжээг бас нэмэгдүүлж байгаа. Янжуур тамхин дээр гаалийн тарифын хувь, хэмжээ 30 хувь байсан бол шинэ төрлийн энэ электрон тамхин дээр бид нар бас ижилтгээд 30 хувийг бас нэмж байгаа. Тэгэхээр гаалийн албан татвар, онцгой албан татварын хувь, хэмжээ бол хуулийн төсөлд нэмэгдсэн байдлаар тусгасан. Амтны хувьд нийт импортоор орж ирж байгаа электрон тамхины 80 орчим хувь нь жимсний амттай. 10 орчим хувь нь гааны амттай, бусад нь ундаа болон кока кола гээд бусад.../минут дуусав./

Б.Найдалаа: Гүйцээж хариулъя. Микрофон 2.

Ч.Чимгэрэл: Амтны хувьд жимс, самар, шоколадны амттай 77 хувийг эзэлж байна. Гааны амттай 10 хувийг эзэлж байна. Ундаа, сүү, дарсны амттай 6 хувь, тамхины амттай 6 хувийн ийм статистик мэдээлэл байна.

Б.Найдалаа: Баярлалаа. Ганхүлэг гишүүн тодруулж асууна.

М.Ганхүлэг: Судалгаа, тооцоололтой холбогдолтой нэмэлт мэдээлэл байвал бас гишүүдэд өгөх нь зөв байх гэж бодож байна. Түүнийг бас шийдвэр гаргахдаа бас анхаарах байх. Зөөлөн аргаар тэмцдэг ч байдаг юм уу тийм туршлагууд юу байх вэ гэдэг дээр бас нэмэлт хариулт өгөхийг хүсэж байна. Татвар нэмэгдүүлэхийн эерэг, сөрөг 2 үр дүнгүүд гарна. Ялангуяа эерэг үр дүнгүүд дээр тодорхой хэмжээнд хэр их хэмжээний бас хуримтлалууд бий болох вэ? Түүгээр бид бүхэн бас ямар өөрчлөлтүүдийг хийж болох вэ гэдэг дээрээ илүү дэлгэрүүлээд бас мэдээллийг авъя. Ялангуяа тодорхой үе шаттайгаар нэмэгдүүлсэн энэ хувийг жил болгон хэдээр өснө гэж тооцож байгаа вэ? Тэр цугласан тодорхой мөнгийг бид нар яг юу юунд зарцуулах вэ гэдгийг бас нэмж тодруулъя.

Б.Найдалаа: Микрофон 3 Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Тэгээд бид нар тамхидалтыг бууруулж нийгмийн эрүүл мэндийг хамгаалахыг зөвхөн мэдээж хууль гаргаад, зохицуулалт хийгээд, татвар гаргах, нэмэгдүүлснээр хангана гэж үзэхгүй байгаа. Мэдээж хэрэгжилтийг хангах дээр маш анхаарна. Дээр нь Монгол Улс Тамхины хяналтын суурь конвенцод нэгдэж орсон анх нэгдэж орсон улсуудын л нэг. Тэгээд суурь конвенцоос бид нарт Монгол Улсад 4 жил тутамдаа зөвлөмж өгдөг. Энэ зөвлөмждөө Монгол Улс юун дээрээ алдаад байна гэдэг дээр 2 юман дээр л их анхаараарай гэдэг юм.

Нэгдүгээрт энэ та бүхэн соён гэгээрүүлэх ажлаа ерөөсөө мартсан байна. Олон нийтийн телевизээр чинь тамхины хор хөнөөлтэй холбоотой ямар ч контент, мэдээлэл өгөхгүй байна. Иргэдээ мэдээлэлжүүлэхгүй байна.

Хоёрдугаарт нийгмийн эрүүл мэндээ хамгаалах татварын бодлогыг та бүхэн ерөөсөө орхигдуулсан байна гэдэг энэ л юм. Тэгэхээр манай хуулийн төсөлд бас бид энэ зөвлөмжүүдийг аваад боловсролын байгууллага ЕБС-д эрүүл мэндийн боловсролын хичээлийг ордог болъё. Үүгээрээ хүүхэд, залуучууддаа хоол, хүнсний шим тэжээл архи, тамхины хор хөнөөлийг багаас нь.../минут дуусав./

Б.Найдалаа: Гүйцээж хариулъя.

О.Номинчимэг: Соён гэгээрүүлэх ажлыг хийж байж, мөн Дагаж мөрдөх журмын тухай хуульд бас энэ кампанит ажлуудыг Эрүүл мэндийн яам, Боловсролын яам маань хамтарч хийхээр тусгасан байгаа. Ингэж хаа хаанаа олон нийтийнхээ санаа бодолд нь энийг оруулж өгч байж бид нар илүү үр дүнг харна гэж бодож байгаа юм.

Татвар дээр бид мэдээж энэ төсөв бүрдүүлэх гэх зорилготой татвар ерөөсөө биш. Ийм зорилго ерөөсөө агуулаагүй. Энэ бол онцгой албан татвар гэдэг ерөөсөө хэрэглээг бууруулах зориулалттай. Зарим улсад нүглийн татвар ч гэж хэлдэг. Тэгэхээр энэ татвараа бид нар ерөөсөө тамхины хор хөнөөлтэй тэмцэхэд л ашиглана гэж байгаа. Дан ялангуяа энэ хууль дээр бид 3 зүйлд яг энэ тусгайлан онцгой албан татварынхаа 50 хувийг зарцуулна гэж оруулсан.

Нэгдүгээрт, ЕБС-ийн хүүхдүүдийн үдийн хоолны шим тэжээлийг сайжруулахад. Одоо бол бид нар чинь бага ангийн хүүхдүүддээ үдийн хоол өгөөд дунд, ахлах ангийнхандаа өгч чадахгүй байгаа. Энийгээ бид нар анхаар ёстой.

Хоёрдугаарт, донтолтоос сэргийлэх хамгийн сайн арга зам бол ерөөсөө спорт гэдгийг дэлхийн улс орнууд турш.../минут дуусав./

Б.Найдалаа: Минут нэмье.

О.Номинчимэг: Донтолтоос сэргийлэх гол зүйл хүүхэд, өсвөр үеийнхний хувьд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх л энэ орчныг бүрдүүлэх ёстой. Бид сүүлийн энэ 30 жилд хүүхдүүдийнхээ сургуулийн заалыг нь, газрыг нь авлаа, хүүхдийн тоглоомын талбайг нь авлаа чөлөөт цагаа өнгөрүүлэх үнэхээр хүртээмжтэй газар нөхцөл муу байна.

Тэгэхээр яг энэ тамхинаас орж ирж байгаа татвараа спортын дугуйлан секцийн хүртээмж, спортын барилга байгууламжийн хүртээмжид зарцуулъя гэж байгаа.

Гуравдугаарт, манай эрүүл мэндийн салбарынхны санал байгаа. Энэ бол тамхины бүтээгдэхүүн ихсээд тамхидалт ихсээд байгаа боловч тамхидалтаас гарах, тамхидалтыг бууруулах энэ арга хэмжээн дээр төрийн бодлого ерөөсөө явахгүй байна. Тэгэхээр тамхинаас гарах энэ нотолгоонд суурилсан эмчилгээ, үйлчилгээнд энэ татварын хэмжээнээс, бас орсон орлогоос зарцуулъя гэсэн ийм 3 зорилтот хүрээнд л бид энэ татварыг зарцуулна гэсэн үзэл баримтлалтайгаар хуулийн төсөлдөө тусгасан байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Ганхүлэг гишүүн нэмж тодруулах уу? Сөрөг юм байгаа юу? Асуулт дутуу байгаа юм байна. Микрофон 1 дээр. Микрофон 1-ийг нээе.

Т.Баасанжав: Товчхон хариулчихъя. Ер нь архаг тамхичид маань 18 нас хүртлээ нийт тамхичдын 90 хувь нь тамхинд орсон байдаг. 25 нас хүртлээ нийт тамхичдын 99 хувь нь тамхинд орсон байдаг. Тэгэхлээр тамхидалтыг бууруулна гэдэг бол хүүхэд, залуучууд руу хандсан бодлого юу гэдэг юм тамхинд оруулахгүй байх гэдэг бодлого хамгийн зөв бодлого байгаад байгаа юм. Эдгээр хүмүүст маань та бүхэн татварын аргаар, эдийн засгийн аргаар хөшүүрэг өгөх нь хамгийн үр нөлөөтэй байдаг. Яагаад вэ гэхлээр тамхины өөрийнх нь үнийн мэдрэмж -0.4-өөс -0.6 буюу ойролцоогоор үнэ 10 хувиар өсөхөд хэрэглээ маань 4 хувиар буурч байдаг гэсэн тоон судалгаанууд байдаг. Энэ утгаараа татвар нэмэгдэх маань худалдан авалт, эргээд хүүхэд, залуучууд маань энэ тамхидалтад өртөх хандлага нь буурч байдаг.

Дээр нь хүүхэд залуучуудын хувьд нөгөө орлого гэдэг зүйл маань бага учраас, байхгүй учраас үнэ.../минут дуусав./

Б.Найдалаа: Гүйцээж хариулъя. Та бас нэрээ хэлээд тэмдэглэлд үлдээгээдхээрэй.

Т.Баасанжав: Тэгье. Баасанжав эдийн засагч байгаа. Үнэд хүүхэд, залуучууд хамгийн мэдрэг байдаг. Тэгэхлээр энэ тавигдаж байгаа татвар маань тамхидалтыг бууруулахад маш өндөр нөлөөтэй.

Сөрөг талууд юу байна татвар тавихаар сөрөг талууд юу байна гэж асууж байна. Манай улсын хувьд тамхины үнэ хөрш орнуудаасаа 2,3 дахин хямд тамхитай гэдгийг дээр дурдсан. Өөрөөр хэлбэл контрабанд ч гэдэг юм уу ха хөрш

зэргэлдээ орнуудаас оруулж ирж дамлан зарах ч гэдэг юм уу энэ төрлийн эрсдэл харьцангуй бага. Татварын хэмжээ маань болохоор хүмүүс бас хэлээд байна, 2000, 4000, 6000 гээд ингээд үе шаттай нэмэгдээд яваад байна. Энэ тооцооллууд маань түрүүнд ДЭМБ-ын мэргэжил маань хэлсэн 75 хувь гэдэг нь нийт жижиглэнгээр борлуулагдаж байгаа үнийнхээ 75 хувьд хүрэх зорилго тавиад ингээд яваад үе шаттай нэмэгдүүлээд яваад байгаа юм. Дээр нь та бүхэн анзаараарай 30 онд 10000 гээд 10000 төгрөгийн татвар тавигдана гэдэг маань 30 онд инфляц маань хэд хүрэх билээ.../минут дуусав./

Б.Найдалаа: Ганхүлэг гишүүн та тодруулах уу? Асуултаа дахиж тодруулж асуух уу болох уу? Дараагийн гишүүн Мөнхсайхан гишүүн асуулт асууна.

Т.Мөнхсайхан: Тамхины хяналтын тухай хуулийг 2 гараа өргөөд дэмжиж байгаа. Ялангуяа энэ хуулийг авч явж байгаа, батлуулахаар явж байгаа гишүүдийн эсрэг энэ тамхи үйлдвэрлэгч, импортлогч нар маш их акц ингэж хийж зохион байгуулалттайгаар бас харлуулах ийм ажлыг хийсээр ирсэн. Тэгээд энийг бас даван гарч энэ хуулийг үүгээр өргөн барьж байгаа Номинчимэг гишүүнд үнэхээр баярлаж байгаагаа илэрхийлэхийг хүсэж байна.

Манай улсад тамхидалт жил ирэх тусам нэмэгдэж байгаа. Сүүлийн 5 жилийн байдлаар эмэгтэйчүүдийн тамхидалт 6 дахин нэмэгдчихсэн. Тамхи татах нас 3-аар залуужсан. 18 байсан бол 15 болсон. Энэ манай улсын үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулах хэмжээний ийм тоо баримт. Тэгэхээр энийг бид нар бууруулах бодлогоо маш сайн хийж хэрэгжүүлэх, энэ хуулиа цаашдаа маш сайн шаардлагатай зүйл, заалтуудыг бас оруулах ийм шаардлагатай гэж үзэж байгаа.

Тэгээд янжуур тамхи ч бай, электрон тамхи ч бай аль алины хэрэглээг бууруулах ёстой, аль аль нь хүний эрүүл мэндэд хортой. Ганц жишээ хэлэхэд манай улсад хорт хавдар тохиолдол их өндөр байна гэж байгаа. Энэний 3 тохиолдол тутмын 1 нь тамхины шалтгаантай байгаа. Тийм учраас бид нар энэ тамхидалтын эсрэг маш том бодлогын арга хэмжээ зөвхөн хууль өөрчлөөд зогсохгүй бусад төрлийн арга хэмжээнүүдийг бас авах ёстой. Тэгээд гадуур энэ Тамхины хяналтын тухай хууль дээр 2, 3 ийм сөрөг асуудлыг хөндөж энэ сошиалаар бас явуулаад байгаа.

Нэгдүгээрт тэгэхээр энэ янжуур тамхийг дэмжсэн ийм лобби явж байна. Электрон тамхинд ноогдуулж байгаа татварыг дэндүү ихээр нэмэгдүүлж байна гэдэг ийм хандлагыг явуулаад байгаа юм. Тэгэхээр яг энэ хоёрынхоо хоорондын татварын ялгаа нь юутай уялдаж, яаж тавигдсан байгаа юм бэ гэдэг энэ зүйлээ та хэд маань сайхан тодорхой хэлээд өгчих.

Хоёрдугаар ярьж байгаа зүйл бол ингээд татварыг нь нэмэгдүүллээ, үнийг нь нэмэгдүүллээ, энэ худалдаа, бизнес нь далд хэлбэрт орох юм биш үү гэдэг ийм асуудал ярьж байгаа. Тэгэхээр энэ далд хэлбэр лүү оруулахгүй байхын тулд энэ тамхины бизнест тавих хяналтыг, энэ хэрэглээг багасгахад тавигдах хяналтаа яаж сайжруулж байгаа юм бэ гэдэг энэ зүйл, заалтуудаа та хэд маань бас тодорхой хэлээд өгчих.

Гуравдугаарт энэ тамхины татвараас орж ирж байгаа ялангуяа энэ нэмэгдэл дээр үүсэж байгаа энэ татвараас орж ирж байгаа санхүү мөнгийг их олон янзын зүйлд нэмж дурдаад заагаад зарцуулна гээд явчихаар жоохон тунхгийн шинж

шинж чанартай болчих гээд байдаг. Тийм учраас энэ орж ирж байгаа нэмэгдэж байгаа татварын ,энэ онцгой албан татварын энэ 50 хувийг энэ гол 1 минутаа нэмээд авчихъя.

Б.Найдалаа: 1 минут нэмье. Мөнхсайхан гишүүнд 1 минут.

Т.Мөнхсайхан: Тэгэхээр олон зүйлд ингээд зарцуулна гэдэг байдлаар биш гол энэ тамхидалт чинь ард иргэдийн эрүүл мэндэд маш их сөрөг нөлөөлөл авчирч байгаа учраас энэ цугларч байгаа энэ онцгой албан татварын 50 хувийг Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлнэ гэдэг юм уу ийм тодорхой зүйл, заалтуудыг оруулаад өгчих юм бол энэ маань эргээд энэ иргэдийн эрүүл мэндэд нь зарцуулаад явагдах ийм боломж бүрддэг юм байна лээ. Энийг бас энэ Архины тухай хууль дээр нэлээн ажиллаж энэ нэлээн өөрчлөлтүүдийг хийж үр дүнгээ авсан хүний хувьд миний хувьд бас энэ үр дүнгүүдийг нь маш сайн мэдэж байгаа. Энэ Архидалтын эсрэг санд төвлөрсөн мөнгө маань төдийлөн зөв зүйлд зарцуулагдахгүй өнөөдрийг хүртэл мөнгө нь байж байгаа ийм асуудал байгаа. Тэгэхээр энийг яг эрүүл мэндийн аль санд яаж төвлөрөх вэ гэдэг зүйл заалтаа оруулсан уу? Энийгээ та хэд маань бас тодорхой энэ 3 зүйл дээр хариулаад өг өө.

Б.Найдалаа: Баярлалаа. 3 асуулт Номинчимэг гишүүнээс эхэлнэ. Микрофон 3.

О.Номинчимэг: Мөнхсайхан гишүүнд маш их баярлалаа. Бас сайд байх хугацаандаа энэ ажлын хэсгийг дэмжиж хамтарч ажиллаж бодлогын дэмжлэг үзүүлж байсанд бас танд хувь гишүүний өмнөөс талархал илэрхийлье. Энэ хуулийг яах вэ ажлын хэсгийн ахлагч болоод авч явснаас хойш ер нь янз бүрийн л байдлаар мушгин гуйвуулж байгаа. Тэгээд энэ хуулийн зорилт бол ерөөсөө түрүүн хэлсэн бүх төрлийн тамхин бүтээгдэхүүний хэрэглээг бууруулна. Ялангуяа хүүхэд, өсвөр насныхаа хэрэглээг бууруулах, оруулахгүй байх ийм талын арга хэмжээн дээр голчилно гэсэн байгаа юм.

Тэгэхээр энэ электрон тамхитай холбоотой ямар ч хуулийн зохицуулалтгүй байсан, задгай байсан энэ асуудлыг бусад тамхитай адилхан тамхин бүтээгдэхүүн гэж үзье гээд хуулийн зохицуулалт нэгдүгээрт ижил түвшинд очиж байгаа. Янжуур тамхи нь байна уу, бусад тамхи нь байна уу яг ижил түвшинд. Энд ялгаатай зохицуулж байгаа юм юу ч байхгүй. Үнэр, амтыг хорих дээр ч гэсэн янжуур тамхин дээр, электрон тамхин дээр адилхан зохицуулалтууд байгаа. Электрон тамхины хувьд, янжуур тамхины хувьд татварын тооцоолол хийгээд, электрон тамхины хувьд бас бид нар татварын тооцоолол хийгээд Засгийн газраас санал авсан юм.

Тэгээд Засгийн газраас ирсэн, Сангийн яамнаас ирсэн санал дээр ер нь бүхэлд нь үзэх юм бол та бүхэн шингэн тамхины буюу электрон тамхин дээр илүү бага татвар тавьсан байна. Энийг ямар хэмжээсээр тавьж байгаа дээр тодорхой болгож дахин тооцоолол хийе гэдэг саналыг өгсөн. 7 сар, 8 сард ирсэн саналдаа. Тэгээд энэ дээр манай ДЭМБ, эдийн засагч нар, Сангийн яамныхан маань бас хамтарч сууж байгаад тооцооллыг гаргасан байгаа. Ерөөсөө энэ дээр барьцах юм байхгүй яг л ижил түвшинд дүйцүүлэх байдлаар тооцъё гэдгийг. Энэ дээр ДЭМБ-аас дахиж, эсвэл эдийн засагч нараас нэмэлт хариулт өгөх байх гэж бодож байна.

Хоёрдугаарт, далд хэлбэрт орох вий гэдэг болгоомжлол. Энийг бас бид нар мэдээж хууль боловсруулаад хэрэгжилтийг нь хангах тал дээр анхаарч байгаа хүмүүсийн хувьд харж байгаа. Ялангуяа энэ дээр бас сайн жишиг байна. Бид нар

Архидан согтууралтай тэмцэх тухай хууль, Архины эргэлтэд хяналт тавих тухай хуулийг 2022 онд батлаад мэдээллийн сантай, хяналтын мэдээллийн сантай болсон. Энэ маань өөрөө энэ онцгой албан татвар төлдөг бүтээгдэхүүн үйлдвэрлэгч хаана үйлдвэрлээд, хэн оруулж ирээд, хаана зарж байна гэдэг нь бүгд дахин давтагдашгүй QR кодтой ийм мэдээллийн сантай болсон. Энийг тамхин дээр бас авч хэрэгжүүлбэ. Бүх төрлийн тамхин бүтээгдэхүүн онцгой албан татвар төлдөг болно. Энийг тэгэхээр бид нар бид нар импортлогч улс шүү дээ. Тэгэхээр тэр үйлдвэрлэгчтэй нь манай гааль, татварын байгууллагуудаас хяналтаа тавьж, энэ асуудлаар холбогдож, ийм байдлаар хууль бус тамхи байдаг юм уу далд асуудал руу шилжүүлэхгүй байдлаар бид энэ зохицуулалтыг хийсэн байгаа. Ер нь энэ тамхины хууль ярихаар үе үеийн байдал контрабанд ихэссэн ч байдаг юм уу, далд хэлбэр рүү ихэснэ гэдэг ийм айлгах тактик их явдаг байсан юм байна лээ. 2013 онд Эрдэнэчимэг гишүүнийг Тамхины хяналтын хуулийг ахлаад явж байхад баар, цэнгээний газруудад тамхи татахаа болино, дотор орчин татахаа болино гэхэд нь манай тэгвэл орлого буураад бид нар дампуурахад хүрнэ шүү дээ гэж жагсаж айлгаж байсан ч юм байна. 12 жилийн дараа бид нар бодит нөхцөл байдлыг харахаар тийм юм байхгүй. Бид нар судалгаа, тооцоололтой бүгдийг нь ингэж оруулж ирж байгаа гэдгийг хэлмээр байна.

Гуравдугаарт, Эрүүл мэндийн даатгалын сантай тэр татварыг зарцуулах тал дээр тантай санал нэг байна. Бид нар одоогийн төсөлдөө эрүүл мэндийг дэмжих санд энэ мөнгийг төвлөрүүлнэ. Нийт төсөв рүү оруулаад аль нэгэн сумын барилга ч байдаг юм уу, аль нэгэн төрийн байгууллагын байр болоод, тоног төхөөрөмж болоод зарцуулагдахгүй энэ өөрөө эргээд тамхитайгаа тэмцэх, тамхины хор хөнөөл, эсвэл тэр уг угшилтай нь тэмцэх юманд зарцуулагдах ёстой гэсэн байдлаар хуульчилсан байгаа. Тэгээд энэ дээр манай хамтарч санаачилсан дэмжсэн гишүүд бас олон санал гаргаж байгаа. Энийгээ бид нар бас хэлэлцүүлгийн явцад сайхан хэлэлцээд ажлын хэсэг дээрээ эд нарыгаа оруулаад, яаж зөв зохистой байдлаар энийг оруулж зарцуулбал илүү үр дүн гарах вэ гэдэг дээр та бүхний саналыг бас нарийвчилж тусгаад явахад бэлэн байна. Түрүүн хэлсэн ер нь спорт, хүүхдийн шим тэжээл, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд ингээд зарцуулъя гэсэн юманд манай хуулийн төсөл орж ирсэн байгаа.

Б.Найдалаа: Нэмж тодруулж хариулах нь микрофон 1 үү? Нэрээ хэлээрэй.

С.Болормаа: ДЭМБ-ын мэргэжилтэн Болормаа. Энэ янжуур тамхины татварыг электрон тамхины татвартай яаж дүйцүүлсэн юм бэ гэж асуусан. Энэ дээр улс орнууд янз бүрээр тооцоолдог. Олон улсын сайн жишиг болохоор электрон тамхины шингэнд нь ерөнхийдөө дүйцүүлж тооцдог. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр 1 хайрцаг буюу 20 ширхэг янжуур тамхи тухайлбал 1мл электрон тамхины шингэнтэй тэнцэх, зарим улс тухайлбал, Английн жишээ 1мл электрон тамхины шингэн 10 ширхэг янжуур тамхитай тэнцэх гэсэн байдлаар ингэж дүйцүүлж тооцсон байдаг. Энэ жишгийг бид тооцооллынхоо хувьд авсан. Тэгээд одоогоор электрон тамхи онцгой албан татвар байхгүй байгаа. Ингээд 26 оноос 1мл электрон тамхины шингэ ингээд энэ дүйцүүлснээр тооцохоор 1000 төгрөг. Ирэх жилүүдэд 2000, 3000, 4000, 2030 он гэхэд 5000 болохоор ийм тооцоолол хийсэн байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа Мөнхсайхан гишүүн тодруулж асууя.

Т.Мөнхсайхан: Та хэд маань тэр Эрүүл мэндээ дэмжих сан биш Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэх үр өгөөж нь илүү их өндөр байх тал дээр

бас цаашид анхаарч үзээрэй. Тэгээд энэ Эрүүл мэндийн яамны газрын дарга нар бас байна. Энэ эрүүл мэндийн сайд маань өөрөө ямар байр суурьтай байгаа юм бол доо. Тэр Олон улсын тамхины эсрэг конвенцын олон улсын хурал дээр Эрүүл мэндийн сайдын зөвлөх гэж нөхөр тэр ярьж байгаа мэдээлэл, мэдэгдэл өгч байгаа зүйл дээр энэ тамхины хэрэглээг дэмжих талын юм яриад байна лээ шүү дээ. Ялангуяа энэ электрон тамхийг дэмжих юм яриад тийм мэдээллүүд өгөөд байгаа. Тэгэхээр энэ дээр Эрүүл мэндийн сайд нь энэ тамхиныхаа хэрэглээг бууруулах энэ хуулиа дэмжиж байгаа юу энэ тал дээр маш сайн тайлбар тодруулга юмаа өгөх нь зөв байх шүү гэж бодож байгаа юм. Баярлалаа.

Б.Найдалаа: Эрүүл мэндийн яамнаас та энэ хариу хариулт өгөх үү? Яг ямар байр суурьд яаж дэмжиж байгаа? Микрофон 6.

Б.Цэцэгсайхан: Сайхан сайдын асуултад хариулъя. Тэгэхээр өнгөрсөн 7 хоногт ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцын 11 дэх удаагийн хурал болсон. Энэ хуралд Эрүүл мэндийн яамнаас Эрүүл мэндийн сайдын албан ёсны бус зөвлөх оролцсон. Энэ хүний ярьсан зүйл манай Эрүүл мэндийн яамны байр суурь биш Эрүүл мэндийн сайд, Эрүүл мэндийн яамны зүгээс Тамхины хяналтын хуулийг бүрэн дэмжиж байгаа бүх Тамхины хяналтын суурь конвенцыг ч гэсэн бүгдийг нь дэмжих байр суурьтай байгаа. Тэгэхээр энэ бол Засгийн газрын байр суурь биш байсан.

Б.Найдалаа: Баярлалаа. Тодруулаад болчихсон уу Мөнхсайхан гишүүн? Одоо Ганбаатар гишүүн асуулт асууна. Дараа нь Эрдэнэбат гишүүн.

А.Ганбаатар: Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гээд хуулийн төслийг манай Ардчилсан намын бүлэг дээр орж ирж байхад нь байр сууриа бас илэрхийлж байсан. Ер нь яах вэ манай бүлэг дээр өчигдөр бас манай судлаач нар энэ талаар хэлэлцсэн. Ардчилсан нам баруун төвийн үзэл баримтлалтай нам учраас бизнесийнхэндээ ээлтэй байх үүднээс энэ татварыг огцом нэмэх, бизнесийнхэндээ татварын ээлтэй бодлого байх ёстой гэдэг байр суурь дээр байж байгаа. Энэ хуулийг бүхэлд нь дэмжиж байгаа. Номинчимэг гишүүнийг шүтэн биширч байна. Ийм галтай хуулийг аваад ингээд орно гэдэг сайн. Гэхдээ хэд хэдэн асуудлыг заавал хэлэх ёстой хэдэн юм байна. Яагаад гэвэл хууль сайн байлгах үүднээсээ тэгээд эргэн тойрноо хардахаас илүүтэйгээр энэ зүйл, заалт дээр анхаарах ёстой шүү дээ ажлын хэсэг.

Тэгэхээр татварын асуудал байгаа юм. 26 онд 50 хувь ингээд цаашаа нь ингээд ингээд нэмээд явчхаж байгаа юм. Тэгэхээр ингээд татвар огцом нэмэхээр тухайн бизнес эрхэлж байгаа, тамхи оруулж ирж байгаа компаниуд чинь бэлтгэлтэй байгаа юм уу? Нэг. Үүнээс гарах сөрөг нөлөө гэж байж болох уу? Өөрөөр хэлбэл, Сухой законы үед бид нар хуурай хууль гэж ярьдаг шүү дээ. Энэ шиг сөрөг эффект гарах уу? Зарим судлаач нар нь бизнес эрхлэгч чинь ийм нөлөө гарна гэж хэлээд байна л даа. Яагаад гэвэл татвар өндөр болчихоор жинхэнэ тамхиа татахаар тэр чинь маш өндөр татвартай болчхож байгаа учраас тамхи орлуулагч, хуурамч тамхи гэдэг юм уу улам хортой тийм тамхинуудыг гаалиар оруулж ирэх магадлалтай байхгүй юу. Гаалийнхантайгаа бас янз бүрийн сүлжээнд орчихсон байна. Ил биш, далд биш ил шүү дээ энэ бол.

Тэгэхээр энэ дээр хариулж өгөөч гээд. Тухайлбал, Киргиз, Казахстан эд нарт 23-аас 27 ондоо 8-хан хувиар нэмж байна. Казахстанууд 6-аас 10-хан хувиар ингээд нэмээд явж болж байна гэсэн жишээ харагдаж байна. Дахиад энэ хууль

дээр ахиад шүүмжлэлтэй тэр жижиглэнгийн эрхлэгчид, энэ тамхи худалдаалж байгаа хүмүүс нь хэлээд байгаа нэг саналыг заавал харах ёстой. Энэ танхим дээр гарсан ярианаас би үндэслэж яриад байгаа шүү. Төхөөрөмж вейп/vape/ дээр өөрөөр хэлбэл энэ төхөөрөмж дээр нь татвар тавиад байхгүй юу. Никотин дээр нь биш төхөөрөмж дээр нь. Тэгвэл бид нар үнсэн тамхийг гаансаар татдаг юм чинь гаанс дээр татвар тавих юм уу? Энийг хариулаад өгчихмөөр байгаа юм. Гаан дээр асуудал яригдаад байна 6.7.16 дээр өөрөөр хэлбэл гаа нь үлдээд бусад энэ амт, үнэрийг нь аваад хаячихсан юм байна л даа.

Тэгэхээрээ энэ вейп зарж байгаа хүмүүс нь вейп тамхи амт, үнэргүй тамхи биш болчхож байгаа юм байна л даа. Зүгээр энэ агаар сороод байгаа юм уу хаашаа юм. Тэгэхээр энийг хорьж байна гэж ойлголт нийгэмд гараад байх шиг байгаа юм. Миний байр суурь бол олон хүмүүс судалгаагаар хэлээд байгаа нэг зүйл бол, эсвэл бүгдийг нь хорих хэрэгтэй. Гааг нь ч хорих хэрэгтэй. Тэр амт, үнэрийг нь ч хорих хэрэгтэй. Эсвэл аль алийг нь тавиад татвараа тавих ёстой. Энийг янзалж өгөхгүй байна л даа. Яагаад та нар тамхи татдаггүй вэ гэдэг хүмүүсийн 57 хувь, 1 минутаа авчихъя дарга. 57 хувь нь муухай үнэртэй учраас гэж хариулсан байна лээ.

Б.Найдалаа: Минут нэмж өгье.

А.Ганбаатар: Тамхи татдаггүй хүмүүсийн 57 хувь нь муухай үнэртэй учраас гэсэн байгаа байхгүй юу. Тэгэх юм тэр гааг нь, амт, үнэрийг нь аль алийг нь ав л даа. Гааг нь үлдээхээр таныг чинь тэр янз бүрийн компанийн лобби хийж байна гэж яриад байгаа нь тэр хардалтаас чинь болоод байхгүй юу. Тэгэхээр энийг эсвэл хоёуланг нь тавих, эсвэл хоёуланг нь болих ийм асуудал байгаа юм.

4 дэх асуудал нь Парламентын судалгаа хөгжлийн хүрээлэнгээс хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн чинь 500 метр орчимд тамхи зарахгүй байх чинь 83.3 хувь зөрчигдөөд байна. Энэ хууль хэрэгжихгүй байна гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр минийхээр энэ тойрогтоо биш хэнд зарах вэ, зарахгүйдээ чухал байхгүй юу. 21 наснаас доош юм уу, 17 наснаас доош юм уу тэр өсвөр үс үеийнхэн очиж тамхи аваад байгаа бол камераар бичих бичлэг нь хэдэн цаг минут байх юм, ID-г нь яаж шалгах юм? GS, CU эд нар болдог гэж байна лээ шүү дээ. Ийм асуултууд байна.

Б.Найдалаа: 3 асуулт байна. Номинчимэг гишүүнээс эхэлье. Микрофон 3.

О.Номинчимэг: Ганбаатар гишүүний асуултад хариулъя 4 асуулт асуулаа. 2-т нь хариулаад татвартай холбоотой асуудлуудыг манай мэргэжлийн ажлын хэсгээс хариулах байх гэж бодож байна. Ганбаатар гишүүн энэ 500 метртэй холбоотой асуудлыг хөндлөө. Бид нар бас судалгаа хийгээд өөрсдөө ч гэсэн нийслэлээс нийслэлийн хэмжээнд ямар байна гээд бүх цэгүүдээ хатгуулж байгаад ингээд үзсэн. Нийслэл Улаанбаатар хотын хувьд мэдээж ийм хот төлөвлөлт, хүн амын байдалтай холбоотойгоор хотын төвөөр мэдээ дээж нь 500 метртэй холбоотой тойрог зураад үзэх юм бол их цөөхөн газар ингээд байж байгаа юм. Энэ хотоос зайдуу гараад ирэх юм бол Хан-Уул дүүрэг, Сонгино, Чингэлтэй ингээд харах юм бол бас зөндөө байна. Энэ дээрээ мэдээж хуулийн хэрэгжилт дээр анхаарах юм байгаа дээр үнэхээр санал нэг байгаа. Бид нар хуулиа хэрэгжүүлнэ. Гэхдээ яах вэ энэ удаагийн бидний хуулийн үзэл баримтлал хүүхэд, өсвөр үеийнхнийгээ хамгаалах, хүүхэд өсвөр үеийнхнийгээ тамхины энэ хүртээмжээс

хамгаалах асуудал ерөөсөө ойр орчин тойронд нь хүүхэд их байдаг газар тамхиа татахгүй, тамхиа зардаггүй л байх асуудал байгаад байгаа юм.

Нөгөө талаараа бид нар бас хуулиа хэрэгжүүлэх асуудал дээр илүү сайн анхаармаар юм шиг байгаа юм. Хууль хэрэгжихгүй байлаа гээд хуулиа сулруулдаг логик руу бид нар явж болохгүй. Хэрвээ ингэх юм бол хар тамхийг бид нар хориглочихсон байгаа. Гэхдээ Монгол Улсад хар тамхины хэрэглээ өсөж байна гэдэг бид нарын сэтгэлд эмзэглүүлсэн юм байгаа юм. Тэгээд хэрэгжихгүй байгаа юм чинь яах юм бэ гаалиар оруулж ирдэг болъё гэдэг логик руу бид нар явахгүйн тулд эхний ээлжид бид нар хэрэгжилт дээр бас анхаарах ёстой гэдэг асуудлыг байгаа. Гэхдээ энэ дээр бас манай гишүүд яаж энийг сайжруулах вэ, яаж хэрэгжилтийг хангах вэ гэдэг дээр олон сайн санаачилгуудыг гаргаж байгаа учраас хэлэлцүүлгийн явцад тусгаад явахад бүрэн нээлттэй байгаа гэдгийг хэлье.

Гааны асуудал байна. Энэ хуулийг бид нар анх бас боловсруулахдаа бүх төрлийн амтыг нь хорихоор оруулсан. Манай ажлын хэсэгт байгаа эрүүл мэндийн судлаачид, бодлогын ажилчид, миний хувьд ч гэсэн энэ асуудлыг нь хорих нь ёстой. Таны яг хэлж байгаа шиг гаар дамжуулж тамхинд шинээр орох асуудал дэлхий даяанаа угаасаа их байдаг. Дэлхийн 36 улс гаатай тамхийг хориглосон ийм юм байгаа юм байна лээ. Гэтэл би яах вэ энэ асуудлыг та бас хэллээ галтай асуудал гээд. Олон гишүүдийнхээ дэмжлэгийг авахыг хүссэн. Ингэж байж энийг явуулна гэж үзсэн. 78 гишүүнтэйгээ бид нар санал бодлыг нь сонссон. Энэ дээр үнэхээр хэрэглээнд их нэвтэрчихсэн энэ гаатай тамхины асуудал уу яах вэ гэдэг дээр бас нэг талын байр суурь шууд баримтлах боломжгүй байсан учраас ингэж орж ирж байгаа. Гэхдээ хэлэлцүүлгийн явцад энэ манай гишүүд санал гаргаад гааг хасна гэх юм бол бид нарын мэргэжлийн ажлын дэд хэсгийн зүгээс дэмжихэд бэлэн байгаа гэдгийг бас хэлмээр байна.

Татвар, төхөөрөмжийн татвар болон хуурамч тамхитай холбоотой асуудлыг бас манай ажлын хэсгээс хариулах байх.

Б.Найдалаа: Микрофон 2.

О.Номинчимэг: Ер нь мэдээллийн сантай болсноор бид нар хуурамч тамхинаас сэргийлэх бас ийм арга хэмжээг хуулийн төсөлдөө тусгасан байгаа талаар түрүүн бас дурдсан байгаа.

Б.Найдалаа: Микрофон 2-ыг нээе.

С.Цэрэнчимэд: Гаалийн Төв Лабораторийн дарга Цэрэнчимэд. Би энэ төхөөрөмжтэй холбоотой талаар мэдээлэл өгөх гэсэн юм. Жоохон буруу ойлголттой яваад байх шиг байна. Тэгэхээр асаахгүйгээр сорж татах зориулалттай тамхи гэж энийг хэлдэг. Энэ маань дотроо энэ гадна талд нь биччихсэн байна энэ 3 хувийн никотин агуулсан 23, 25мл-тэй ийм никотин агуулсан дээрээ, дотроо пропленгликол, глицерин, амт оруулагч гэсэн ийм бодис агуулсан ийм нийлэг органик нэгдлүүдийг агуулсан ийм тамхи байгаа. Энийг өнөөдөр юу гэж бодож байгаа вэ гэхээр энэ чинь энэ дээрээ ч гэсэн биччихсэн байгаа, гадна талынх дээр нь энэ бүтээгдэхүүн бол никотин гэдэг юмыг агуулсан. Никотин бол химийн бодис юм гээд. Тэгэхээр нийлэгжүүлж гаргаж авсан химийн бодис, түүнтэй холбогдуулаад бусад органик уусгагчуудад агуулсан ийм юм байгаа шүү. Тэгэхээр энийг бид нар татвараа тавихдаа зөвхөн 30 хувийн татвартай буюу тавтай

тамхитай адилтгаж оруулж ирэхийн тулд бид нар өнөөдөр 30 хувийг нь.../минут дуусав./

Б.Найдалаа: Гүйцээж хариулъя. Микрофон 2.

С.Цэрэнчимэд: Урьд нь энэ тамхи маань юу гэж байсан гэхээр та бүхний хэлдгээр электрон тамхи гээд 85, 43 дугаар бүлэгт ордог байсан учраас хүмүүс ингээд буруу яриад байна. Тэгэхээр энэ маань өнөөдөр 24,04 гээд барааг тодорхойлох кодлох уялдуулсан систем гэдэг конвенц Монгол Улс 1991 онд орсон. 93 оноос хэрэгжүүлж байгаа. Үүнтэй холбогдуулаад дэлхийн гаалийн байгууллагаас ангиллын кодтой холбогдоод нэмэлт, өөрчлөлт орсон. Тэгэхээр 2022 онд тамхины бүтээгдэхүүний энэ хэрэгслийг 24,04 гэдэг ангилал руу буюу тамхин бүтээгдэхүүн гэдэг ангилал руу оруулсан шүү. Тэгэхээр энэ маань ингээд тамхин бүтээгдэхүүн гэж ангилагдаж байгаа учраас бид нар 30 хувийн татвар тавиад байгаа юм.

Таны яриад байсан түрүүний хэлээд байсан хэрэгсэл гэсэн тамхины татах хэрэгсэл гэдэг маань энэ. Энэ маань болохоор халаах хэрэгсэл гэж явдаг. Тамхи нь тусгайдаа 24,04 гэдэг ангиллаар орж ирдэг. Тамхины энэ халаах хэрэгсэл нь 85,43 гэсэн ангилалд ганцаарчилсан зориулалттай ийм цахилгаан хэрэгсэл гэж орж ирдэг юм. Энэ нь болохоор цахилгаанаар цэнэглэгддэг тамхиа энэ рүүгээ хийгээд ингээд татдаг ийм хэрэгсэл. Тэгэхээр энийг.../минут дуусав./

Б.Найдалаа: Гүйцээж хариулъя микрофон 2.

С.Цэрэнчимэд: Тэгэхээр тамхи нь тусгайдаа өөр ангилалтай, цахилгаан хэрэгсэл нь болохоор өөр ангилалтай орж ирж байгаа учраас энэ цахилгаан хэрэгсэл буюу төхөөрөмжийг нь бид нар 85,43 гэдэг ангилалд оруулаад цахилгаан хэрэгсэл гэдгээр нь тусгайд нь тавьсан. Энийг ганц удаагаа аваад хэчнээн ч тамхийг татах боломжтой учраас дахин дахин ашиглах боломжтой гэдгээр нь тоног төхөөрөмжийг нь оруулж ирсэн шүү гэж.

Дараачийн асуудал болохоор электрон тамхи энэ байна. Электрон тамхи гэдэг нь яаж байгаа вэ гэхээр цахилгаанаар ажилладаг. Батарейгаа хийлээ гарлаа. Энэ электрон тамхи. Энэ нь яадаг вэ гэхээр цахилгаанаар ажилладаг. Энэ нь яг адилхан энэ электрон никотин агуулсан шингэн бодистой энэ бодис нь болохоор 24,04 тамхин бүтээгдэхүүн гэдгээр ангилагдаж байгаа. Энэнтэйгээ нийлээд ороод ирэхээр болохоор цахилгаан тамхи болчхож байгаа. Энэ нь ганцаараа орж ирж байгаа тохиолдолд тамхины эд анги гэдгээр бас 85,43-аар батарей нь орж ирдэг.

Тэгэхээр ингээд тус тусдаа ангилалтай байгаа. Бид нар яг ангиллын кодыг нь Дэлхийн гаалийн байгууллагаас гаргасан 22 оны зөвлөмжийн дагуу ангилж байгаа шүү. Тэгэхээр урьд нь энэ бид нарын яриад байгаа юм бол тамхин бүтээгдэхүүн гэж электрон бараа гэдгээр ингээд хүмүүс андуурагдаж яриад байсан болохоор энэ маань 22 онд Дэлхийн гаалийн байгууллагаас тавьсан зөвлөмжийн дагуу Монгол улс гаалийн байгууллага энэ ангиллын кодоор оруулж ирж байгаа юм. Энэ дээр бас юуг хэлмээр байна гэхээр энэ дээр нь ингээд бичээстэй байгаа. Би түрүүн хэлсэн энэ химийн бодис шүү гээд. Дээрээс нь 21 наснаас дээш хүн хэрэглэнэ шүү гээд тавьчихсан байгаа. 3 процентын никотин агуулсан шүү гээд тавьчихсан байгаа.

Тэгвэл Монгол улсын стандартын дагуу MNS 5024 тамхи, тамхины бүтээгдэхүүн янжуур тамхины стандартаар болохоор 1 ширхэг тамхи маань хамгийн өндөртөө 1.3 миллиграмм ийм никотин агуулсан байна гэж байгаа. Тэгвэл энэ маань процентоор байгаа шүү. Тэгээд та хэд аль нь илүү их хортой вэ гэдгийг илүү харна. Тэгэхдээ бид нар янжуур тамхийг нь ч гэсэн электрон тамхийг нь

Б.Найдалаа: Ганбаатар гишүүн тодруулж асуугаад та хариулаарай.

А.Ганбаатар: Нарийн төвөгтэй асуудал учраас тодруулаад байгаа шүү. Уучлаарай би өөрөө тамхи татдаггүй байхгүй юу. Тэгээд таны хэлснээр бол энэ вейп юм чинь татвар авах юм байна. Өөрөө никотин агуулчихсан байна шүү дээ. Ойлголоо. И-кос билүү, янжуураа залгаж байгаад ингээд сорж байгаа. Наадхаас нь авах юм уу наад савнаас нь?

Б.Найдалаа: Ганбаатар гишүүн асуултаа асуучих уу? Тэгээд микрофондоо хариулахгүй бол.

А.Ганбаатар Тэр гаанс маанс нь ч ягшиг даа ерөнхийдөө ойлголоо. Баярлалаа.

Б.Найдалаа: Танд тодруулж хэлэх юм байсан уу? Сая яриад байсан уу үгүй юу? Микрофон 2 товч тодорхой хаагаад.

С.Цэрэнчимэд: Энэ маань үндсэндээ та бүхний яриад байгаагаар гаанс гэж ойлгож болно. Тамхи татах хэрэгсэл. Нөгөөдөх нь тамхи чинь бэлнээрээ энд байж байна. Тэгэхээр энэ тамхийг энэ рүү хийж л татдаг байхгүй юу. Энэ ингэж л хэрэглэх зориулалттай. Тэгэхээр тус тусдаа л дотроо авч болно.

Б.Найдалаа: Баярлалаа. Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

С.Эрдэнэбат: Тамхины тухай хуулийг дэмжиж байгаа бас хамтран санаачлагчийн нэг. Номинчимэг маань бас энэ галтай асуудлыг барьж авсан. Олон ч бас дайралт янз бүрийн лобби орох гэж оролдож байх шиг байна. Ер нь ний нуугүй хэлэхэд өмнө нь энэ Тамхины хууль дээр дандаа лобби орж байсан юм байна лээ. Янз бүрийн хүмүүсээр 1 хуулийн заалтыг хүртэл амлаж аваад гишүүдтэй ажилладаг. Тийм учраас бид нар энэ Тамхины хуулийг харин ч оройтож оруулж ирж энэ вейп гэдэг энэ электрон тамхи чинь орж ирээд үндсэндээ 2, 3 жил болчихлоо. Энэ хугацаанд хэчнээн ч хүүхдийн уушги, тамхи татах зуршил нэмэгдсэн бүү мэд. Тийм учраас энэ тодорхой бас ийм сонирхлын бүлэг байсан учраас энэ хууль ч гэсэн хойш байгаад байсан болов уу гэж бодож байна.

Хуультай холбоотойгоор хэд хэдэн зүйлийг бас тодруулж асуумаар байна. Түрүүн бас гишүүд асуулаа. Саяын таны тэр сурталчлаад байгаа тамхи чинь үндсэндээ зайрмаг шиг л харагдаж байна шүү дээ хүүхдүүдэд. Ямар ч гоё өнгөтэй юм, ямар ч гоё үнэртэй юм тээ? Тийм учраас энэ тамхин дээр байгаа энэ зүйлийн бусад янжуур тамхин дээр байдаг шиг тэр хавдар, өвчлөл гэдэг юмыг нь зургийг нь нааж өгөөч. Хүн харахад хамгийн муухай харагдахаар байх ёстой. Нэг.

Хоёрдугаарт, манай энэ инфлүенсерүүд олон нийтийнхэн үндсэндээ энэ залуу үеийг тэр тамхи татаж байгаагаараа тэр кино сурталчилгаа өөр юу байдаг юм олон нийтийн газар явж байгаагаараа маш их дагана. Үндсэндээ энийг вейп зуучихсан хүн бол их гоё гэдэг мэдрэмжийг 10 жилийн хүүхдүүд өгч байгаа юм.

Тийм учраас энийг нь сурталчлах ийм хортой юм шүү гэдэг юмыг нь яг үнэндээ эргээд бодоход нээрээ манай энэ олон нийтийн телевиз, радио, хэвлэл мэдээллээр тун цөөхөн гараад байгаа юм. Бараг битгий гаргаасай гэснийхээ төлөө магадгүй урамшуулал шагнал авдаг юм уу гэж хардахаар ийм л болчхож л дээ. Тийм учраас хууль дээр, дагах хууль дээр тэр өргөн нэвтрүүлэг болон тодорхой тэр сошиал түвшинд нийт нэвтрүүлгийнхээ хэдэн хувийг хийдэг юм энэ тамхины хор сурталчилгааг гаргаж өгнө өө гэдэг бүх нийтийн үүргийн үүргийг дагалдуулж заах нь зөв өө гэдэг ийм байр суурьтай байгаа.

Дээрээс нь манай цагдаагийнхан байгаа асуумаар байна. Сая 85 хувийн биелэлттэй гэж байна хүүхдийн орчинд тамхи татахгүй гээд зарахгүй гэдэг. Би саяын Ганбаатар гишүүнтэй бас яах вэ нэг талаар санал нэгтэй байгаа. Хөдөө орон нутгийн ихэнх дэлгүүрүүд манай 330 сумын, радиус чинь өөрөө сургуулийнхаа ойролцоо 500 метрийн радиуст байдаг.

Тэгэхээр үндсэндээ сумд тамхи зарахгүй гэдэг ийм болчхоод энэний өмнөх бас хууль л даа. Тэгэхээр яадаг вэ гэхээр үндсэндээ нууж зардаг. Нууж зарангуут нь яадаг вэ гэхээр цагдаагийнхан очиж торгодог л ийм болчхоод байгаа юм. Түүний оронд харин хүүхдэд зарсан байх юм бол маш өндөр хариуцлагатай шууд тэр тусгай зөвшөөрөл гэдэг юм уу, эрүүгийн хариуцлага байх хэмжээний юмнууд татаж авчрах ийм зохицуулалтыг нь уул нь оруулаад өгчихвөл яадаг юм бэ бас? Ийшээ орчихоор бас хүүхдүүдийн тамхи зар гэх гэж байна гэдэг байдлаар бас сөрөг бас юу руу орчих вий гэдэг болгоомжлол байгаа. Гэхдээ ийм хуурай байдлаар байж болохгүй. 1 минутаа нэмээд авчихъя. Тийм зүйлийг ер нь тусгаад өгчихвөл ялангуяа жижиг дэлгүүр эрхэлж байгаа, сум дээр байж байгаа хүмүүс ерөөсөө л цагдаагаас нууж юм зардаг. Тэгээд манай цагдаагийнхан ч тэгээд ямар хариуцлага тооцдог юм? Би мэдэхгүй байна. Ний нуугүй хэлэхэд жоохон хуурайдуу болчихсон.

Б.Найдалаа: Минут нэмж өгнө.

С.Эрдэнэбат: Тийм учраас нэгэнт энийг барьж явсных хэдүүлээ хэлэлцүүлгийн явцад ингээд оруулаад өгчихсөн нь бас яг энэ талаар хэлэлцүүлэг хийвэл яадаг юм гэж би бас би бодоод байгаа юм. Дээрээс нь Эрүүл мэндийн даатгалын сан руу оруулах уу юунд оруулах вэ? Одоо манай энэ цуглаж байгаа мөнгийг ер нь юунд зарцуулдаг юм бэ? Тамхи, архинаас орж ирж байгаа мөнгийг хүний эрүүл мэндийн юунд? Би сураг сонсох нь зарим нэгэн инфлүенсерүүд гэрээ байгуулаад телевизээр хааяа юм ярьдаг гэж сонсоод байсан.

Дээрээс нь энэ ДЭМБ-ынхан байх шиг байна. Яг энэ вейп гэдэг тамхи хүүхдийн уушги болон энэ татдаг хүмүүст яг ямар сөрөг нөлөөтэй вэ, эрүүл мэндийн баталгаажсан яг тийм судалгаа байна уу? Ялангуяа эмч нар компьютер томографаар үзүүлж байж л наад уушгины гэмтэлд юу чинь гардаг гэдэг ийм зүйлийг зарим эмч нар ярьдаг. Тэгэхээр энэ хүүхдүүдийг үндсэндээ компьютер томографт үндсэндээ үзүүлдэггүй шүү дээ. Тэгэхээр цаана нь асар их эрүүл мэндийн золиос яваад байгаа юм биш үү? Энэ дээр тандалт судалгаа байна уу гэдэг ийм асуултыг асуумаар байна.

Б.Найдалаа: Хариултыг микрофон 3. Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Бас манай хуулийг дэмжээд санал бодлоо хэлж байгаад маш их баярлалаа. Таны хэлсэн тэр

өвчлөлийн анхааруулга, хортой бүтээгдэхүүний анхааруулгыг бэл бид нар энэ бүх бүтээгдэхүүндээ оруулна. Тэгээд одоо бол янжуур тамхин дээр, дүнсэн тамхин дээр 50 хувьд нь, гадаргууных нь 50 хувь дээр анхааруулга байгаа. Энгийг 70 хувь болгож байгаа. Янжуур дээрээ ч адилхан, дүнсэн дээрээ ч адилхан, электрон тамхин дээрээ ч гэсэн хортой бүтээгдэхүүн бол хортой гэсэн энэ агуулгыг нь заавал оруулах ёстой. Америк эд нарт хортой гэж анхааруулаагүй учраас энэ чинь өөрөө хэрэглэгчдийн эрх ашгийн маргаан болоод явдаг.

Тэгэхээр хортой бүтээгдэхүүн бол хортой бүтээгдэхүүний агуулга, анхааруулга нь заавал байх ёстой гэсэн энэ шаардлагыг оруулж өгч байгаа. Тэгээд таны хэлж байгаа бас зөв. Энэ электрон тамхи, шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүн манай Монгол Улс бусад маш хурдацтайгаар өсөн нэмэгдсэний нэг гол шалтгаан нь ямар ч хуулийн зохицуулалт байхгүйгээс үүдээд цахим орчинд маш хүчтэй маркетинг сурталчилгаа их явсан байна лээ.

Тэгээд энэ талын судалгааг бас Сингапурын эрдэмтэд манай ажлын хэсэгт бас хийж өгсөн. ДЭМБ-аас хараад тэгээд Монгол Улсын хувьд үнэхээр агрессив/aggressive/ маркетинг буюу хүчтэй маркетингаар хүүхэд, залуучууд руу чиглэсэн тэд нарыг хардаг юу гэдэг тэр сувгуудаар гаргаж ийм байдлаар маш их нөлөөлсөн байна. Энэ дээр хууль, эрх зүйн зохицуулалтаа сайжруулах хэрэгтэй гэсэн зөвлөмж өгсөн. Тэгэхээр бид нар энэ тамхи гэдэг бүтээгдэхүүнд ороод зохицуулалтад орохоор уламжлалт тэр бусад тамхитай адилхан ийм ил задгай сурталчлах боломжгүй болсон гэдгийг бас хэлмээр байна.

Хүүхдэд ерөнхийдөө зарсан тохиолдолд энэ хүүхдэд зарахгүй байх асуудлаа бид нар бас үнэхээр хэрэгжилтийг нь хангах ёстой. Тэгээд манай цагдаагийн ажлын хэсэгт байгаа цагдаагийн байгууллагаас энэ хүүхдэд 21 нас хүрээгүй хүүхдэд тамхи, тамхин бүтээгдэхүүн үнэхээр зарсан байх юм бол худалдаалах энгийн тусгай зөвшөөрлийг нь цуцлах ёстой иймэрхүү санкцтай байж байж бид нар хаа хаанаа хариуцлагатай байна гэдэг саналыг оруулж өгсөн. Бид нар бас энгийг хэлэлцүүлгийн явцад тусгаад яг энэ тал дээр бас гишүүдийнхээ ч, мэргэжилтнүүдийнхээ ч гэсэн саналыг нь ингээд сайжруулаад явахад нээлттэй байгаа гэдгийг бас хэлмээр байна. Юутай холбоотой сөрөг нөлөө, хор хөнөөлтэй холбоотой асуудлыг.

Б.Найдалаа: Микрофон 1.

С.Болормаа: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. ДЭМБ-ын мэргэжилтэн Болормаа байна. Электрон тамхи хүүхэд, өсвөр насныханд хортой юу, хэр хортой вэ гэж байна. Маш олон судалгаа байдаг. ДЭМБ-аас энэ гарч байгаа судалгаануудыг тогтмол давтамжтайгаар авч хэлэлцэж өөрийнхөө хэмжээнд дүгнэлт гаргадаг. Тэгээд тамхин бүтээгдэхүүний судалгааны группийн тайлан гээд тогтмол гардаг байгаа. Энэ дээр маш дэлгэрэнгүй шинжлэх тухайны үндэслэлтэй тайлбарууд гарсан байдаг. Таны асуултад товчхон хариулахад өсвөр насны хүүхдийн уушгинд хэрхэн нөлөөлдөг вэ гэж байна. Электрон тамхины найрлагад хүний биед хортой олон улсын хавдар судлалын агентлагийн албан ёсоор гаргасан хавдар үүсгэгч ацетальдегид формальдегид гэдэг гэх мэт канцерген буюу хавдар үүсгэгч химийн бодисууд, түүнчлэн propylene glycol гэх мэт химийн хортой нэгдэл, мөн витамин Е ацет гэсэн ийм нэгдлүүд орсон байдаг ер нь бүх төрлийн электрон тамхинд. Тэгэхээр энэ витамин ацет.../минут дуусав./

Б.Найдалаа: Гүйцээж хариулъя. 1 минут микрофон 1.

С.Болормаа: Витаминь аттестаттай холбоотой АНУ ялангуяа 2020, 2021 оны үед 2800 орчим хүүхэд огцом электрон тамхины нөлөөтэй EVALI буюу Vaping use associated lung injury гэсэн ийм шинжлэх ухаанд бүүр ийм шинэ нэр томьёо гараад ирчихсэн. Яг вейп хэрэглэснээс үүдэлтэй уушгины гэмтэл гэсэн ийм шинэ төрлийн өвчин гараад үүнээс үүдэлтэй би тоог нь яг нарийн санахгүй байна 60 хэдэн хүүхэд нас барсан АНУ-д гэсэн ийм тооцоо байдаг. Энэ бол бүүр хамгийн ийм ноцтой EVALI гэсэн ийм шинэ төрлийн бараг өвчин үүсгэчихсэн байгаа. Тэгээд электрон тамхи яагаад хортой вэ гэхээр электрон тамхины найрлагад ордог энэ химийн хортой нэгдлүүд бүгдээрээ хортой нэгдлүүд хүний биед ашигтай, хэрэгтэй 1 ч төрлийн юм байдаггүй. Тийм учраас хортой гэж үздэг.

Судалгаа та асууж байна. Хор хөнөөл, донтуулах байдлын талаар Австралийн эрүүл мэндийн газрын.../минут дуусав./

Б.Найдалаа: Эрүүл мэндийн яамны та нэмж тодруул. Дуусаагүй бол нэмээд минут өгье. Минут микрофон 1.

С.Болормаа: Австралийн Эрүүл мэндийн яамнаас гаргасан тайланд дурдсанаар хэдий бага насандаа электрон тамхи хэрэгдэнэ төдий чинээ цаашид янжуур тамхи болон бусад төрлийн мансууруулах, донтуулах төрлийн бодист орох магадлал нь 3 дахин нэмэгддэг гэсэн ийм судалгаа гаргачихсан байдаг. Баярлалаа.

Б.Найдалаа: Эрдэнэбат гишүүн тодруулж асууна.

С.Эрдэнэбат: Тэгэхээр яах вэ энэ цаашдаа яг энэ талаар шинжилгээ судалгаанд нь бид нар маш их хөрөнгө зарах хэрэгтэй. Ялангуяа гадаадад хорьчихсон байгаа юмыг бид нар татварын аргаар л аргалж байна шүү дээ одоохондоо энэ хуулиар магадгүй. Хятадад хорьчихсон, Англид хорьчихсон, Европын орнуудад хорьчихсон. Тэгэхээр тэд нар нарийн шинжилгээ судалгаанаас үндэслэж тэгж байгаа байх. Тэр торгуулийн арга хэмжээнүүдийг бас эргэж сайн бодмоор юм шиг байгаа юм. Энэ 50000 байна уу нийтийн газар тамхи татахад? Энэ бараг 5, 10 жилийн л өмнө гарч байсан зүйл байгаа. Энийг индексжүүлэх шаардлага бол байгаа юм шиг байгаа юм. Ялангуяа нийтийн газар, орцонд ч гэдэг юм уу ийм газарт татдаг бүхэл бүтэн юу байдаг. Хэн торгох юм тэрийг очоо? Цагдаа нар орцоор явах юм уу, эс үгүй бол иргэн хэн нь мэдээлэх юм уу гээд энийг боловсронгуй болгохгүй бол хэзээ ч энэ тамхи, дам тамхидалтыг багасгах ийм арга байхгүй. Тэгээд энэ хууль дээрээ бас анхаараарай гэдгийг хэлмээр байна. Баярлалаа.

Б.Найдалаа: Надад 1 асуулт байна. Энэ хөрш улсууд Хятад гээд түрүүн дурдаж байх шиг байна. Хятад, Япон ч юм уу, Зүүн өмнөд Азийн улсууд ч юм уу яг энэ тамхины зохицуулалт нь ямар байгаа вэ? Электрон тамхи татвартай байна уу, хориглосон байна уу, бүүр татваргүй зөвшөөрчихсөн байна уу? Энэ талаар улсуудыг нь дурдаад маш товчхон тодорхой мэдээлэл өгөөч? Энэ зөвхөн энэ Байнгын хорооны гишүүдээс бас иргэдэд ч хэрэгтэй мэдээлэл байгаа юм.

Хэн хариулах вэ? Микрофон 3 Номинчимэг гишүүн хариулах юм уу?

О.Номинчимэг: Энэ Global centre for Good Governance энэ Tabaco contral буюу тамхины хяналтын сайн засаглалын төв гээд байнга судалгаа хийдэг газар

байгаа. Энэний 2025 оны 5 сарын байдлаарх энэ зохицуулалтын талаар улс орнууд ямар байдалтай байна гэдэг судалгааг бид нарт байна. Нийтдээ 82 улс электрон тамхины зохицуулалтуудыг хийсэн байгаа. Тэр дундаас 46, түүнээс гадна 46 улс ерөөсөө хорьчихсон байгаа. Ялангуяа манай Ази Номхон далайн бүс нутагт Сингапур, Шриланка, Турк, Энэтхэг, Тайланд, Вьетнам, Непал гэх мэтчилэн энэ улсууд ер нь бүрэн хориглох арга хэмжээ рүү орсон байна. Япон улсууд никотинтой электрон тамхийг бүрэн хорьсон ийм нөхцөл байдалтай байгаа. Европын болон хөгжилтэй улсууд ихэвчлэн одоогийн байдлаар хуулийн зохицуулалтаар мөн тэр дотроо 43 улс нь агууламж буюу энэ бүтээгдэхүүн доторх никотины агууламж нь заавал стандарт тогтоож өгсөн байдаг. Тэгэхгүй бол түрүүн манай гаалийн даргаас хэлж байгаачлан бусад тамхин бүтээгдэхүүнээс хамаагүй өндөр проценттой никотины тийм агууламжтай ийм стандартгүй бүтээгдэхүүнүүд өөрөө илүү донтолт үүсгэж байна гэсэн ийм судалгаа байгаад байгаа.

Мөн 20 улс бол энэ үнэр, амтыг хорьсон байгаа. Энд бас жишээ дурдах юм бол БНХАУ, Финланд, Унгар, Латви, Литва, Нидерланд, Словен, Украин, Австрали, Канад, Дани, Эстони, Герман, Шинэ Зеланд, Филиппин, Саудын Араб, АНУ гэсэн ийм улсууд үнэр, амтыг хориглож, тодорхой үр дүнд гараад байгаа гэсэн ийм судалгаанууд бидэнд байна.

Б.Найдалаа: Баярлалаа. Гишүүд асуулт асууж. Шижир гишүүн асуулт юм уу? Шижир гишүүнийг асуулт асуухаар нэрийг нь нэмье. Шижир гишүүний микрофоныг нээе.

Ө.Шижир: Би энэ Байнгын хороонд байдаггүй ч гэсэн орж ирсэн юм. Тэгээд асуулт асуух боломж олсонд баярлалаа. Хоёрхон юм тодорхой асуучихмаар байгаа юм. Маш энгийнээр ярих юм бол бид нар чинь талхнаас хямдхан тамхитай байгаад байна шүү дээ нэг талаасаа.

Нөгөө талаасаа ингээд харах юм бол гаалиар орж ирж байгаа тамхийг шинжлэх лаборатори манай улсад байдаг юм уу? Эхнийх нь. Хоёрдугаарх нь гаалийнхан байна уу? Гаалийнхан байвал энэ хууль хэлэлцэж эхлээд нэлээн нийгмийн анхааралд ороод явлаа шүү дээ. Тэгэхээр импортолдог компаниудын татан авалт сүүлийн саруудад өмнөх хэвийн үеэс хэд дахин нэмэгдэж байна? Энэ чинь нэг талаасаа ярих юм бол татвараас, татвар нэмэгдэхээс өмнө л оруулж ирэх гээд байна шүү дээ. Тэгээд энэ 2 асуултад надад хариулт өгөөч. Маш товчхон юм болохоор.

Б.Найдалаа: Маш тодорхой 2 асуулт байна. Микрофон 2.

С.Цэрэнчимэд: Таны асуултад хариулъя. Гаалийн төв лабораторийн дарга Цэрэнчимэд. Гаалийн лаборатори тамхи, тамхин бүтээгдэхүүн шинжлэх чиглэлээр Монгол улсын итгэмжлэгдсэн лаборатори. Бид нар бүх төрлийн тамхин бүтээгдэхүүн дээр шинжилгээ хийж байгаа. Дүнсэн тамхинаас авхуулаад электрон тамхи дуустал, өшөө цаашаа яриад хар тамхи, мансууруулах бодисыг хүртэл шинжлэх эрхтэй ийм лаборатори байгаа. Бид нар энэ орж ирж байгаа бүтээгдэхүүнийг дотор нь агуулагдаж байгаа найрлага, бүрэлдэхүүний никотиных нь процентоор нь бүгдийг нь тодорхойлох боломжтой.

Б.Найдалаа: Тодруулж асуух уу Шижир гишүүн.

Ө.Шижир: Тэрийгээ мартчихаж тэгээд тодруулчихъя.

Б.Найдалаа: Микрофон 2.

Ч.Чимгэрэл: Шижир гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад янжуур тамхи 1.7 дахин нэмэгдсэн. Цахилгаан халаагч хэрэгслээр татаж байгаа тамхи буюу түрүүн үзүүлсэн “IQOS”-ийн энэ тамхи бол 7 дахин нэмэгдсэн тоо хэмжээ нь. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад. Электрон тамхины хувьд бас өөрчлөлттэй үзүүлэлтүүд гарсан нь электрон тамхины цэнэглэгч шингэн буюу 1 удаагийн хэрэглээ нь буурсан үзүүлэлттэй хэдий боловч электрон device-тайгаа хамт орж ирдэг тоо хэмжээ нэмсэн байгаа. Яагаад гэхээр электрон device дээр татварын хувь хэмжээ тавьж байгаа учраас. Энэ бол 1.3 дахин их тоо хэмжээтэй гарч ирсэн.

Б.Найдалаа: Шижир гишүүн тодруулж асууна.

Ө.Шижир: Тэгэхээр хэлэлцүүлгийн явц ингээд болоод хууль батлагдах юм байна гэхээр ингээд импортолчихсон компаниуд чинь ингээд өмнөх үеийнхээсээ бараг 7 дахин их оруулж ирээд байна шүү дээ. Энэ эхний асуудал нь.

Хоёрдугаарх нь лабораториос дахиад асуучихъя. Тэр цаанаа Солонгос улс, хаанаас ч юм ингээд орж ирж байгаа улсуудаас бодвол тамхины шинжилгээнийх нь бичиг баримт хамт ирж байгаа шүү дээ. Танай лабораторитой хэр зөрдөг юм, яг таардаг юм уу, зөрдөг юм уу гэдэг ийм асуулт. Энгийнээр ярих юм бол импортолж байгаа Казахстанас тамхи орж ирж байгаа бол тэр тамхинд дагалдаж ирж байгаа шинжилгээний бичиг нь танай лабораторийн шинжилгээний бичигтэй хэр зөрдөг юм бэ гэдэг, зөрвөл яадаг юм бэ гэдэг асуудал.

Б.Найдалаа: Микрофон 3.

О.Номинчимэг: Шижир гишүүнд баярлалаа. Тэгэхээр яг энэ их асуудал болоод байгаа юм. Анх энэ ажлын хэсэг 2024 онд байгуулагдсан. Тэгээд бид нар аль болох энэ шуурхай асуудлыг шийдэхгүй бол үнэхээр ийм зах зээлийн юугаа хараад татвар тавих гэж байна, хориглох гэж байна гэдэг нөхцөлөөр энэ импортлогч нөхдүүд импортын бүтээгдэхүүнээ нэмээд ингээд татан авалтаа хийчихдэг юм байна лээ. Гэхдээ одоо ч гэсэн бид ингээд хэлэлцүүлгээ эхэлж байна. Улсын Их Хурал дээр бас улс төрийн нөхцөл байдлаас болоод энэ хуулийн хэлэлцүүлэг багагүй хугацаагаар хойшлогдсон.

Тэгээд бид нар 1 хором ч гэсэн алдаж болохгүйгээр энэ хуулиа хэлэлцээд сайжруулах зүйлсээ хийгээд тэгээд хэрэгжилтээ ч гэсэн шуурхай хийх хэрэгтэй байгаа. Тэгэхгүй бол бид нар хууль ярьсаар байтал хэрэгжилтийн хугацаа өөрөө хойшлох тусам үр нөлөө буурчихдаг. Бид нарын хийж тооцоолж энэ зохицуулалтуудыг орж ирсэн тооцоолол бүгдээрээ гажчихсан учраас энэ дээр бас цаг алдалгүй энэ зохицуулалтуудыг хийгээд хэрэгжүүлэх ажил дээрээ бид нар бас анхаарах ёстой байгаа гээд энийг бас дэмжээсэй гэж бас хүсэж байна. Гаалиас тэгвэл нэмэлтээр хариулчих.

Б.Найдалаа: Микрофон 2, микрофон 1. 1 үү? Микрофон 1.

С.Цэрэнчимэд: Гаалийн төв лаборатори Цэрэнчимэд. Манайх бол бүгдийг нь шинжилж байгаа. Янжуур тамхин дээр бохь никотины агууламжийг тодорхойлдог. Электрон тамхин дээр электрон нь энэ тамхин дотор байгаа

найрлагын бүрэлдэхүүнд нь байгаа органик уусгагчуудаас гадна никотины процентыг тэмдэглэдэг. Энэ дээр ямар нэгэн зөрсөн ийм асуудал гараагүй. Урьд нь бас тамхины дээр үед би энэ гаалийн лабораторид 28 жил ажиллаж байна. Тэгэхээр энэ урьд нь бас ийм янжуур тамхи буруу никотин зөрсөн асуудал орж ирсэн. Энэ дээр хуурамч тамхи орж ирэх бас ийм юм гарч ирсэн учраас никотины агууламж, бохины агууламжаар бид нар хянах бололцоотой байдаг. Тийм манайхаар бол зөрсөн асуудал байхгүй гэсэн үг.

Б.Найдалаа: Шижир гишүүн дахин тодруулъя.

Ө.Шижир: Тэгэхээр Солонгосоос жишээгээр ярих юм бол импортоор орж ирж байгаа тамхи манай, тэдний шинжилгээний бичиг манай лаборатори 2 яг таардаг юм байна зөв үү? Би өөрөө тамхи татдаггүй болохоор мэдэхгүй байна. Гэхдээ яагаад тамхи татдаг хүмүүс 2 өөр байдаг гэж яриад байдаг юм? Солонгосоос авсан тамхи, эндээс авч байгаа тамхи шал өөр байдаг юм гээд хүмүүс захиад байдаг шүү дээ. Тэр юундаа байдаг юм бол? Одоо шинжилгээний бичиг таарч байгаа юм бол яг л адилхан юм байна шүү дээ уг нь бол.

Б.Найдалаа: Хариулт микрофон 1.

С.Цэрэнчимэд: Ерөнхийдөө Солонгос, бид нар бас Алтан гадас компанийн үйлдвэрлэдэг “change esse” та бүхний мэддэг энэ тамхины үйлдвэр дээр очиж үзсэн. Ер нь бол энэ тамхины агууламж “Esse” ч, тэр никотины агууламж, бохины бохины хангамж өндөр байх нь болохоор юунаас хамаардаг вэ гэхээр тухайн тамхины ургамлаас хамаардаг. Ургамалд нь хэр зэрэг хэмжээний никотин, бохь байгаа юм бэ, ямар амттай байгаа юм бэ гэдгээс хамаардаг байгаа. Яах вэ яг бид нар Алтангадас дээр очоод, Алтангадасын үйлдвэрлэдэг Солонгосын үйлдвэр дээр очиж үзэхэд анхнаасаа бүүр судалгааных нь байгууллага нь эхлээд оруулж ирээд “change esse” 3 гэхийг хийхийн тулд 4 төрлийн нэр төрлийн тамхи байгаа тэр дотор. Гашуун амттай, чихэрлэг амттай, цайвар өнгөтэй, сулавтар амттай гээд. Тэгэхээр энэ олон төрлийн тамхинуудыг тамхины ургамлыг аль олон газраас авчирчхаад.../минут дуусав.

Б.Найдалаа: Хариулт болсон уу Шижир гишүүн хангалттай юу?

Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо үг хэлнэ. Үг хэлэх гишүүд байна уу? Нэрсээ оруулаарай.

Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Үг хэлэхэд зүгээр энэ бас дэгийн тухай зүгээр сануулга байна. Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дугаар зүйлд гишүүд хууль санаачлагчдын илтгэл, хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн үр нөлөө, зардлын тооцоо болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлэх юм шүү. Зөвхөн тамхитай холбоотой байр сууриа биш ер нь яг энэ хуулийн төслийг дэмжиж байгаа, дэмжээгүй талаар байр сууриа илэрхийлэх юм. Ариунзаяа гишүүнээс эхлээд үгээ хэлье.

А.Ариунзаяа: Хуулийн төслийг дэмжиж байгаа. Мэдээж хуулийн төслийг яг парламентын хэлэлцүүлгийн үе шат бол олон үе шаттай байгаа. Зарим гишүүдийн болоод сошиал дээр яваад байгаа асуудлуудыг харгалзаж үзэх нь ажлын хэсгийн бас нэг үүрэг болно. Яг энэ хуулийн төслөөрөө ямар нэгэн өөрчлөлтгүйгээр тэр чигээр нь харанхуй батална гэж зүтгэсэн асуудал бас Номинчимэг гишүүний хувьд

ч тэр, хууль санаачлагчдын хувьд ч тэр тийм асуудал байхгүй учраас энэ хуулийг бүхэлд нь үгүйсгэж, бүхэлд нь унагаах гэж байгаа юм шиг улс төрийн мэдэгдлүүдийг гишүүдийг битгий хийгээсэй гэж хүсэж байна. Тодорхой хэмжээнд хоёрхон асуудал байгаад байгаа. Тэр нь юу вэ гэхлээр нь яг энэ татвартай холбоотой цахилгаан тамхин дээр адилхан янжуур тамхитай адилхан 30 хувийн татвар ногдуулж байгаа нь өөрөө дэлхий нийтэд байдаг жишиг уу үгүй юу үү, энэ дээр тухайлж авч үзэх үү гэдэг нэг ийм асуулт байгаа. Энэ дээр мэдээж дэлхийн жишиг юу байна вэ, үүнд хэрхэн яаж нөлөөлж байна вэ гэдгийг ажлын хэсгийн хүрээнд харах боломжтой байх гэж үзэж байна.

Амт, гаа, жимсний үнэр амттай. Энэ амтат болгосон тамхийг хориглох уу үгүй юу гэдэг бас нэг том асуудал гарч ирж байгаа. Тэгээд энэ нь өөрөө юу юм бэ гэхлээр ер нь сая гаалийн мэдээлэл бас хэллээ шүү дээ. 24 оны гаалийн байгууллагаас гаргасан бас албан ёсны статистикийн мэдээллээр янжуур тамхины 47-50 хувь нь хагалдаг гаатай үнэр, амт оруулсан янжуур тамхи, тамхин бүтээгдэхүүн байдаг юм байна. Харин янжуур тамхин бүтээгдэхүүнээс тусдаа халаадаг болон электрон тамхи бидний хэлж заншсанаар вэйп буюу вэйпний 5-хан хувь нь яг тамхины амттай буюу ямар нэгэн амт, үнэргүй байдаг юм байна. 95 хувь нь л амт, жимс, ус ундаа, дарс юу л байна хамгийн гоё болгосон ийм л төрлийн бүтээгдэхүүн байгаад байдаг юм байна шүү дээ. Тэгэхээр энийг амт, үнэрийг хориглох юм Вейпийг ер нь бүхлээр нь хориглож байгаатай нэгэн адил болох гээд байна гэдэг ийм асуудлыг Вейп хэрэглэгчдийн зүгээс тавиад байгаа юм байна.

Монгол улсад янжуур тамхинаас татгалзах, утаа үнэрээс зайлсхийж халаадаг болон электрон тамхи хэрэглэж байгаа буюу утаат юу гэдэг юм янжуур тамхи муу, янжуур тамхинаас гарах хэрэгсэл нь энэ цахилгаан тамхи юм гэдэг тэр сурталчилгаанд автсан хүмүүс нь Монгол улсад 250 мянган хүн байдаг юм байна гэсэн ийм судалгаа гаргаад байгаа юм. Хагалдаг гаа, жимсний амттай янжуур хэрэглэж байгаа 400 мянган хүн гээд ингээд нийлээд ойролцоо 650 мянган хүн энэ гаатай, амттай үнэртэй тэгээд энэ электрон тамхи хэрэглэдэг юм байна. Энийг 650 мянган хүний хэрэглээг бараг байхгүй болгох гээд байна гэдэг ийм асуудлыг дэвшүүлээд байгаа байхгүй юу. Тэгэхээр магадгүй энэ дээр бид нар бас авч хэлэлцэх асуудлууд нээлттэй байж болно. Энэ гишүүдийн бүрэн эрх. Гагцхүү бид нар хамгийн гол асуудлыг юу гэж дахиад би юуг онцлох гээд байна вэ гэхлээр энэ насанд хүрсэн хүмүүсийн хэрэглээ бол тусдаа асуудал энэ ухамсарт сонголт.

Бага насны, өсвөр насны насанд хүрээгүй байгаа хүүхдүүдийн энэхүү амтанд дурлаад ороод байгаа асуудлыг бид нар хэрхэн яаж цэгцлэх вэ? Бусад улс орнууд хориглоод байна. Бусад улс орнууд энэ янжуур тамхинаас гарах хэлбэрээр энэ электрон тамхийг хэрэглэж байгаа хүмүүсийг эмийн сангуудаар дамжуулж хүртэл борлуулах ийм үзэгдэл байна. Ийм учраас бид нар энэ асуудлыг авч хэлэлцэхээс өөр арга байхгүй. Хүүхдүүдийн энэ сонирхлыг хэрхэн, яаж байхгүй болгох вэ, үнэхээрийн зүгээр шууд тамхиныхаа үнэртэй, тамхины амттай байвал хүүхдүүд хэрэглэх үү үгүй юу гэдэг дээр бид нар эргээд бас том асуултын тэмдэг байгаа юм.

Б.Найдалаа: Баярлалаа. Мөнхтуяа гишүүн үг хэлнэ.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. 2013 оноос хойш гар хүрээгүй Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах энэ хуулийн төслийг санаачилсан Номинчимэг гишүүндээ бас баяр хүргэмээр байна. Тэгээд энэ хуулийн төслийг нэр бүхий 78 гишүүн хамт өргөн барьж байгаа. Тэр гишүүдийн

1 нь би өөрөө байгаа. Энэ хуулийг ер нь дэмжих нь зөв өө. Одоо ялт ч үгүй энэ сая гишүүд бараг бүгд л хэлж байна шүү дээ. 13-17 насны хүүхдүүд энэ вейп тамхинд донтож байна. Багш нар энэ дээр бүүр хүч хүрэхгүй байна гээд ингээд маш их гомдол, саналууд ирж байгаа.

Тийм учраас энэ хүүхдийн, насанд хүрээгүй хүүхдийн энэ донтолт вейп тамхи татах энэ асуудлыг бид нар яаралтай цэгцэлж авахгүй бол ирээдүйн ингэж ярьж байна шүү дээ сая судалгаа, судлаачид уушгины үрэвсэл, амьсгалын замын архаг үрэвсэл, мөн дархлаа сулрах, тэгээд тархины хөгжил нь дутуу өсвөр үеийнхэнд хүүхдийн төв мэдрэлийн системийг гэмтээдэг гэсэн ийм ДЭМБ-ын судалгаа байна. Тийм учраас энэ хуулийг яаралтай батлаад энэ ялангуяа энэ өсвөр насны хүүхэд рүү чиглэсэн асуудлыг бид нар бүүр онцгой анхаарах чухал гэдгийг хэлмээр байна. Тэгээд энэ хуулийг дэмжиж байгаа. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: Хуулийн төслийг дэмжиж байгаа. Өргөн барьсан гишүүдийн нэг байгаа. Цаашдын бас хэлэлцүүлгийн шатууд дээр нэлээн бас нарийвчилж ярилцах асуудлуудыг бас манай Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо бас гишүүд бас хэлж байна. Санал бас нэг байна зарим гишүүдтэйгээ. Юуны түрүүнд бас энэ 2013 онд тамхины тодорхой зохицуулалтыг хийсэн Эрдэнэчимэг тэргүүтэй бас гишүүдэд бас талархал илэрхийлье гэж бодож байна. Энэний бас үр дүнг өнөөдрийн бас Монголчууд бид бүхэн бас хүртээд явж байна. Ямартай ч ер нь дотор орчинд бид бүхэн бас хамаа замбараагүй тамхи татахгүй ийм болсон. Дам тамхидалтын нөлөө бас эрс буурсан. Энэ бол бидний бас соёл, өдөр тутмын амьдралд бас нэлээн том үр нөлөө болсон гэж бодож байна. Ингээд бид нар цаашдаа дараагийн алхмаа хийгээд зоригтой өөрчлөлтүүдээ оруулаад явах ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа. Үндсэндээ шинэ төрлийн тамхи болон янжуур тамхины энэ хэрэглээг ижил түвшинд авч үзэж, тодорхой татварын үе шаттай нэмэгдүүлэх энэ бодлогыг бас дэмжиж байгаагаа илэрхийлье.

Мөн дээрээс нь бас тодорхой энэ эдийн засгийн үр нөлөөгөөр дамжуулж хэрэглээг бууруулах, тэр чиглэлийн тодорхой үйл ажиллагааг 3 энэ хэлбэрт шилжүүлж байгаа энэ бодлогыг бас дэмжиж байгаагаа бас илэрхийлье. Ялангуяа тэр хүүхдийн үдийн цай хөтөлбөрийг бас дэмжих энэ санаачилга, мөн дээрээс нь спорт, олон нийтийн үйл ажиллагаагаар дамжуулж бас энэ хорт зуршлыг бууруулах энэ санаачилга маш зөв өө гэдгийг хэлье.

Цаашдаа ер нь энэ өсвөр үеийнхний хүмүүжлийн энэ асуудал дээр бас тодорхой төсөв, санхүүгийн энэ боломжууд бас үүгээр бас нээгдэнэ гэсэн ийм онцлогийг бас харж байна гэдгийг бас хэлье. Би түрүүн асуулт дээр асуусан хатуу аргаар тэмцэж байгаа, эдийн засгийн аргаар тэмцэж байгаа энэ асуудлаас гадна илүү бас соён гэгээрүүлэх, өсвөр үеийнхнийг бас хорт зуршлаас сэргийлэхэд чиглэсэн энэ арга хэмжээнүүдийг нэмэгдүүлэх чиглэлийн ажлуудыг бид бүхэн цаашдаа дэмжих чиглэлийн саналуудыг бас оруулах ёстой шүү. Энэ бол бид бүхний хамгийн чухал асуудлуудын болох ёстой.

Мөн дээрээс нь сум, орон нутгийн хувьд тодорхой хэмжээнд хяналтгүй байгаа, хүүхдүүдэд худалдаалж байгаа энэ асуудлыг илүү нарийвчлах Эрдэнэбат гишүүний бас саналыг бас дэмжиж байна. Тодорхой тэр 500 метрийн радиусын хувьд бас бид бүхэн зохицуулалтуудыг гаргах, эргэж харах хэрэгтэй.

Мөн дээрээс нь хяналтыг яг хэн хийх вэ, яаж зохион байгуулах вэ, ямар хариу арга хэмжээ авах вэ гэдэг дээр бид бүхэн бас тодорхой шийдлүүдийг гаргаж өгч чадвал энэ бас 1 төрлийн дэвшил болно гэдгийг бас онцлон хэлье. Хэлэлцүүлгийн шатад эдгээр саналуудыг бас дэмжиж, илүү нарийвчилж бас саналуудаа тусгаад явъя. Ингээд үндсэндээ 126 гишүүнтэй болсны үр дүнг харуулах ийм хуулийн төсөл гэж би бас нэг талдаа бас бодож байна. Бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулагдсан, өргөтгөсөн парламентын тодорхой сорилтуудтай бас тулж ирж байгаа түүний нэг илрэл нь энэхүү Тамхины тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал байна. Мэргэжлийн олон салбарын гишүүд орж ирсний хэрэг юун, нэлээн бас олон салбарын хүмүүс бас орж ирсний хэрэг юун энэ дээр бас гарах болов уу гэж бодож байна. Тэгээд ажлын хэсэгт амжилт хүсье.

Б.Найдалаа: Баярлалаа. Болормаа гишүүн үг хэлнэ.

Х.Болормаа: Байнгын хорооны гишүүд, ажлын хэсгийн ажлын хэсгийнхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Номинчимэг гишүүний санаачилсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг өргөн барихад миний бие дэмжиж бас гарын үсэг зурсан. Миний хувьд хамгийн их олзуурхаад байгаа зохицуулалтыг бас олж харлаа. Үүн дээр дагалдуулан оруулж ирж байгаа Онцгой байдлын албан татварын тухай хууль, мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, тамхины онцгой албан татвараас орж ирэх орлогоос хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв, боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийтийн зориулалттай спортын байгууламж шинээр барих, өргөтгөх, засварлах, аймаг, нийслэлийн спортын дугуйлангийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх гэсэн энэ заалтууд орж ирсэн нь маш их сайшаалтай зүйл байна гэж олзуурхаж бас харж байна. Хүүхэд, залуусыг аливаа хорт зуршил, уруу татлага, сөрөг амьдралын хэв маяг маягаас хамгаалахын тулд бид тэдний чөлөөт цагийг эрүүл, зөв боловсрон өнгөрүүлэхэд орчин нөхцөлийг нь бүрдүүлэх нь хамгийн чухал. Тийм учраас энэ хуулийн зохицуулалт дээр энэ оролдлогыг ингэж хүүхэд, залуучууддаа зориулж байгаа энэ зохицуулалт орж ирж байгаа нь их сайшаалтай байна гэж харагдаж байна.

Тийм учраас ийм энэ хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж байгаагаа илэрхийлж байна. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Баярлалаа. Би энэ хуулийн төслийг бас гарын үсэг зурж дэмжсэн нэг гишүүн байна. Электрон тамхийг ялангуяа хүмүүс сэтгэл зүйн дарамтаа намжаах, тайвшруулах ийм хэрэгсэл гэж залуучууд ер нь ойлгож байгаа. Энэ бол бодитой биш. Электрон тамхи өөртөө итгэх итгэлийг сайжруулахгүй, стрессийн үндсэн шалтгааныг огт шийдвэрлэдэггүй зөвхөн түр зуурын мэдрэмж өгдөг ийм л хэрэгсэл байгаа. Одоогийн байдлаар электрон тамхийг аюулгүй, хоргүй гэдгийг баталсан судалгаа байхгүй. Эсрэгээрээ хортой гэдгийг маш олон орнуудын судалгаанууд харагдаж байгаа. Тэр судалгаанд нь ямар хор байгаа гэхлээр нэгдүгээрт хамаарал буюу донтолтыг үүсгэдэг, сэтгэл гутрах, сэтгэл түгших эмгэгийг нэмэгдүүлэх хүчин зүйл болдог, өөртөө итгэх итгэлийг бууруулдаг зэрэг сэтгэцийн шалтгаантай холбоотой.

Ингээд ургуулаад үзэхээр сургууль дээр байгаа хүүхдүүдийн ганцаардал, сэтгэл гутрал, дээрэлхэлтийн асуудлууд буюу хэрвээ тэр хэсэг рүү бид нар нэлээн сайн нүдээ нээгээд харах юм бол дээрэлхэлтийн кэйс, сургууль дахь янз бүрийн асуудлууд бол электрон тамхины хэрэглээтэй холбоотой байгаа. Шууд бус болон шууд. Энэ судалгааг би ганцхан хэлж байгаа юм биш. Америк, Солонгос, Австрали, Монгол, төстэй орнууд ч гэсэн олон оронд энэ явж байгаа. Энэ бол нотлогдчихсон зүйл. Тэгэхээр бид нар хүүхдүүдийн өсвөр үеийнхэнд зориулж байгаа хэрэглээ нь түлхүү байгаа учраас өнөөдөр бид нар ийшийгээ илүү анхаарч энийг яриад байна гэсэн үг.

Нөгөө талд манай нийгэмд хүүхдүүдээ зориулаад бид нар нэг зүйлийг огт зааж өгөөгүй. Хөвгүүдэд ч зааж өгөөгүй. Тэр нь юу вэ гэхээр сэтгэл зүйн асуудлыг яаж даван туулдаг юм бэ гэдгийг бид нар ерөөсөө зааж өгөөгүй. Сэтгэл зүйн асуудлыг бид нарын медиа, хэвлэл мэдээлэл яаж харуулж байгаа гэхлээр тамхи татаж, архи ууж найзуудтайгаа янз бүрийн арай ийм хөнгөн энгийн ийм эрүүл бус аргаар энийгээ даван туулж байна гэж ойлгодог ийм бүтэн ийм давлагаа явж байна. Манай сүүлийн Монгол улсад ерөнхийдөө хийгдсэн бүх кино уран бүтээлүүдэд сэтгэл зүйн асуудалтай сцен, дүр зураг болгон дээр тамхидалт гардаг, архидалт гардаг. Тэгэхээр энийг бид нар энэ Зар сурталчилгааны хууль дээр байгаа заалтаа өнөөдөр ажиллуулахыг шаардах хэрэгтэй. Тамхины дүр, архин дээр бид нар дүрс тавиад болиулдаг мөртөө тамхин дээр бид нар байдаггүй. Хамгийн том жишээ бүсгүй гэдэг маш гоё кино байдаг. Би энийг өмнө нь бас хэлж байсан. Тэр киноны хайр дурлал тэр чигээрээ тамхины утаан дунд өрнөдөг. Дурлалаа тамхи. Гоёо cool, залуучууд, охидууд байлаа тамхины асуудлууд.

Тэгэхээр бид нар ер нь энэ нийгэмд тулгамдаж байгаа хүн ер нь өөрийнхөө амьдралд янз бүрийн асуудал тулгамдахаар тэрийгээ яаж шийдэх ёстой юм гэдэг арга замыг хүүхдүүдээ огт заадаггүй, сургуульд тэр хөтөлбөр байхгүй, нийгмийн ажлыг огт дэмждэггүй, сэтгэл зүйн үйлчилгээгээ уг углуургаар нь хийгээгүй учраас хүүхдүүд тэр хоосон орон зайг өнөөдөр вэйпинг буюу тамхиар нөхөж байгаа. Тэгэхээр өнөөдөр бид нар зөвхөн энэ Тамхины тухай хуулийг 1 удаа хориглоод орлуулж байгаа тэр зүйлийг нь хийхгүй юм бол энэ зогсохгүй. Би тэгж бодож байна. Энэ олон улсын туршлага, судалгаа байгаа.

Тэгэхээр нэгэнт өөрөөр хэлбэл донтоод байна гэдэг чинь тэнд хэрэгцээ байна, хүн амьсгалмаар байна, уртаар амьсгаа авмаар байна, ганцаараа баймаар байна, тайвширмаар байна. Гэтэл тэрийг яаж ингэдэг вэ гэдгээ бид нар энэ хүүхдүүдээ ээж, аав нар өөрсдөө бас зааж өгөх хэрэгтэй байна. Энэ бол хүүхдүүдээ тамхинаас хамгаалах, татварын бус нийгмийн сэтгэл зүйн хамгийн чухал арга. Энэ тухай өнөөдөр ерөөсөө ярихгүй байна. Энэ тухай бид нар яривал өнөөдрийн бид нарын энэ татварын бодлого илүү ойлгомжтой болоод эхэлнэ. Яагаад татвар байдаг гэдгийг цаад санааг ойлгоод эхэлнэ. Тэгэхээр энэ донтоод байгаа, донтуулаад байгаа орон зайнд нь орлуулагч зүйлсийн тухай яримаар байна. Тэгэхээр Зар сурталчилгааны хуулиар хуулийн заалтуудаа ажиллуулмаар байна. Мөн вейпийг хориглох нь зүйтэй. Орлуулах зүйлийг заавал оруулах, ярих хэрэгтэй юм гэж хэлье.

Б.Найдалаа: Баярлалаа. Галбадрах гишүүн үг хэлнэ.

Ж.Галбадрах: Энэ хуулийг дэмжиж байгаа гишүүдийн нэг, бас өргөн барьсан гишүүдийн нэг. Тэгээд энэ маш чухал хууль байгаа. Би сургуулийн багш

хүн сургууль дээр ажилладаг. Энэ вейп буюу энэ электрон тамхи татаж байгаа асуудал сургуулийн энэ хүмүүжил, төлөвшил энэ асуудал дээр маш ноцтой асуудал болчихоод байгаа. Өөрөөр хэлбэл гамшиг болчихоод байгаа. Тэгээд энийг давах гээд багш нар маш их цагаа бардаг. Тэр нойлийн өрөөг отоод зогсож байдаг гэдэг шиг цүнх савыг нь нэгжинэ гэдэг гэхээс эхлээд маш их асуудал өөрсдөө тэр хор уршгийг нь мэдээд байдаг.

Гэтэл энэ нь хүүхдүүдийн дунд ингээд бүүр давлагаалаад, моод болоод, тэгээд нэг нэгийгээ ингээд уруу татаад ингээд яваад байгаа. Тэгээд тэр хор хөнөөлийг нь сайн ойлгохгүйгээс тэр л хүүхдүүдэд сайн хүрэх хэрэгтэй байна. Харин яаж хүргэх вэ, хор хөнөөлийг багш нар мэдээд ярьдаг. Тэгэхдээ тэр нь үнэхээр тийм далайцтай хүрэхгүй байна уу, хүүхдүүд ингээд шохоорхоод ингээд яваад байгаа. Сая 170 хэд дахин нэмэгдсэн энэ тэр гэдэг чинь аймаар тоо байна. Тэгэхээр энэ яг цагаа олчихсон энэ хууль байж байгаа. Тэгээд бид нар аврахын тулд энэ хууль дээрээ л тэр мэдээж зүгээр үнэ нэмээд, татвар нэмээд ингээд багасгая гээд энэ нь цаашаагаа дамын наймаа гэдэг шиг газар аваад өшөө бас ингээд явчих вий гэдэг талаас нь бас эдийн засаг талаасаа бас харах хэрэгтэй байх. Өөрөөр хэлбэл тийм наймаа нь бас буруу талаараа цэцэглэх вий гэдэг дээр бас анхаарах шаардлагатай.

Тэгээд багш нар зөвхөн сургах биш энийг гэр бүлд нэлээн сайн ойлгуулах, эцэг эхчүүдэд ойлгуулах нь хамгаас чухал ажил юм л гэдгийг хэлж байна. Тэгэхээр сургууль дээр мэргэжлийн хүмүүс очоод яг тойрч явж хийдэг тийм багуудыг, сошиалын багуудыг, энэ инфлюенсер энэ сая манай Саранчулуун гишүүн хэлж байна шүү дээ тэр тамхин дотор тамхины утаан дотор л ингээд явдаг ийм орчин тэр энэ их гоё ийм тааламжтай орчин шиг гэхээсээ эсрэгээр нь бид нар сурталчилгааны юун дээр их явна. Тэгээд бид нар 2030 онд 30 хувьд бууруулна тамхины хэрэглээг гээд энэ том зорилт тавьчихсан байна. Гэтэл бид нар чинь 20 оноос 25 оныхоо энийг харахаар маш их олон дахин өсөөд ирчихсэн. Тэгээд өсөөд ирчихсэн энэ юмыг бид нар өнөөдөр бууруулна л гэвэл үнэхээр бодитой тийм арга хэмжээнүүдийг л их сайн төлөвлөж энэ далайцтай юмыг авах хэрэгтэй байна гэж бодож байна.

Тэгээд энийг яахын тулд тэр орлогыг 50 хувиар нэмэгдээд гаалийн албан татвар ч юм уу, онцгой албан татвар ч юм уу нэмэгдэх юм байна шүү дээ. Тэр нэмэгдэж ирж байгаа зүйлийг ийм зохистой юманд ингэж хэрэглэж байна гэдэг талаас нь бас ойлгуулах, хүүхдийн хичээлээс гадуурх зөв зохистой цагаа өнгөрөөх тэр зүйлд өөрөөр хэлбэл энэнээс олсон орлогоор спорт, дугуйлан секцийн бид нар Edu centre гээд л их гоё тийм төв гарчихсан байж байдаг шүү дээ. Тэр шиг ийм төвүүдийг, дүүргүүдэд, аймгуудад энэ тэр барихад нь бас энэ онцгой татвараас орж ирсэн орлогоос бид нар санхүүжүүлж ингэж явсан юм ч гэдэг юм уу тийм эерэг талынхаа сурталчилгааг бас их сайн хийж байж, ил тод зарцуулалтыг их гаргаж ирж байж энэ бас үр дүнгээ өгөх байх. Тэгээд аль аль талаасаа л соён гэгээрүүлэх ажил нь л их чухал гэж бодож байна. Тэгээд маш сайн дэмжиж байгаа. Тэгээд энийг удаалгүйгээр хурдан батлах нь яаралтай чухал байгаа гэдгийг хэлэхийг хүсэж байна. Тэгээд ажлын хэсэгт амжилт хүсэж байна. Дэмжээд явна.

Б.Найдалаа: Баярлалаа. Энхнасан гишүүн үг хэлнэ.

Л.Энхнасан: Ажлын хэсэг болон бүх гишүүддээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Тамхины хяналтын тухай хууль болон энэ дагаж байгаа хуулиудыг дэмжиж байгаа. Дэмжиж гарын үсэг зурсан гишүүний нэг байгаа. Тамхины

хяналтын хууль маань ингээд орж ирэх гэсээр байтал бас нэлээн хугацаа өнгөрчихлөө. Тэр хооронд бас энэ тамхины лобби групп нэлээн хүчтэй ажиллаж байх шиг байна. Энэ хууль маань яг бас нэлээн олон цаг хугацаанд бас ингээд батлагдахгүй яваад байсан бас хуулийн нэг. Тэгээд энэ галтай хуулийг бас авч орж ирж байгаа Номинчимэг гишүүндээ бас талархал илэрхийлье. Бас ажлын хэсэгт бас баяр хүргэе.

Ингээд энэ өнөөгийн энэ нэмэлт, өөрчлөлт бол иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, залуу үеийн хэрэглээг бууруулах, эрсдэлээс сэргийлэх ийм маш чухал алхам байгаа. Цахим, цахилгаан тамхи, 1 удаагийн төхөөрөмжийн хэрэглээ хүүхэд, өсвөр насны дунд эрс нэмэгдсэн байгаа. Тархалт нь улаан улам залуужиж байгаа. Яг энэ үед бас энэ чиг хандлагыг хариу өгч энэ импорт худалдаа, сурталчилгаа хүртээмжийг бас хатуу зохицуулалт зайлшгүй хийж байгаад бас цагаа олсон хууль байна гэж үзэж байна.

Энэ хэлэлцүүлгийн шатад бас зарим өөрчлөлтүүд бас орох байх. Би бас ХҮН намын зөвлөлийн хуралд бас өөрийнхөө саналаа бас илэрхийлж байсан. Энэ 500 метр орчимд зарахыг бас ингээд дахиж харж үзэхгүй бол ялангуяа энэ хотын төвд энэ хууль маань хэр хэрэгжих вэ гэдэг нь бас асуудал байгаа. Мөн 21 настай, нас хүрээгүй хүүхдүүдэд бас энэ тамхины хэрэглээг бүүр зарахыг бүүр хатуу хориглосон энэ заалтуудыг бас оруулах нь зүйтэй юм гээд.

Ер нь тамхи яагаад хүн хэрэглэдэг вэ гэвэл бас энэ сэтгэл гутрал, стресст орохлоор бас маш их хэрэглэдэг. Тэгэхлээр энэ онцгой татвараас орж ирж байгаа орлогыг бодоод бас нийгмийн эрүүл мэнд, ялангуяа сэтгэл зүйн эрүүл мэндийн зарцуулаарай гэсэн бас хүсэлт байгаа. Би бас өөрөө яах вэ тамхи татдаг байсан хүний нэг. Тэгээд Эрдэнэчимэгийн тамхины хуулийн үр дүнд тамхинаас бас гарсан. Тэгэхлээр энэ амьдралд хамгийн их хэрэгцээтэй хууль байсан гэж бодож байна. Яагаад гэвэл олон нийтийн газар бас тамхи татахгүй байх гэдэг бас тамхинаас гарах бас бас том шалтгаан болдог. Тэгээд ажлын хэсэгт амжилт хүсэж байна. Би 100 хувь дэмжиж байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Энхцэцэг гишүүн үг хэлнэ.

М.Энхцэцэг: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Ингээд нийгмийн хамгийн чухал эрэлт хэрэгцээтэй ийм хуулийг санаачлаад явж байгаа Номинчимэг гишүүндээ баярлалаа. Энэ хуулийг боловсруулж байгаа гишүүдийн нэг нь би өөрөө байгаа. Ер нь ингээд Эрдэнэчимэг гишүүн анх Тамхины хуулийг баталснаас хойш нийгэмд бас томоохон хэмжээний өөрчлөлтийг авчирсан ийм ач холбогдолтой хуулийг баталсан. Тэгээд өнөөдөр тамхи маань ялангуяа бага насны хүүхдүүд, 10-н жилийн хүүхдүүд энэ электрон тамхи гэдэг юмыг хэрэглэж байгаа асуудал бүүр харангын хэмжээнд, аюулын хэмжээнд хүрчихсэн хүн болгоны сэтгэл зовнисон ийм асуудал нийгэмд тулгарч байгаа.

Тэгээд энэ үед энэ байдлыг байхгүй болгох, бууруулах, томоохон хэмжээний өөрчлөлтийг нийгэмд авчрах ийм хуулийг боловсруулаад явж байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд хамгийн гол чухал юм нь энэ электрон тамхины хувьд болохоор тэр тамхины маш муухай үнэр маш, муухай амтыг бууруулах төрөл бүрийн бодис хэрэглэж, нэг төрлийн урхи хэрэглэж ийм залуу хүүхдүүдийг тамхинд донтуулах ийм арга хэрэглэсэн байгаа. Тэгээд энэ дээрээс нь Монголд бас тодорхой хэмжээний хязгаарлалт, хууль байхгүй учраас бараг бусад улсуудтай

харьцуулахад маш өргөн хэмжээнд ингээд дэлгэрчихсэн ийм асуудал байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ хууль дээр бас нэг анхаарах юм нь тэр тамхины муухай үнэрийг дарж байгаа бодис дээр гаа болон бусад бүх бодисыг хориглох гэдгээр оруулж өгөх нь зүйтэй байх гэсэн саналтай байгаад байгаа. Яагаад гэхээр бид нар гааг хэрвээ үлдээчих юм бол тэгээд л бас тэр электрон тамхийг хориглохгүй хэвээр үлдээсэнтэй л адилхан болчхож байгаа учраас гаанаас бусад бодисыг хориглох биш, гаа болон бусад бүх бодисыг хориглох гэсэн байдлаар оруулж өгвөл зүйтэй байх гэж ингэж бодож байна.

Хоёрдугаар асуудал болохоор ер нь энэ хуулийн хариуцлагын асуудал маш чухал. Бид нар мянга сайхан хууль батлаад бодит амьдрал дээр хэрэгждэггүй. Тэгэхээр яг энэ хууль дээр байгаа заалтыг биелүүлэхгүй байх юм бол ямар хариуцлага хүлээх вэ гэдэг юмыг нэлээн хатуу, чанга байдлаар оруулж өгөөч. Тэгж байж энэ хууль маань нийгэмд томоохон хэмжээний өөрчлөлтийг бид нарын хүсэж байгаа тэр өөрчлөлтийг авчрах тийм хууль болж чадна гэж ингэж бодож байна. Хамгийн гол чухал юм нь л энэ хуулийн дараа 1 жилийн дараа бид нарын тэр бага насны хүүхдүүд маань тэр тамхи, электрон тамхи хэрэглэдэггүй болох тийм орчин нөхцөл бүрдэх хэрэгтэй байна. Тэгэхийн тулд нөлөөллийн ажлыг ялангуяа сая гишүүд хэлж байна. Соён гэгээрүүлэх ажлыг тэр 10 жилийн сургуулийн эрүүл мэндийн боловсролын хүрээнд тамхины хор нөлөөллийг ойлгуулж ухуулах ажлыг маш сайн хийх хэрэгтэй байна. Дээрээс нь нийгэмд энэ вейп энэ электрон тамхийг татаж олон нийтэд сайхан зүйл гэж сурталчилж байгаа асуудлыг хориглох хэрэгтэй байна.

Дээрээс нь ингээд нэгэнт тамхинд орчихсон байгаа хүүхдүүдийг яаж тэр тамхинаас нь гаргах вэ, эрүүл эмчилж тэр тамхинаас нь гаргах вэ гэдэг асуудал дээр бас анхаарч ажиллах та чиглэл рүү бас ажиллах хэрэгтэй байна гэж ингэж харж байгаа. Ингээд энэ хуулийг маш яаралтай баталж, нийгэмдээ томоохон хэмжээний өөрчлөлтийг авчрах дээр энэ шинэ 126 гишүүнтэй Улсын Их Хурал нягт хамтарч ажиллана гэдэг дээр итгэлтэй байна. Тэгээд энэ хуулийг бүрэн дэмжиж ажиллаж байгаа. Мэдээж бизнесийнхээ байгууллагуудыг дэмжих гэж асуудлууд бас хүмүүс хөндөж ярьж байх шиг байна л даа. Тэгэхдээ бид нарын хувьд бизнесээс илүүтэй бид нар Монгол Улсын ирээдүй чухал, үр хүүхэд маань чухал. Тийм учраас бид нар энэ дээр хамгийн түрүүнд онцгой анхаарч, энэ хуулиа цааш маш яаралтай баталж үр хүүхдээ, ирээдүйгээ хамгаалах нь чухал гэж ингэж бодож байна.

Б.Найдалаа: Баярлалаа. Шижир гишүүн үг хэлнэ.

Ө.Шижир: Сая Энхцэцэг гишүүн ирээдүй гээд ярьж байна. Яг үнэн. Бид нар чинь ирээдүй өнөөдрөөс эхэлнэ гээд лоозогнодог. Яг бодитоор шийдэл байдаггүй. Тийм учраас нэгэнт ирээдүйг өнөөдрөөс эхлүүлчих юм бол өнөөдрөөс энэ хуулийг хэлэлцээд батлаад явах нь зүйтэй. Ер нь нэгэнт цахилгаан тамхи татаад амандаа ямар нэгэн юм зуугаад сурчихсан дадал зуршил болчихсон хүн, хүүхэд насныхан дараа зав янжуур л орно. Энэ чинь өөрөө тийм том судалгаа байдаг юм байна лээ шүү дээ. Тэгэхээр одоогоос бид нар энэ зүйлээс сэргийлэх хэрэгтэй.

Ер нь тэгээд талхнаас хямдхан тамхитай улс ч гэж юу байх вэ. Цахилгаан тамхиа электрон бараа гэж оруулж ирдэг ч улс гэж юу байх вэ. Цахилгаан тамхинаасаа онцгой албан татвар гэж авдаггүй улс ч гэж бас юу байх вэ яг

бодитойгоор. Тэгэхээр бид нар тамхины төрлөөсөө хамаараад 1.7-гоос 7 дахин 2024 оныхоос өссөн гэдэг чинь аймшигтай тоо байхгүй юу. Өнгөрсөн онд зүгээр би энэ ажлын хэсгийн даргаас асууж байхад 2024 онд 3.5 тэрбум ширхэг янжуур, 8.9 сая ширхэг вейп тэгээд үүний тодорхой тоо нь цахилгаан бараа гэж орж ирдэг.

Тэгэхээр үүнд энэ дээр бид нар үүнийг нэргэсэн хойно хашхирав гэдэг шиг болохгүйн тулд энэ хуулийн зохицуулалтыг зайлшгүй хийх хэрэгтэй. Мэдээж гишүүдээс гарч байгаа санал, санаачилгууд хэлэлцүүлгийн явцдаа ингээд өөрчлөгдөөд явах байх гэж бодож байна. Тэгээд ажлын хэсгийнхэнд амжилт хүсье. Энэ бас яг яг ний нуугүй хэлэхэд бас түүхэнд үүрэг гүйцэтгэхээр хууль шүү. Энэ өмнөх Эрдэнэчимэг гишүүний баталсан хуультай адилхан. Тэр хууль, Эрдэнэчимэг гишүүний хууль батлагдсаны дараа бас нийгэмд аягүй зөв өөрчлөлт гарсан. Олон нийтийн газар тамхидахаа больсон, хоол, цэнгээний газар тамхидахаа больсон. Тэгээд нэг тал өөрөө тамхи татдаггүй мөртөө дам тамхидалтад өртөөд л ингээд давхар хордоод яваад байдаг байсан бол ер нь байхгүй болсон. Тэгэхээр энэ дээр бас та бүхэнд энэ бүхэнд бас амжилт хүсье. Баярлалаа6 Дэмжиж байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Цогтбаатар гишүүн үг хэлнэ.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Миний хувьд Баянхонгор, Архангай, Өвөрхангай аймгаас сонгогдсон. Яг иргэдтэйгээ буцаж очоод уулзалт хийж байхад даа ялангуяа ээжүүд, эмээ нар босож ирээд үг хэлэхдээ яг хэлж байгаа юм эдээ энэ тамхи тэр дундаа энэ электрон тамхи гэдэг юмыг хориод өгөөч, хууль ингээд санаачилдаг бол энийг санаачлаад ажил болгоод өгөөч гээд. Тэгээд би их олон хууль өргөн бариагүй. Тэгэхдээ энэ хуулийг хамт өргөн барилцсан гишүүдийнх нь нэг. Тэгэхээр энийг би батлагдах ёстой хууль гэж харсан учраас дэмжиж гарын үсэг зурсан, хамт өргөн барьсан. Манай гаалийн байгууллага бол тэнд манай тэр 1 номер дээр сууж байгаа эгч бол 28 жил ажилласан цагаан хэрэм шиг найдвартай гаалийн байгууллагатай л гэж баталж байна. Гэхдээ бид нар гаалийн байгууллагаараа шаланз шаланзаар нь хэдэн их наядын нүүрсээ алдчихдаг улс. Оруулж ирж байгаа энэ тамхин дээрээ бас жоохон нүүрсээ алдаж болдог юм чинь гээд ийм хайхрамжгүй хандаад байж болохгүй. Энэ бол хүний эрүүл мэнд шүү. Энэ дээр гаалийн байгууллага онцгой анхаарч ажиллах ёстой шүү гэж онцгой анхааруулж хэлэх гээд байгаа юм.

Дээрээс нь энэ Монголбанк журам гаргадаг бол энэ арилжааны банкнуудад энэ төрлийн бизнес хийж байгаа бизнесийнхэнд зээл олгох боломжгүй шүү гэдэг энэ саналуудаа бас эртхэн шиг бодлогын бичиг баримтдаа тусгаж ажиллах ёстой гэдэг ийм бас санал байгаа юм. 20 онд 4700 ширхэг, 47 мянган ширхэг орж ирдэг байсан электрон тамхи өнөөдөр 88.2 сая ширхэг орж ирдэг болчихсон. Тэгээд энэ электрон тамхи чинь өөрөө энэ янжуур тамхийг орлох хэмжээний гэж яриад байдаг байсан. Янжуур тамхи чинь өөрөө 20 онд 3.1 тэрбум ширхэг орж ирдэг байсан. Одоо бол 3.5 тэрбум ширхэг орж ирдэг болчихсон.

Тэгэхээр бид нар энэ аль алийг нь яг эдийн засгийн аргаар буюу татвар, татварыг нь бодлогоороо дамжуулаад үнэтэй нь холбоотой асуудлыг ярьж байж л бид нар тогтоож барина уу гэхээс юу гэдэг юм. Хууль бусаар цэцэглэнэ гэдэг үгнээс нь айгаад бид нар энийг чинь өөгшүүлээд энэ чигээр нь байлгаад тамхийг нь татуулаад сууж байж болохгүй байхгүй юу. Өнөөдөр манай хүүхдүүд гэртээ шүднийхээ сойзыг хүртэл солихгүйгээр л амны эрүүл мэндийг сахиж байгаа мөртөө гудамжинд гараад тамхи татахаараа алив найздаа, алив маньдаа гээд бүгдээрээ ингээд вейпээ сольж татаад сууж байдаг чинь амны хөндийн эрүүл

мэндийн асуудал тэнд бүх тэр нян бактериа солилцоод, тэр холбогдох өвчин зовлонгоо хуваалцаад явж байгаа юм.

Тэгээд хүмүүс юун дээр очоод илүү ухаардаг вэ гэхээр явж явж байгаад уушгины хорт хавдартай болчихоод хайртай хүмүүс нь бүгдээрээ 1 хоног ч гэсэн амьд байгаач гээд гуйгаад эхлэхээр би энэ тамхинаас эрт гардаг байж дээ л гэж амаа барьдаг шүү дээ бүгдээрээ. Манай даа ялангуяа энэ нийслэлд, аймгийн төвүүдэд энэ Баянхонгор, Өвөрхангай аймгийн төвүүд бүүр утааны шаардлагагүйгээр хангалттай хэмжээний утаагаар амьсгалж байгаа шүү дээ бид нар. Зүсэн зүйлийн утаагаар амьсгалж байгаа.

Дахиад дээрээс нь энэ тамхи гэдэг хорыг татаж, өөрсдийгөө хордуулж, тэр дундаа ирээдүй үеэ дахиад энэ хорт зуршилд энд вейп чинь зүгээр зуршлыг суулгаж өгөх гээд байна шүү дээ хүүхдүүдэд. Зуршилтай болчихсон ямар нэгэн юм хум ам руугаа хийх зуршилтай болчихсон хүн дараад нь хар тамхи өөр юу байдаг юм юу ч хамаагүй ам руугаа хийхэд бид нар тамхи гэдэг үгээр өөрсдийгөө хуурч болохгүй. Тийм учраас энэ хууль заавал батлагдах ёстой. Би энэ хуулийг дэмжиж байгаа. Тэгээд ажлын хэсэгт амжилт хүсье. Над болон энэ бусад 125 гишүүн, Номιο гишүүнтэй нийлээд 126 гишүүн хийх ёстой ажил юу байна тэр болгоныг хийхэд бэлэн гэдгээ бас илэрхийлье. Амжилт хүсье.

Б.Найдалаа: Баярлалаа би ганц үг хэлье. Удахгүй бас энэний дараа санал хураалт явна. Гишүүд бас цуглаж байх шиг байна. Ер нь зүгээр ингээд саяхан бид нар ингээд сая Тамхины хуулийг 10-аад жилийн өмнө баталсан. Ингээд эргээд харахад саяхан ийм электрон тамхи вейп гэж байгаагүй. Технологийн хөгжилтэй дагаад ороод ирсэн. Бид нарын мэдэхгүй бүтээгдэхүүн гараад мэдэхгүй тооцож чадахгүй хортойгоор ингээд бид нарын үр хүүхдийн дунд, ялангуяа залуучуудын дунд их яваад байгаа. Тэгээд энийг заавал зохицуулалтад оруулах ёстой байгаа. Тэгээд хуулийн үзэл санаа энэ гэж үзэж байгаа.

Тэгэхээр тамхи бол тамхи. Утаатай байна уу, электрон байна уу ямар нэгэн байдлаар уушигилж байгаа үйлдэл нь адилхан, хор нь адилхан учраас тамхи бол тамхи учраас зохицуулалт нь байх ёстой. Тийм болохоор энэ хуулийн үзэл санаа нь ялгахгүйгээр утаатай байна уу, утаагүй байна уу, цахилгаан байна уу, электрон байна уу ижил хэмжээний татвар, ижил хэмжээний зохицуулалт ажиллана гэж үзэж байгаа. Тэгээд түрүүн хэлж байна ажлын хэсгийнхэн дэлхийн улсуудын 46 улс нь хориглочихсон байна гээд. Тэгээд 46 улс бүх улсын 4-ний 1 нь хориглочихсон байхад Монгол Улсад зохицуулалтгүй явна гэж байгаа байж болшгүй зүйл.

Тийм болохоор энэ хуулийг үзэл санааных нь хувьд, зохицуулалтынх нь хувьд бүрэн дэмжиж байгаа. Миний бие бас санаачлаад гарын үсэг зурсан гишүүдийн нэг байгаа юм. Тэгээд энэ дээр наана цаана яах вэ тохируулгын засвар хийх ажлууд гарч болно. Тэрийг ажлын хэсгийн хүрээнд энэ Байнгын хороон дээрээ нарийвчилж яриад ажиллаад залруулаад явчихна. Нэг тодорхой жоохон санал байна. Түрүүн Мөнхсайхан гишүүн гаргасан татварын орлогоор цугласан төсвийг, мөнгийг Эрүүл мэндийг дэмжих санд оруулна гэсэн байгаа юм. Тэгээд энэ дээр залруулга хийвэл зөв байж магадгүй. Яагаад гэвэл Монгол Улсад яг юунд зарах нь тодорхойгүй ийм сангууд бий болчихоод эргээд тэр нь тэгсхийж байгаад санамсаргүй байдлаар бодлогын хэмжээнд бас зарцуулчихдаг тохиолдлууд зөндөө байгаа. Зарим нь хулгайд явчихдаг, эсвэл хэрэггүй зүйлд зарцуулчихдаг, оновчгүй зүйлд зарцуулдаг.

Тэгэхээр Мөнхсайхан гишүүний гаргаад байгаа санал зөв байж болох юм шүү. Энийг бас судалж үзэцгээе. Тэр нь юу вэ гэхээр Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлээд тэндээсээ бас зориулалтаар нь зарцуулдаг ингээд тогтолцооны маягийн урт хугацааны юманд оруулах юм бол илүү зөв болоод цаашдаа зөвхөн тамхи биш өөр газраас орж байгаа орлогыг тийш нь оруулдаг маягийн зохицуулалт байвал зөв байж магадгүй.

Тэгэхгүй бол зохицуулалт болгоноос, шинэ татвар болгоноос шинэ сан үүсгээд байх юм бол тэр дээр нь бодлого нь байхгүй юм чинь үргүй зарцуулах хандлага их юм байна лээ. Тэгээд яах вэ энэ дээр энэ тамхи бол олон талын оролцоог хангаж байгаа янз янзын шүүмжүүд гарч байх шиг байна. Зарим гишүүдээс цухалзаж байна ингээд дайралтууд ч ирж байна гэж байгаа. Энийг мэдээж хэрэг хууль, ёс зүйн хүрээнд зохисгүй байвал хэлж ярих ёстой байх. Ер нь зүгээр ингээд тамхины хууль юмыг чинь тал талаас нь ярилцаж байгаад тэр болгоныг үл хэрэгсээд гэдэг юм уу хамгийн оновчтой, зөв шийдлийг нь олоод хуулиа батлах нь бид нарын үүрэг байх.

Ингээд ямар ч байсан өнөөдрийн хэлэлцүүлэгт оролцсон гишүүддээ баярлалаа. Ялангуяа манай Байнгын хорооны гишүүн биш Шижир гишүүн, Цогтбаатар гишүүн оролцож асуулт асууж, бас дэмжиж үг хэлсэнд маш их баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа.

Одоо хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл тус бүрээр санал хураалт явуулна. Санал хураалт явуулахаас өмнө сая чөлөө авсан 2 гишүүнийг ирцээс гаргах хэрэгтэй байгаа. Мөнхсайхан гишүүн, Батнайрамдал гишүүд хүндэтгэх шалтгаантайгаар чөлөө авсан байгаа. Тийм болохоор ирцээс гаръя гэсэн хүсэлт тавьсан. Ирцээс гаргаж өгнө үү. Мөнхсайхан гишүүн, Батнайрамдал гишүүн. Болчихлоо. Гишүүд санал хураалтад бэлдье. Галбадрах гишүүн ороогүй байна шүү. Энхнасан гишүүн бас ороогүй байна. Энхнасан гишүүн бас ороогүй байна. Энхнасан гишүүн арай ороогүй байна дахиад үзээрэй болох байх. Ганбаатар гишүүн санал хураалтдаа бэлдээрэй. Хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл тус бүрээр санал хураалт явуулах юм шүү..

1.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 86.7 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 86.7 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Засгийн газрын тухай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 86.7 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

4.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 80 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

5.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Гишүүдийн 86.7 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

6.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Гишүүдийн 86.7 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

7.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

Гишүүдийн 86.7 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

8.Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

Гишүүдийн 86.7 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

Дараагийнх нь “Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

Гишүүдийн 86.7 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

Дараагийнх нь Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

Гишүүдийн 86.7 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл тус бүрээр санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах уншиж танилцуулна. Баярлалаа.

Дараагийн асуудалдаа оръё. Дараагийн асуудалдаа оръё.

14.56 цаг

“Засгийн газар чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

2025 оны 8 сарын 26-ны өдөр Боловсрол шинжлэх, ухааны дэд хорооны гишүүд салбарын холбогдох хууль, эрх зүйн актын хэрэгжилтийн талаар 2025 оны 9 сарын 23-ны өдөр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд Боловсролын салбарын 2026 оны төсвийн төслийн танилцуулга сэдвээр Боловсролын сайд Наранбаяр тус тус мэдээлэл хийсэн. Уг мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан саналыг үндэслэн боловсролыг дэмжих жилийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгох талаар Байнгын хорооны тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүд боловсруулан танилцуулж байна.

Уг тогтоолын төслийг Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны 2025 оны 11 сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, гишүүдийн саналыг нэмэлт тусгасан болно. Ингээд байнга Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа албан тушаалтныг танилцуулъя. Ажлын хэсэг нь байвал оруулаарай. Орчихсон уу? Боловсролын сайд Наранбаяр байгаа. Боловсролын яамны Сургалтын хөтөлбөр, үнэлгээ, хүний нөөцийн бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан шинжээч Э.Батсэлэм, Сургуулийн өмнөх боловсрол, боловсролын удирдлагын байгууллагын төсөв, санхүүгийн бодлого төлөвлөлт, эдийн засгийн шинжилгээ хариуцсан шинжээч Гансүмбэрэл.

Одоо Байнгын хорооны тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны дарга С.Зулпхар танилцуулна. Сулпхар гишүүний микрофоныг нээе.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны гишүүдээс Монгол Улсын Их Хурлын Байнгын хороогоор тогтоол гаргуулахаар санал санаачилга гаргасан юм байгаа юм. Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү, Д.Бум-Очир, А.Ганбаатар, Ж.Галбадрах, Ц.Мөнхтуяа, Д.Рэгдэл, Г.Хосбаяр, Б.Хэрлэн, С.Зулпхар нар ийм тогтоолын төсөл бэлэн болгосон байгаа.

Тогтоолын төсөл Монгол Улсын Засгийн газраас 2026 оныг Боловсролыг дэмжих жил болгон зарласантай холбогдуулаад Боловсролыг дэмжих жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх тодорхой үйл ажиллагаануудыг энэ тогтоолд тусгасан байгаа.

Тогтоолын төсөл боловсруулахтай холбоотойгоор холбогдох байгууллагуудаас санал авсан. Тэрнээс гадна Улсын Их Хурлын гишүүд, дэд хорооны гишүүд, Байнгын хорооны гишүүдээс бас санал авсан байгаа. Энэхүү саналыг дэд хороон хороогоор бид хэлэлцсэн. Энэ хэлэлцсэний үр дүнд бид 3 зүйл, 4 дэд зүйл, 24 заалт бүхий тогтоолын төсөл бэлэн болсон байгаа. Тогтоолын төслийг боловсролын салбарыг бүхэлд нь харгалзсан байдлаар сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын чиглэлээр, мэргэжлийн болон техникийн боловсролын чиглэлээр, түр болон богино хугацааны сургалтын чиглэлээр, дээд боловсролын чиглэлээр, цаашлаад жишээ нь, боловсролын салбарын ажилтан, албан хаагч, багш нарын цалин хөлсний бодлогын чиглэлээр, цаашлаад жишээ нь энэнтэй уялдсан бусад арга хэмжээ гэсэн байдлаар энэ тогтоолын төсөл бэлэн болсон. Тогтоолын төсөлд бидний хувьд тулгамдаж байгаа тодорхой асуудлуудыг саяын хэлсэн жишээ нь дэд тогтолцоо болгоноор нь тодорхойлоод үндэстэйгээр

хэрэгжүүлэх бүх нөхцөлүүдийг нарийвчлан судалсны үндсэн дээр ийм тогтоолын төсөл бэлэн болсон байгаа. Тэгээд та бүхэн асуулт асуувал хариулахад бэлэн байна. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуух асуулт гишүүн байгаа юу?

Мөнхтуяа гишүүн нэрээ оруулчих. Мөнхтуяа гишүүнээр нэрийг тасаллаа. Рэгдэл гишүүнээс. Мөнхтуяа гишүүн эхлэх үү? Төрийн нарийн ороод ирлээ. Сайд одоо ороод ирэх байх. Мөнхтуяа гишүүний микрофоныг нээе.

Ц.Мөнхтуяа: Би зарчмын асуултууд асууна боловсролын яамныхнаас. Ер нь бид нар энэ 25 оныхоо асуудлыг шийдээгүй байж 26 оны тогтоолын төсөл ингээд батална гээд сууж байгаа нь үнэхээр харамсалтай байна. Яагаад гэхээр энэ бид нар ингээд боловсролын жил энэ тэр гээд сайхан сайхан юм яриад л байна л даа. 26 оныг Боловсролыг дэмжих жил болгоно гээд. Тэгээд 12 сарын 15-нд төсвийн 25 оны төсвийн жил дуусна. Энэ дуусах гэж байгаа хугацаанд амжих уу? Энэ олон асуудлууд овоорчихсон байна. 26 оны юм ярихаас илүү би 25 оныхоо асуудлуудыг дуусгая гэж бодож байна. Энэ боловсролын салбарын төсөв, санхүүжилт, санхүүгийн одоогийн нөхцөл байдал чинь ер нь юу болоод байна аа? Сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, нярав, нягтлан гээд багш нар гээд бөөн гомдлууд ирж байна. Одоо боловсролын салбарын багш, ажилтнуудын цалин хөлс бүрэн олгогдож байгаа юу нэгдүгээр асуудал.

Хоёрт нь нэмэгдэл, нэмэгдэл хөлсүүд олгогдож байгаа юу? Дандаа олгогдохгүй байна гэж ирээд байгаа байхгүй юу. Гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал 9 сараас хойш олгогдоогүй гэсэн ийм гомдол ирсэн. Сургууль, цэцэрлэгүүд НДШ-ийн өр төлбөртэй яваад байгаа гэдэг бас мэдээлэл ирсэн. Мөн хувьсах зардлаар санхүүждэг багшийн бичиг хэргийн зардал, бусад зардлууд бүгд орохгүй байна гэсэн гомдлууд ирж байна. Анги танхимын ариутгал, цахим хэрэглээний зардал ингээд бүх асуудлууд чинь байхгүй, нөгөө тавьсан мөнгө чинь байхгүй. Энийгээ хэзээ өгөх юм бэ? Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа багш нарын 5, 3 жилийн тэтгэмж яагаад олгогдохгүй байна вэ Батжаргал даргаа? Мөн багш, ажилтны тэтгэвэрт гарахдаа авдаг 36 сарын тэтгэмжийг яагаад өгөхгүй байна. Эндээс харахад бүхэлдээ боловсролын салбар хариуцлагагүйн зуд нүүрлэсэн байна гэж дүгнэхээр байна. Тэгээд энэ 7 хоногтоо багтаагаад сайн мэдээлэл авъя. Шаардлагатай бол Байнгын хороо бас хугацаатай тогтоол гаргаж өгье гэж бодож байна. Ийм горимын санал байна. Тэгээд бүүр болохгүй бол Сангийн яамныхныгаа ч дуудъя. Та нараас асуухаар Сангийн яам гээд байдаг тээ тэгээд Сангийн яамныхантай чинь бид нар цуг уулзъя. 25 оны асуудлууд нь хэвээрээ байхад бид нар 26 оны юм яримаар гүй байна зарчмын хувьд.

Б.Найдалаа: Хариулт Батжаргал дарга микрофон 1.

Ц.Мөнхтуяа: Наранбаяр сайд яасан юм?

Х.Батжаргал: Гишүүний асуултад хариулъя. Батжаргал Боловсролын яам. Боловсролын салбар, боловсролын сайдын багц урсгал зардал, урсгал санхүүжилт бол ямар нэгэн ялангуяа цалин хөлсөн дээр ямар нэгэн хоцрогдол болоод олгогдохгүй байгаа тийм бэрхшээл байхгүй байгаа. Одоогийн байдлаар бидэнд энэ санхүүгийн гүйцэтгэлээр ирсэн мэдээллээр 10 сарын эцсийн байдлаар

гүйцэтгэл гарсан байгаа 77 хувийн гүйцэтгэлтэй байгаа. Цалин болон нэмэгдэл хөлс нэмэгдэл дээр ямар нэгэн дутагдал, хасагдсан ийм зөрчил хүлээгдэж байгаа гүйцэтгэл байхгүй.

Харин гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллын асуудал 4 дүгээр улирал цалинтайгаа сүүлд бодогдож ордог. Бусад зарим нэгэн санхүүжилт төсвийн орлогын эх үүсвэртэй холбогдуулж зарим нэгэн зардлыг эрэмбэлэх тэгээд 11 сард байх хуваарь 12 сар руугаа шилжих гэх мэт зарим нэгэн зохицуулалтын ажлууд хийгдэх асуудал гарч байгаа. Гэхдээ цалин мөнгөтэй холбоотой, багш нартай холбоотой авах ёстой цалингийн асуудал ямар нэгэн хугацааны хоцрогдол болоод саатал байхгүй гэдгийг тодотгож хэлье.

Б.Найдалаа: Мөнхтуяа гишүүн яах юм?

Х.Батжаргал: Тэтгэвэр тэтгэмжийн тухайд хөдөө орон.../үг тасрав./

Б.Найдалаа: Байж байгаарай. Мөнхтуяа гишүүн тодруулаад Зулпхар гишүүн араас нь дараа хариултаа өгөх үү тээ? Мөнхтуяа гишүүн тодруул.

Ц.Мөнхтуяа: Батжаргал дарга энэ гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллууд чинь 9 сараас хойш орохгүй байна гэж байна. НДШ-ийн өр төлбөр яваад байна гэж байна. Тэгээд бичиг хэргийн зардал, цахим хэрэглээний зардал, эрүүл мэндийн зардал гээд бусад зардлууд чинь бүгд байхгүй ороогүй байна гээд гомдлууд ирээд байна. Дээрээс нь 5, 3 жилийн тэтгэмж орохгүй байна гэж байна. Энэ бүх юмнууд нь хэзээ орох вэ гэдгийг л асуугаад байна багш нар.

Б.Найдалаа: Зулпхар гишүүн хариулах уу үгүй юү саяынх дээр? Батжаргал дарга микрофон 1.

Х.Батжаргал: Гишүүний асуултад нэмж тодруулъя. Тэгэхээр гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал 3, 4 дүгээр улиралд орохоор байгаа. 3 дугаар улирал буюу 9 дүгээр сард олгогдчихсон байж байгаа. Олгогдчихсон. Одоо 12 дугаар сард 12 дугаар сарын 10-аар олгогдохоор тооцоолол төлөвлөгөөнд орчихсон хүлээгдэж байгаа гэсэн үг. Тэгэхээр 12 сардаа багтаад буюу ондоо багтаад гүйцэтгэлийн үнэлгээний 4 дүгээр улирал багтаж урамшуулал нь орно.

Б.Найдалаа: Мөнхтуяа гишүүн та микрофон дээрээ тодруулчих. Мөнхтуяа гишүүн тодруулъя. 1 тодруулга байгаа.

Ц.Мөнхтуяа: Батжаргал даргаа бусад нэмэгдлүүдийг асуугаад байгаа байхгүй юу. Дата, бичиг хэрэг, эрүүл мэнд, цахим хэрэглээ тэгээд 5, 3 жилийн нэмэгдэл гээд зөндөө олон асуудал байгаа байхгүй юу. Тэгээд 25 оныхоо асуудлыг шийдээгүй байж бид нар энд 26 оны юм яриад суух нь зарчмын хувьд нийлэхгүй байна гэж бодож байна.

Б.Найдалаа: Микрофон 1.

Х.Батжаргал: Тийм ээ, гишүүний асуусан энэ бусад нэмэгдлийн асуудал эхний ээлжид ямар ч байсан цалин, тэтгэмж, гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал олгох ёстой бүх нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг олгоод харин таны асуултад орсон тэр бусад нэмэгдлүүдийг бусад зарим нэгэн төсвийн орлоготой уялдсан эрх нээгдэж байгаа энэ санхүүжилтийнхээ хүрээнд эрэмбэлээд бусад эх үүсвэрээ

дайчлаад ингээд олгоно. Хамгийн гол нь бас орон нутаг багш, албан хаагчдын хувьд 12 сард багтаж энэ бүрэн олгогдохоор төлөвлөгдсөн байгаа гэдгийг хэлэх байна.

Б.Найдалаа: Баярлалаа. Зулпхар гишүүн микрофоныг нээе.

С.Зулпхар: Мөнхтуяа гишүүний асуулт бас саналтай холбогдуулж би бас эндээс хариулт өгье. Манай дэд хорооноос гишүүд маань ирэх жилийг боловсролын дэмжих жил болсонтой холбогдуулаад боловсролын салбарт бүхэлд нь хэрэгжүүлэх асуудлуудыг багтаасан үйл ажиллагаануудыг санал болгож энэ тогтоолын төсөл гаргаж байгаа. Тэр дотор бас таны өөрийн чинь санаачлаад бас та өөрөө энэ асуудлын араас байнга явж байгаа. Сургуулийн багш нарын, ажилтнуудын цалин хөлсний асуудал байгаа. Энэ тогтоол дээр тогтоолын манай төслийн 2 дугаар зүйл болж орж ирсэн. Сая бас их тодорхой зүйл хэлж байна. 25 оныхоо юмыг шийдээгүй байж байж 26 оноо яах вэ гэж. Яг энэнтэй уялдсан байдлаар бид энэ асуудлыг оруулсан гэдгийг хэлмээр байна. Ер нь бидний энэ тогтоолын төсөлд орсон асуудлууд дээр өнгөрсөн хугацаанд өмнө жилийн ч биш, тэрний өмнөх шинэ жилүүдэд эхэлчихсэн хийгдээд явж байгаа. Зарим нь шийд хүлээгдэж байгаа ийм асуудлууд байгаа учраас энд оруулна гэдэг ийм жишээ нь зүйл яригдсан. Би энэ орсон.../минут дуусав./

Б.Найдалаа: Нэмж хариулъя. Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Цалин хөлстэй холбогдуулаад сургуулийн өмнөх болон ЕБС, мэргэжлийн боловсролын сургууль, политехникийн коллеж, насан туршийн суралцахуйн төвүүдийн багш, ажилтны цалингийн бүтцийг оновчтой болгох, цалин хөлсийг үе шаттайгаар нэмэгдүүлэх бодлогыг тогтвортой хэрэгжүүлэх гээд энэ. Тухайлбал таны хэлж байгаа гол санал байгаа. Энийг бид нар тогтвортой хэрэгжүүлэх ёстой. Гэхдээ энэ дээр цалин хөлсний бүтцийг гарсан саналууд байгаа та сайн мэдэж байгаа. Тэрэнтэй уялдсан байдлаар энийг та бүхэн хэрэгжүүлээч гэж байгаа юм. Тогтоолын төслийн хэрэгжилтийг бид нар ирэх жишээ нь хаврын чуулганаас эхлээд тогтоолын хэрэгжилтийг танилцаад эхэлнэ гэсэн ийм чигтэй байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Ганхүлэг гишүүнийг асуух асуулт гишүүнд нэмье. Эрдэнэбат гишүүн бас нэмье. Өнөөдөр хэлэлцэж байгаа асуудал тогтоолын төсөл. Тэгэхээр гишүүд маань бас саналаа өгсөн, бас үзсэн, ярилцсан. Яг энэ тогтоолын төсөлтэйгөө аль болох холбоотой тодорхой асуулт асууж, үг хэлэхийг хүсье. Ганхүлэг гишүүн микрофоныг нээе.

М.Ганхүлэг: Бас санал хэлэх, асуулт асуух боломж олгосонд баярлалаа. Тогтоолын төсөлтэй холбогдолтой нэлээн чухал бас агуулгууд бас орж ирж байгаа юм байна. Тэгэхдээ бас зохион байгуулалтын хувьд нэлээн тулаад бас мэдээлэл авчихлаа Байнгын хороон даргаа тодорхой бас саналуудаа бас нэмэлтээр өгөх боломж юмнууд бас юу байх болов уу үгүй болов уу? Би ямар ч байсан өөрийнхөө саналуудыг томъёолоод асуугаад тэгээд бас саналаа бас тусгуулах саналуудаа хэлээд явчихъя гэж бодож байна. Боловсролын зээлийн сантай холбогдолтой асуудлыг нэлээн бас хөндөөд бас яриад байгаа. Та бид ерөнхийдөө санал солилцсон. Энэнтэй холбогдолтой ямар заалт агуулгууд бас энд орж байгаа вэ? Боловсролыг дэмжих жилийн хүрээнд нэлээн том бас өөрчлөлт авч хийх ёстой нэг хэсэг бол энэ боловсролын зээлийн сангийн үйл ажиллагааг нэлээн сайжруулах чиглэлийн ажлыг бид бүхэн бас хийж амжуулмаар байгаа юм. Үүнтэй

холбогдолтойгоор үндсэндээ Боловсролын хөгжлийн сан болгоё гэдэг ийм агуулга бас яриад байгаа. Бараг 80, 90 хувь нь буцаан төлөгдөхгүй ийм тусламж хэлбэртэй болчихоод байгаа асуудлыг ер нь Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагааг заавал ч үгүй эргэн төлөх ийм хэлбэр рүү оруулаад тэрийг нь шахдаг тэр тодорхой процесс тэр журмуудыг нь илүү сайжруулах ажлуудыг нэлээн оруулаад ингээд явах нь зөв байна гэсэн эхний санаа байгаа юм.

Хоёрт нь тодорхой 10-20 хувийг нь энд зээлийн сан дээр эхний жилдээ бид бүхэн бас нэмэгдүүлэхгүйгээр нийт орж ирж байгаа энэ бас санхүү, хөрөнгийн 10-20 хувийг нь гадаадаас багш боловсон хүчнийг авчирч, 1 оюутныг гадаадад сургах биш Монголдоо байгаа бараг 100 мянган оюутныг сургах чиглэлийн энэ хөтөлбөрийг туршиж эхэлье гэсэн ийм санааг бид нар яриад байгаа. Тэгэхээр энэ тодорхой саналууд бас орох боломжтой юу, орсон уу?

Гурав дахь нь ер нь бид нар Дэлхийн топ сургуулийг Монголдоо авчрах чиглэл дээр яах вэ гэдэг айн, гэдэг энэ чиглэл дээр бас яах вэ гэдэг ийм тодорхой саналууд өмнөх уулзалтууд дээр гаргасан. Яг ийм тогтоол гарах гэж байгааг би бас мэдээгүй байж байгаад саналаа бас оруулаагүй байна. Энэ саналуудыг бас оруулъя гэсэн саналтай байна. Орсон уу гэдгийг бас асууя.

Хүүхдийн үдийн цай хөтөлбөрийг бид бүхэн яриад байгаа бүгдэд нь олгоё гээд. Энийг үе шаттай явуулмаар байгаа юм. Хүүхдийн үдийн цай хөтөлбөрөөс гэхээр зардал нэлээн өндөр байгаа, бас бэлтгэл ажлын хувьд хангалтгүй байгаа учраас эхний удаад ер нь бүх хүүхдүүддээ сүү өгдөг больё гэдэг энэ тооцоо судалгааг Боловсролын яам дээр хийгдээд ингээд явж байгаа. Тэгэхээр энэ рүү ер нь зүгээр зорих энэ чиглэлийн судалгаа юмнуудыг энэ жилдээ сайжруулаад ирэх жилээс алхах энэ агуулгуудаа бас эндээ оруулбал яасан юм бэ?

Нөгөө талдаа сүү үйлдвэрлэж байгаа орон нутгийн аж ахуйн нэгжүүдээ дэмжих ийм зах зээлийн энэ боломжууд бас гарч ирэх юм.

Зуны хугацаанд Монголын бүх сургууль, бүх их, дээд сургуулиуд хоосон байгаад байна. Тэгэхээр энэ зуны хугацаанд энэ насан туршийн боловсролын асуудал, малчдыг сургах асуудал гээд тодорхой ийм асуудлуудыг бас бид нар энэ байгаа боломжоо ашиглаад хийвэл яасан юм бэ гэдэг энэ саналыг бас би өмнө нь бас хэлж илэрхийлж байсан. Тэгээд энэ чиг.../минут дуусав./

Б.Найдалаа: Минут болсон уу? Болсон тэгвэл. Баярлалаа. Асуулт байсан уу? Үг. Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Ганхүлэг гишүүнд маш их баярлалаа. Та бас тогтоолын төсөл батлуулж байсан өнгөрсөн хаврын чуулганаар залуучуудын асуудлаар. Бид бас таны батлуулсан тогтоолын төслийг судалж үзсэн. Тэрнээс гадна гарсан саналуудыг энэ тогтоолын төсөлтэй уялдуулах чиглэлээр бас ажилласан юм байгаа юм. Нэн ялангуяа та бол Боловсролын зээлийн сан, энэ ямар нэгэн байдлаар их, дээд сургуулиудад, гаднын их, дээд сургуулиудаас зочин профессоруудын зочин багш нарыг урьж хичээл заалгуулах байдлаар гаднын багш нараас хичээл сонсох энэ боломжийг өргөжүүлбэ, нэгэнтээ гадагшаа явах нь хязгаартай учраас гэсэн ийм санал гаргаж байсан. Би энэ тогтоолын төслийн 19 дээр дэлхийн шилдэг сургуулийн зэрэглэлийн жагсаалтад эхний 50-д багтсан сургуулиас өндөр ур чадвартай багш, мэргэжилтнийг урьж ажиллуулах үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ гээд ингээд оруулчихсан байгаа юм. Энэ их, дээд

сургуулиуд хийж байгаа. Гэхдээ энийг бид бодлогын түвшинд энийг зохион байгуулъя гэсэн ийм бодолтой байгаа. Ингэж байж бид бага өртгөөр Монгол оюутнууд гаднын их, дээд сургуулиудын жишээ нь зочин профессоруудын хичээлийг сонсох, тэндээс мэдлэг авах боломжийг нээнэ гэсэн.

Хоёр дахь зүйл 20 дугаар зүйл дээр байгаа юм. Энэ манай их, дээд сургуулиудын зайлшгүй хийх хийх ёстой Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт ч гэсэн энэ тусгагдсан зүйл байгаа юм. Дээд боловсролын сургалтын байгууллагын тодорхой хөтөлбөрүүдийг олон улсын магадлан итгэмжлэлд хамруулж, суралцагчид олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дипломтой түвшин нөхцөлийг бүрдүүлнэ гээд. Эхний байдлаар ингэж хос дипломтой төгсөх, олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн дипломтой төгсөх хөтөлбөрүүд манайд бий болчихсон. Тухайн Санхүү эдийн засгийн дээд сургууль, Удирдлагын академи гэхэд сая төрийн удирдлагын хөтөлбөрийг олон улсын магадлан итгэмжлэлд оруулаад олон улсын хөтөлбөртэй болчихлоо. Тэгэхээр бид ингэж байж их, дээд сургуулиудын сургалтын байгууллагуудын чанарыг нэгдүгээрт дээшлүүлэх, хоёрдугаарт суралцагчдын төгссөн улсуудын чанарыг дээшлүүлэх ийм боломжтой гэж үзэж байгаа учраас таны санал энд тухайлан жишээ нь тусалсан шүү гэдгийг хэлье.

Нөгөөтээгүүр таны саяын хэлсэн 2 санал байгаад байна. Үдийн цай болон бусад их, дээд сургуулиудын менежменттэй холбоотой асуудлыг. Та энэ саналаа бас тухайлан бас нэмж энэ тогтоолын төсөлд тусгуулж болно.

Б.Найдалаа: Баярлалаа. Ганхүлэг гишүүн тодруулж асууя.

М.Ганхүлэг: Баярлалаа. Орчны хүртээмжтэй холбогдолтой асуудал бүх ер нь 10 жилийн сургууль, их дээд сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүд дээр байгаа. Ялангуяа сая бас бид Саранчулуун гишүүнтэй хамтарч “Гэрээсээ гарцгаая” аяны оюутны хэлэлцүүлгийг би бас дэд хороон даргын хувьд бас зохион байгуулсан. Монгол улсад нийтдээ 18-34 насны ид суралцах ийм насны 18800 орчим хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа юм билээ. Эдгээр иргэдийн 98 хувь нь гэртээ байгаа. Тэгэхээр тусгайлан юу эдгээр иргэд рүү чиглэсэн хүртээмжийг нэмэгдүүлэх, ялангуяа энэ хувийн туслахын үйлчилгээ, мөн энэ тохируулгыг хөгжлийн бэрхшээлтэй иргэн болгон дээр хийхтэй холбогдолтой ийм бас саналууд байгаа юм. Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбогдолтой асуудлыг тусгасан уу нэмэх боломжтой юу гэж.

Б.Найдалаа: Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Баярлалаа. Маш чухал асуулт. Хуулиар тэгш хамран сургахтай уялдсан тухайлсан зохицуулалтууд байгаа. Бүх сургуулиуд, ЕБС-иуд хөгжлийн бэрхшээлтэй суралцагч нарт тохиргоотой шинэ сургалт зохион байгуулах ийм үүрэг хүлээсэн. Энэнтэй уялдсан байдлаар бид сая санал авахад тухайлсан санал ирээгүй. Энэнтэй уялдсан байдлаар саналаа оруулж болно. Бид энийг Саранчулуун гишүүн, Ганхүлэг гишүүн тухайлсан ийм заалт оруулах юм бол бид энийг оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Б.Найдалаа: Баярлалаа. микрофон 1 нэмж хариулна.

Х.Батжаргал: Баярлалаа. Гишүүний асуулт дээр нэмж бас тодотгож хэлэхэд яг бас бидний өмнөх уулзалтаар бас ярилцаж байсны дагуу Боловсролын зээлийн

санг бас Боловсрол хөгжлийн сан болгож хөгжүүлэх зохион байгуулалтын хэлбэрийг засаглалын хувьд хөрөнгө оруулалт, санхүүжилтийг бүрдүүлэх эх үүсвэрийн хувьд ингээд шинэ зохион байгуулалтаар оруулах анхан шатын тандан болон үндсэн бүх төрлийн судалгаанууд МУИС, МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнтэй хамтраад ерөнхийдөө ингээд бэлэн болж байгаа. Тэгэхээр дараагийн шатад бид бас Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу процессыг үргэлжлүүлээд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн асуудал гээд бас Их Хуралтай, Байнгын хороотой хамтарч ажиллаад шинэ шатад гаргах ажлууд бас хүлээгдэж байгаа. Бидний уулзаж ярилцсанаас хойш бас нэлээн ахиц гарсан гэдгийг бас энд тэмдэглэж хэлье.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд бас гэрээр боловсролоо эзэмших боломжийг нь бас нэмэгдүүлэх чиглэлээр бид бас өчигдөр дэд хороон дээр бас яригдаж байсан энэ.../минут дуусав./

Б.Найдалаа: Гүйцээж хариулъя 1.

Х.Батжаргал: Цахим цахим сургуулийг бид бас албан ёсоор Засгийн газрын тогтоолоор байгуулж байгаа. Тэгээд цахимаар боловсролоо эзэмших сургууль завсардсан болон сургуулиар бүрэн хамрагдаж чаддаггүй байгаа дотоодод болон гадаадад бас энэ бэрхшээлтэй байдаг энэ асуудлуудыг бас цогцоор нь шийдэхээр энэ цахим сургуулиар дамжуулж шийдэхээр Засгийн газрын тогтоолын хэрэгжилт ингээд хангагдаад явна. Үүн дээр төсөв, санхүү болон хувьсах зардал тэр нарийвчилсан зохион байгуулалт Боловсролын яаман дээр хийгдээд үйл ажиллагаагаа энэ ондоо багтааж эхлүүлэх гэж байгаа гэдгийг хэлье.

Б.Найдалаа: Ганхүлэг гишүүн тодруулна.

М.Ганхүлэг: Нэмэлт тодруулахаас юу болчихлоо. Саяын миний зохион байгуулж байгаа уулзалтуудаар ер нь гэрт нь байлгах, цахимаар хязгаарлах энэ тэр гэдэг ийм саналууд харин ч гаргахгүй байлаа шүү дээ. Та хэд яг ямар судалгаанд үндэслэж үндсэндээ ийм цахим сургалтын агуулгуудыг дэмжихээр болоод ингээд бас яриад болж байгаа юм? Магадгүй мэдээжийн хэрэг тийм хүсэлтэй хүмүүс хэр их байгаад байгаа юм? Яг би тэргэнцэртэй иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, мөн асран хамгаалагч байгаа хүмүүстэй бүгдтэй нь ингээд уулзаад үзэхэд энгийн нийгэмд оролцмоор байна гээд байгаа байхгүй юу. Оролцмоор байна. Тэгээд яг л бусдын адил ингээд заавал тусгай ийм сургууль биш бусдын адил ингээд бас суралцмаар байна энэ тэр гэдэг ийм агуулга руу л үндсэндээ яриад байгаа юм л даа. Тэгэхээр наадах чинь буруу ийм ойлголт руу бас явчих вий дээ. Та хэд ямар судалгаа хийв?

Б.Найдалаа: Микрофон 1.

Х.Батжаргал: Энэ нэмэлт тодруулга дээр бас залруулах хэрэгтэй болж байх шиг байна. Энэ яг гэртээ сургуульд хамрагдах боломжгүйгээр суралцах тэр тэгш боломжийг нь хангах зорилгоор бид нар бас шинэ хөтөлбөр боловсруулж цахимаар олгох гэж байгаа. Хуулийнхаа дагуу тэгш хамран боловсролыг нь дэмжиж сургуулийн, ЕБС-ийн хамрагдах хувьсах зардлыг нь жирийнхээс 3 дахин илүү санхүүжилтийг олгоод яг жирийн хүүхдийнхээ адил найз нөхдийнхөө дунд бүрэн хамрагдах энэ бололцоог нь бүрэн дэмжээд хуульчлагдсан энэ хуулийн хэрэгжилт хангагдаад явж байгаа гэж.

Б.Найдалаа: Баярлалаа. Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

С.Эрдэнэбат: Боловсролын жил ямар ч байсан угтаад багшийнхаа үндсэн цалинг улсын дунджаас дээшээ болгоод авч байгаа энэ том улс төрийн шийдэл. Хэдийгээр хэрүүл маргаантай янз бүрийн хардлага сэрдлэг олон талаас авч үзсэн ч гэсэн ингэж хөдлөх ёстой байсан юм. Тэгээд энийг цаашдаа ер нь тогтвортой барьж явах нь маш чухал. Тийм ч учраас таван жилийн үндсэн чиглэлд ер нь бид нар боловсрол, эрүүл мэнд гээд энэ суурь салбарынхаа хүмүүсийн цалингийн өрсөлдөх чадварыг байнга бодож байхгүй бол өнгөрсөн хойно нь, хаяад явчихсан хойно нь араас нь хөөх байдлаар явна гэдэг өөрөө асар их цаг хугацааны хувьд болон хүний нөөцийн алдагдлын хувьд томоохон хохирол амссан ийм болж хувирсан. Энэ дээр багшийн цалин хөлсний асуудлыг гол түлхүүр асуудлын нэг.

Цаашдаа өнөөдөр багшийн мэргэжлийг сонгох гэж байгаа хүүхэд ер нь Засгийн газраас ойрын 5, 10-н жилдээ ямар хэмжээний цалин хөлс, урамшуулал, нийгмийн хамгааллын бодлого байх ёстой юм бэ гэдгийг хардаг. Тэгж байж энэ дээр боловсон хүчин илүү өрсөлдөөнтэй, чанартай болно. Тийм учраас энд цалин хөлсний асуудал дээр ер нь яг тодорхой бас санал тавих хэрэгтэй гэдгийг бас хэлмээр байна. Сая энэ багш нарын үндсэн цалинг нэмэгдүүлэхэд ерөнхийдөө хөдөлмөрийн арбитр ч гэсэн ер нь энийг ер нь жилдээ дор хаяж инфляц дээрээ нэмэх нь 20 орчим хувь буюу нийтдээ 30 орчим хувь нэмэгдүүлье гэдэг ийм л зүйлийг гаргасан. Одоо бол манай зарим хүмүүс пүү паа багш нарын цалин ингээд өсчихлөө гээд. 200 доллароор л нэмж байгаа юм л даа хөөрхий он гараад. 200 доллароор. Өнгөрсөн жилийн. Энэ жилийн хувьд хоцорсон бид нар 6-хан хувиар нэмсэн. Тэгэхээр энэ өөрөө нэлээн том түлхэц болно.

Хоёрдугаар бас нэг чухал зүйл байна. Хөдөө орон нутгаар сумуудаар нэлээн явлаа. Тэнд багш нар очиж байна. Хөөрхий орон байр ерөөсөө байхгүй. Нэг гэрт амьдардаг юм байна. Тэгээд үндсэндээ шантраад эмэгтэй багш нар голдуу байдаг хүмүүс эмч нар ч мөн ялгаа байхгүй тэгээд буцдаг. Тийм учраас энэ тал дээр орлогод нийцсэн орон сууц. Сумын төв дээр хөөрхөн 8 айлын орон сууцын зураг төсөл гаргаад тэрийгээ Барилга хөгжлийн яам болон энэ Ипотекийн корпорац Орон сууцжуулалын тэр банк эд нартайгаа нийлж байгаад ийм хөтөлбөр болгоод хэрэгжүүлээд явчихвал тэнд хүний нөөц тогтох хамгийн гол хөшүүрэг болохоор байна гэдгийг хэлмээр байна.

Тийм учраас эргээд тэрүүгээрээ моргейжээр цалин хөлсөөрөө төлөх боломж нь бас хөрсөн суурь нь тавигдаж байгаа учраас энэ орон сууцын асуудал гэдэг зүйлийг тогтоол дээр бас маш том хүлээлтийн асуудал байгаа учраас зөвхөн хөдөө орон нутаг биш. Энэ дахин дэд төвүүд дээр багш, цэцэрлэг, эмнэлэг гээд энэ орон сууцын хөтөлбөрт хамруулна гэдэг саналыг оруулаад өг.

Тэгээд редакцын шинж чанартай нэг юм байна. Тэр 2030 он хүртэл багшийн дутагдлыг бодитоор хориглох төлөвлөгөө гаргана гээд энэ найруулгын алдаа юу? Тэрнээс наана хүртэл ямар нэгэн бодитой төлөвлөгөө гаргахгүй гэж ойлгогдох гээд байх шиг байна. Энийг жоохон зас.

Б.Найдалаа: Санал, үг хэллээ гэж. Баярлалаа. Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Энэ түрүүн хэний асуултад бас жоохон юу яагаад байна л даа буруу л хариулаад байна л даа хэн ээ Боловсролын яам. Хувьсах зардал чинь СӨБ болон бага ангид байгаа билүү? Эсвэл 10 жилийн дунд анги, ахлах ангид

бүгдээрэнд нь оногдож байгаа билүү хувьсах зардал? Бүх ангид байгаа тээ? Ганхүлэг гишүүн болохоор түрүүн насыг нь хэллээ шүү дээ. 18-30 нас буюу оюутны нас яриад байгаа байхгүй юу. Оюутнууд буюу оюутны сурах боломжтой энэ дээр ямар ч оролцоо алга. Энэ дээр та нар ямар ажил хийж байна гэхээр дунд сургуулийн хувьсах зардлын дүнг хариулдаг чинь ямар учиртай юм? Ингэж хариулахгүй шүү.

Хоёрдугаар юм. Одоо би асуулт асууя. 14 мянган орчим хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагаас 12 мянган СӨБ болон ЕБС-ийн насны хүүхдүүд байгаа. Боловсролыг дэмжих жил гэж зарласан. Тэгвэл одоо энэ жил 26 онд суралцах орчин, хэрэглэгдэхүүн, хүртээмж дэмжих үйлчилгээ дээр яг бодитой ямар ажил төлөвлөсөн бэ? Хэрвээ төлөвлөөгүй бол энэ тогтоол дээрээ оруулах хэрэгтэй. Нарийн төлөвлөгөө. Би 26 оны төлөвлөгөөнөөс нарийн бас харахгүй байгаа байхгүй юу.

Дараа нь тэгш хамран сургах боловсролын бүлэг гээд хуульдаа бүүр оруулчихаад байгаа мөртөө энэ ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийн эрхийг хэрэгжүүлэх бодлого, зохион байгуулалтын ажлыг ямар бүтэц, нэгж хариуцах юм. Одоо яаман дээр байгаа тэр бүтэц чинь байхгүй болчихсон гэж байна шүү дээ. Тэгээд тэрийгээ яаж зохион байгуулах юм? Шинэ зохион байгуулалтын загвар ямар төлөвлөгөө гаргаж байгаа юм? Дотор нь байгаа хүмүүс нь өөр өөр бүтэц рүү явчихсан юм бол хуучин байгаа ажил нь яах вэ? Би судалгаа асуугаад холбогдохоор байхгүй ээ, манайх татан буугдчихсан, манай хэлтэс байхгүй гээд хариулаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг яах вэ?

Яагаад би энийг асууж байна гэхээр тэгш хамран сургах бодлого чинь зөвхөн багшийн асуудал биш энэ чинь хүртээмжтэй орчин хэрэгтэй, дэмжих үйлчилгээтэй туслах ажилтан, багшийн туслах эцэг эхийн оролцоо гээд ийм олон оролцогч талууд оролцсон ийм тогтолцоо шүү дээ. Тэгээд энийг чинь бодлогоор хангаад шаарддаг бүтэц энэ тэр уул нь 23 оныхоо хуулиа дагаад оруулсан байтал яагаад яаман дээр энэ бүтэц нь буцаад байхгүй болоод ингээд солигдоод байдгийг би ерөөсөө ойлгосонгүй. Тэгээд энийгээ дагаад улсын хэмжээнд стандарт гаргана, ийм ийм зүйлүүдийг хийнэ гэж байгаа мөртөө тэрийг нь хэн нь аль бүтэц нь хэмжиж, үнэлж гаргах вэ яамны тэр гаргаж байгаа зүйлүүдийг? Аль нь хаана энэ бодлого зангидагдах вэ? Энэ дээр хариулъя.

Тэгээд эргүүлээд би энэ тогтоолын төсөл дээр нэг санал байгаад байна. 20 номер дээр дээд боловсролын сургалтын байгууллагын тодорхой хөтөлбөрийг олон улсын магадлалд хамруулна гэхихсэн байгаа байхгүй юу. Угаасаа магадлал нь орж л байгаа шүү дээ их сургуулиуд. Анагаах лав хөтөлбөрөө олон улсын сургууль магадлалд оруулж л байгаа. Тэгэхээр энэ дээд боловсролын гэж бичээд доод тал нь төрийн өмчийн гэхээр энэ 2-ын хооронд ямар ялгаа байгаа юм оо? Энэ төрөөс энийг хийх юм уу? Энэ дээр зардал яригдаж байна уу? Төрийн өмч гэвэл зардал нь өөр яригдана. Дээд боловсрол гэвэл магадлалын зардал бас өөрөөр яригддаг. Эдгээрийг нэг бүрчлэн тодорхой хариулъя.

Б.Найдалаа: Хариулт микрофон 2 Наранбаяр сайд. Микрофон 2.

П.Наранбаяр: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Тэгэхээрээ бид үнэн. Өнөөдөр энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэгш хамран сургахад өнөөдөр жирийн ангид хүүхдүүдийг хамруулж ингэж сургахаас гадна дэмжих төвүүдийг байгуулж байгаа. Дэмжих төвүүдийг байгуулж тэнд нь бас тоног

төхөөрөмжийг нь өгч Дэмжих төв дээр бас яг сургалтыг, мөн эрүүл мэндийг нь дэмжих үйлчилгээг мөн бусад дэмжих үйлчилгээг Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, гэр бүлийн яамтай хамтраад ингээд хийж байгаа. Юуны хувьд бид бас энэ жилийн төсөвт яг энэ тусгай хэрэгцээтэй ийм хүүхдүүдийн тоног төхөөрөмжийг оруулсан. Яг энэ нэрээр нь оруулсан байгаа. Нийтдээ хэд орчим айн, 750 сая төгрөгийн бас энэ санхүүжилтийг тооцож оруулсан байгаа. Тэгээд одоо яг энэ яамны нэгжийн тухайд манай яаман дээр сая та бүхэн яасан бол төрийн төв байгууллагууд, төрийн захиргааны төв байгууллагууд, төрийн захиргааны буюу агентлагуудыг ер нь цөөлөх, газар хэлтсүүдийг нь цөөлөх ийм бодлогыг Засгийн газраас барьсан.

Тэгээд 1 загвараар 7 хүртэлх хүнтэй хэлтэс. Түүнээс дээш газар бол 10 хүнээс дээш байх ёстой ч гэдэг юм уу ийм тоон хязгаар тавиад тэгээд тэр хязгаартаа тааруулаад энэ дээрээ яг газар хэлтсээ цөөл гэсэн ийм зүйл ирсэн юм. Тэгэхээрээ манай яам 6 газар, 6 хэлтэстэй болж цөөрсөн. Энэ цөөрөх үеэр яг тэгш хамрангийн асуудал хариуцсан хэлтэс маань татан буугдсан. Тэгэхээр бас аюултай тал нь энэ л байгаа юм л даа. Яг таны хэлдэгчлэн яг ингээд асуудал байгаад байдаг.

Гэтэл ингээд Засгийн газраас 1 загвараар бүгдийг нь ингээд Боловсролын яам 6 газар 6 хэлтсээс илүү бүтцийг байгуулж болохгүй гэсэн юм ороод ирэхээр л ийм байдалтай болчхож байгаа юм. Тэгээд хуульд заасан хэлтсүүд үлдсэн. Яг энэ тэгш хамрангийн яг энэ хуульд байхгүй. Чиг үүргүүд нь бусад газруудад бүгдэд нь байгаа. Жишээлбэл, аймаг дээр, нийслэл дээр, дүүрэг дээр, Ерөнхий боловсролын газар, Нэгдсэн бодлогын газар гээд энэ юунууд дээр яг энэ асуудлаа хариуцсан энэ мэргэжилтэн, шинжээч, ахлах шинжээч нар нь ажиллаж байгаа. Нөхцөл байдал ийм байгаа гэдгийг танд тайлбарлаж хэлье.

Б.Найдалаа: Саранчулуун гишүүн тодруулж асууя.

О.Саранчулуун: Тодруулъя. Яах вэ яг наадах чинь хүн ам эрүүл мэндийн салбарын эмч, сувилагчаас бусад цомхотгол гэдэг шиг зарчим явчихсан гэж би ойлгоод байна тээ? Тэгэхээр энэ чинь өөрөө нийтээрээ энэ төрийн байгууллагууд аягүй хортой байгаа байхгүй юу. Тэгэхээр татан буулгачихсан тэр газар чинь тэгээд бодлого, үйл ажиллагаа нь ингээд алдагдаад буцаад бид нар хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш хамруулах сургуулилалт дээр олж авсан 2 жилийн сүүлийн хэдэн жилийн овоо босгож ирсэн амжилтаа ингээд буцаагаад хойш нь татчихаж байгаа гэж би харж байна шүү дээ.

Тэгэхээр энэ Байнгын хорооны энэ тогтоол дээр энэ асуудлыг заавал оруулах хэрэгтэй. Энэ дээр би заавал санал оруулж оруулах хүсэлтэй байна. Нэгэнт хийгээд эхэлчихсэн ажлын дундуур нь ингээд нэг ийм юм орж ирээд л хүн амын бүлэгт энэ чухал биш гэж байгаа юм шиг ингээд л хаячхаад байх юм. Энэ чинь тэгээд л дахиад л хүүхдүүдийн асуудал байгаа. Тэгэхээр энийг заавал буцааж энэ хэлтсийг байлгаж энэ чинь бодлогоо ганц ганц олж авсан юм нь энэ шүү дээ өдий хүртэл ярьж байгаад хуулиа дагаад. Тэгэхээр энэ дээр тогтоол дээр санал оруулмаар байна.

Б.Найдалаа: Зулпхар гишүүн энэ дээр хариулт өгнө.

С.Зулпхар: Саранчулуун гишүүний 3 асуултад би хариулъя. Эхнийх нь асуулт бөгөөд санал байгаа нь тэр бүтэцтэй холбоотой. Энэ бол гарцаа байхгүй их олон яаман дээр ингэж яригдаж байгаа. Энэ бүтэц зорилготойгоо нийцсэн, чиг

үүрэгтэйгээ нийцсэн байх ёстой бол сая бид 7 сард баахан Хэмнэлтийн хуультай уялдсан байдлаар бүтцийг жишээ нь багасгачихсан. Бүтцээ жишээ нь бүтэц дотроосоо тодорхой чиг үүргүүд хэрэгжүүлэх бүтцүүдийг аваад хаячихсан ийм нөхцөл байдал бүх яаман дээр байгаа юм.

Тэгэхлээр зэрэг бид энэ бүтэц байж байж чиг үүрэг хэрэгжих ёстой учраас тогтоолын төсөлд ийм санал оруулах нь зөв гэж ойлгож байгаа юм. Нэн ялангуяа саяын тэгш хамруулах мэргэжлийн боловсрол хариуцсан бүтэц ерөөсөө байхгүй болчихсон. Тэгж байж бид нар их том зорилт тавьсан. Одоо мэргэжлийн боловсрол дээр 42 мянган хүн суралцаж байна. Хариуцсан бүтэц байхгүй болчихсон учраас. Энэ бол сайдын асуудал биш. Үндсэндээ бид эргэж харах ёстой асуудал юм байна гэж ойлгож байгаа учраас энийг хүлээж авах нь зүйтэй гэж ойлгож байна. Бас тэрнээс гадна.../минут дуусав./

Б.Найдалаа: Нэмж минут өгье.

С.Зулпхар:Тэрнээс гадна та яах вэ сая хэлж байна. Тэр магадлан итгэмжлэлтэй холбоотой. Магадлан итгэмжлэлийг бид бүх сургуулиуд нээлттэй үлдээж энийг бодлогоор дэмжинэ гэж байгаа юм. Магадлан итгэмжлэлийн зардал сургуулиас өөрөөс нь гарна. Угаасаа ингэж гардаг учраас тэрийгээ хийгээд яваасай гэсэн чиг барьж байгаа. Нөгөө асуудал энэ төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын байгалийн ухааны хөтөлбөрийн сургалтыг 10 хувийг Англи хэл дээр зохион байгуулна гээд. Энэ бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нь тусчихсан 20 хувь гээд заачихсан байгааг бид ирэх жил 10 хувь болго гэдэг ийм бас чиглэл гаргасан байгаа. Тухайлсан санал бол энийг нэмж оруулах боломжтой.

Б.Найдалаа: Баярлалаа. Рэгдэл гишүүн асуулт асууна.

Д.Рэгдэл: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр энэ боловсролыг дэмжих жил чинь түрүүчийн Засгийн газрын үед зарлагдаад төлөвлөгөө гарсан гэж би ойлгоод байгаа. Тэгэхээр бидний энэ гаргаж байгаа тогтоолд заасан арга хэмжээнүүд, тэр хуучин төлөвлөгөөнд байгаа арга хэмжээнүүд дээр нэмэх юм уу, эсвэл шинээр боловсролыг дэмжих жилийн төлөвлөгөө зохиох юм уу гэж ийм асуултыг асууя яамнаас.

Хоёрдугаарт, энэ тогтоолын төслийг өчигдөр ч бид манай дэд хороон дээр яриад би бас зарим санал өгсөн. Заримыг нь хүлээж аваагүй байгаад байгаа юм. Энэ дээд боловсролтой холбоотой 16, 17 дугаар заалт байгаа юм. Тэгэхдээ зэрэг 16 дугаар заалт бол дээд боловсролын байгууллагын бие даасан байдлыг хангах талаар. Нөгөөдөх нь болохдоо зэрэг төрөөс дээд боловсролын сургалтын байгууллагад олгох татаасыг бодитой нэмэгдүүлэх, судалгааны тоног төхөөрөмжөөр хангах асуудал гээд ингээд байгаад байгаа юм. Тэгэхээр энэ хоорондоо харшлаад байгаа заалтууд. Яагаад гэвэл төрөөс авдаг татаас нэмэгдээд байх тусам бие даасан байдал доошлоод байдаг угаасаа.

Тийм учраас ер нь дээд боловсролын сургалтын байгууллагуудаар бие даасан байдал их сонирхолтой. Би бол нэлээн сайн мэддэг л дээ. Шинэ хуулиар ректорыг удирдах зөвлөл томилдог болсон. Ректорыг сонгон шалгаруулах комиссыг сайдын тушаалаар байгуулна. Сайд төрийн бодлого хэрэгжүүлэх байгууллагаа төлөөлөөд 3 хүн оруулаад бусад газраас 2 хүн оруулаад 5 хүнтэй комисс гардаг угаасаа. Тэгээд л 3 хүний саналаар сайдын тавих гэсэн хүн ректор

болдог. Тэгээд ректор болсон хүн про ректоруудаа бие даагаад томилчих эрх мэдэл байхгүй. Ингээд л формалный яваад байдаг. Энгийг бодитойгоор яамнаас ер нь ямар ажил хийвэл зүгээр юм? Та бүхэн бодооч. Тэр ажлын хэсгийг нь Удирдах зөвлөлийн даргын тушаалаар байгуулаад шалгаруулаад томилчихдог бол сайдаас өөрөөр хэлбэл засгаас хараат байдал их, дээд сургуулиудад нэлээн буурах юм байгаа юм.

Энэ 4 заалттай 22 дэд заалттай тогтоолын энэ 3 дугаар заалтын өгүүлбэр байгаа юм. Би бүүр ер нь Монголоор бас гайгүй уншиж ойлгодог л гэж өөрийгөө бодоод л байдаг. Энгийг ерөөсөө уншаад ойлгохгүй байгаа. Энэ юуны тухай? Бүүр ингээд уншаад үзэхээр барилга, сургалтын байгууллагын барилга байгууламж, ширээ сандал, тавилга, тоног төхөөрөмж бүрийг компьютержуулах энэ юу гэсэн үг юм? Тэгээд цааш нь унших юм бол бас ерөөсөө ойлгомжгүй. Энэ 3 дугаар.../минут дуусав./

Б.Найдалаа: Та минутаа нэмээд авах уу? Рэгдэл гишүүн минутыг нь нэмж өгье.

Д.Рэгдэл: Ядаад байхаар бас дахиж юм л тодруулахгүй. Та нар харин сайн хариулаарай. Тэгэхээр зэрэг энэ 3 дугаар заалт бол хэрэггүй дээ. Нэг бол 2 хуваамаар. Нэг бол байхгүй болгочихмоор л заалт байгаад байгаа. Тэгээд энэ дээр та бүхэн минь анхаараач. Тэгээд тэр 16, 17-доо та бүхэн сайн хариулаад өгөөрэй.

Хамгийн анхаармаар юм энэ дотор заалт болгонд “болон” гэдэг үг бараг 1-2 удаа орсон байгаа. “Болон”, “болон” гээд л яваад байгаа. Тэр үгнүүд энэ тэрийгээ та нар сайн хараад хүн шиг юм хийчих нь үү гэж хүсэж байна.

Б.Найдалаа: Баярлалаа. Наранбаяр сайд хариулна. Микрофон 2.

П.Наранбаяр: Рэгдэл гишүүний асуултад хариулъя. Баярлалаа. Тэгэхээр Нэгдүгээрт их, дээд сургуулийн эрдмийн эрх чөлөө бие даасан байдлын асуудал дээр ректорыг хэрхэн томилж байгаа вэ гэхээр яг Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хуульд заасан яг л тэр заалтынх нь дагуу л томилж байгаа. Ажлын хэсэг байгуулагдахгүй. Удирдах зөвлөл 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагддаг үүнээс 8 нь төрийн өмчийн оролцоотой ийм байгууллагуудаас төр талаасаа. Тэр нь Боловсролын сайд санал болгодог. Нөгөө 7 нь жишээлэх юм бол оюутны төлөөлөл, багш нарын төлөөлөл, үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл гээд тухайн сургууль нь өөрөө шийддэг. Ингээд 15 хүн өөрсдөө хуралдаад ректороо шууд сонгодог. Ректортоо бас төсвийг нь баталж өгдөг ийм л үд ажлыг Удирдах зөвлөл нь хийнэ. Ректор өөрөө проектор буюу өөрийнхөө орлох захирлуудыг өөрөө шууд томилж байгаа. Ямар нэгэн оролцоо байхгүй.

Тэгэхээр яг ийм систем рүүгээ явчихсан байгаа шүү. Энэ яг хуулийн заалтаараа явж байгаа гэдгийг нэгдүгээрт тайлбарлая. Яг тэгж байгаа. Одоо яг энүүгээрээ л явж байгаа. Хууль зөрчсөн ийм асуудал байхгүй. Бид яг л энэ хуулийн дагуу л яг ийм томилгоог ингэж хийж байгаа.

Хоёрдугаарт, Боловсролыг дэмжих жилийн төлөвлөгөө төсөв батлагдсаны дараа энэ батлагдахаар ингэж яригдаж байгаа. Тэгээд бид бас төсвийн төлөвлөгөөгөө боловсруулаад, оруулаад, засгаар хэлэлцүүлж тэмдэглэл

гаргуулсан байгаа. Үүнийгээ тогтоол хэлбэрээр. Энэ тогтоол гарсны дараа ингээд нийцүүлээд хэрэгжүүлэх ажлынх нь хүрээнд төлөвлөгөөг гаргана.

3 дахь заалтын тухайд тэр найруулга энэ тэрээг манай энэ ажлын хэсгийнхэн сайн засаж өгөөрэй. Үнэхээрийн тийм бас хэт их нуршуу урт өгүүлбэрүүд байна. “Болон, “болон” гэж их олон яасан найруулгын хувьд ядмаг болсныг л үгүйсгэхгүй. Энийг нь засаарай.

2-т тэр харин энэ энэ чухал заалттай байгаа юм энэ. 3 дээр нь санхүүгийн түрээс хэлбэрээр зохион байгуулах гэж оруулж өгсөн нь маш чухал. Өнөөдөр төсөв өөрөө мөнгө хүрэлцэхгүй ийм үед санхүүгийн түрээс хэлбэрээр энэ компьютер, бусад тоног төхөөрөмжүүдийг ингээд нийлүүлээд явах нь цаг алдахгүй хүүхэд лаборатори, тоног төхөөрөмж, ширээ сандал бүхий л зүйлээр хангагдах ийм сайн талтай байгаад байгаа юм. Тэгээд тэрийгээ төсвөөс нь төлөөд явдаг ийм боломж байгаа учраас энэ санхүүгийн түрээс гэдэг энэ заалтад маш чухал, бидний хувьд маш чухал байгаа. Энийг та бүхэн маань ойлгоорой. Мэдээж найруулгын тал дээр засаж сайжруулах зүйл байгааг хүлээн зөвшөөрнө үү. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа гишүүд асуулт тавьж, хариулт авч дууслаа.

Одоо тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байгаа юу? Үг хэлэх гишүүн байвал нэрээ оруулаарай. 4 гишүүн. Ганхүлэг гишүүнээр тасаллаа. Мөнхтуяа гишүүн.

Ц.Мөнхтуяа: Наранбаяр сайд ороод ирчихсэн байна. 25 оны асуудал шийдээгүй байхад бид нар 26 оны юм яриад байгаа нь аягүй зарчмын хувьд бас их болохгүй байна таарахгүй байна. Тэрийг түрүүн би Батжаргал даргаас асуучихсан. Одоо би ярих гэж байгаа юм болохоор энэ тогтоол дээр чинь ерөөсөө ийм тодорхой юм ерөөсөө байхгүй. Жишээлбэл ингэж байгаа байхгүй юу багшийн дутагдал, хомсдолын талаар хийсэн судалгаа тооцоолол, дүн шинжилгээнд үндэслэн 2030 онд багшийн дутагдлыг бодитоор арилгах төлөвлөгөөг гаргаж, багш бэлтгэдэг их, дээд сургуулиудын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, төлбөрийн хөнгөлөлттэй болгоно гээд ингээд энэ утгагүй юм ороод ирсэн байна. Энэ дээрээ аягүй тодорхой ингээд бичихгүй бол 2030 оноос л багшийн дутагдлыг ингээд судлах юм уу гэдэг ийм асуулт сая түрүүн бас Эрдэнэбат гишүүн асуусан шүү дээ.

Тэгэхээр энэ байна. Тэгээд л надад энд асуух юмнууд аягүй их байна л даа. Цаг нь хүрэхгүй байна. Жишээлбэл, энэ хиймэл оюун ухаанд суурилсан хөтөлбөр нэмнэ гэж байгаа юм. Гэтэл дунд анги 18-19 төрлийн хичээл агуулга нь хүндэрчихсэн байгаа шүү дээ. Энийг цөөлье гэж ярьж байхад дахиад дээрээс нь хиймэл оюун ухааны агуулга, хөтөлбөр нэмэх юм уу? Энэ тохиромжтой юм уу? Хөдөө орон нутагт датагүй, интернэтгүй газар энэ хэрэгжих боломж байгаа юу? Энэний судалгаа тооцоо байна уу? Тэгээд энэ багш ажилтнуудын цалин хөлс гээд энэ түрүүн Зулпхар гишүүн надаа уншиж өгөөд байсан. Энэ 2-т нь байна л даа. Тэгээд энэ яг хэзээ, ямар хувиар, хэдэн хувь нэмэгдэх юм бэ гэдэг ийм тодорхой л юм хэрэгтэй байна. Тэрнээс зүгээр л бүх юман дээр тэгнэ ингэнэ гээд ирээдүй цаг дээр заагаад хийсэн, хэрэгжүүлсэн юм байхгүй тэгээд л дараагийн жил болдог шүү дээ. Тэгэхээр эд нарыг бүгдийг нь тоотой болгомоор байна.

Ер нь таван жилийн үндсэн чиглэл батална шүү дээ. Тэрний дараа бид нар дахиад энэ дээрээ суугаад тал талаасаа бүүр ингээд тоо тавимаар байна. Тэгэхгүй ингээд хэмжиж чадахгүй, үнэлж чадахгүй гээд яриад байгаа шүү дээ. Ямар ч

хэмжих юм байхгүй зүгээр л тэгнэ, ингэнэ, сайжруулна, засна гээд ийм үлгэрийн юм хийчихээр энэ чинь дараа нь ямар ч юу хариуцлага тооцох юм байхгүй байна шүү дээ энэ дээр. Тэгэхээр энийг бүүр дахиад л сайжруулмаар байна. Сая Рэгдэл гишүүн бүүр шоолж инээгээд байгаа биз дээ шинжлэх ухааны хүн шоолоод инээгээд байна шүү дээ ойлгохгүй байна гээд. Тэгээд үнэхээр энэ дээр засах юм маш их байна. Би бүүр ингээд сарааччихсан байна.

Тэгээд энд ингэж байгаа юм Бүсчилсэн хөгжлийн бодлогыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд бүс бүр технологийн коллеж, KOSEN сургууль байгуулахад онцгой анхаарч өмнө нь байгуулагдсан Технологийн коллежуудаас туршлага судалж хамтарч ажиллана. Байгуулаад л хаячих юм уу? Ажиллах багш байгаа юм уу, боловсон хүчин байгаа юм уу? Өнөөдөр багшийн хомсдолд ороод арай ядаж байж дахиад баахан бүс бүрд KOSEN байгуулна л гэнэ, тэр KOSEN байгуулах мөнгө төгрөг чинь хаана байна, багшлах боловсон хүчин чинь хаана байна? Энэ мэт ийм үлгэрийн, агаарын, хөрсөн дээр буугаагүй юмнууд аягүй их орж ирсэн байна. Тэгэхээр энийгээ засаж залруулаад таван жилийн үндсэн чиглэлтэйгээ холбоод уяад явсан нь дээр байх гэж бодож байна шүү Наранбаяр сайдаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: 2026 оныг бид нар боловсролыг дэмжих жил болгон зарлаж байгаа. Үүнтэй холбогдолтой тодорхой бас төсвийн хэлэлцүүлгүүд дээр, бусад хэлэлцүүлгүүд дээр бид нар яг юуг шийдэж чадах вэ гэдэг асуултыг би бас удаа дараа асуугаад байгаа. Энэ утгаараа энэ батлагдаж байгаа тогтоол маань энэ 2026 оны гол энэ зорилтыг хангахад Байнгын хороо тодорхой чиглэл өгч байгаа ийм бас өндөр ач холбогдолтой тогтоолын төсөл байна. Өмнөх өмнөх тогтоолын төслүүдтэй адилхан гардаг үр дүнг нь хэмжиж болдоггүй бас хэрэгжилт нь тодорхой 50 хүрэхгүй хувьтай байх ийм тогтоол биш байгаасай гэж бодоод байгаа юм.

Тийм учраас тодорхой саяын бас асуусан асуултуудынхаа дагуу хэд хэдэн саналуудыг бас тогтоолын төсөлд тусгуулах саналтай байгаагаа бас илэрхийлье.

Хамгийн нэгдүгээрт, энэ Боловсролын зээлийн сантай холбогдолтой асуудлыг энэ дээр нэлээн нарийвчилж оруулж өгөөч. Энэ 2, 3 хүрээнд бас хийгдэх ажлуудыг нь бас нэлээн задалж оруулаад дараа нь бас энэ юуныхаа дагуу бид нар хэрэгжилтийг нь бас ингээд хангуулаад явах нь зөв байна гэсэн ийм саналтай бас байгаа юм.

2 дахь нь боловсролын жилийн хүрээнд хүүхдийн бас энэ ялгаварлалгүйгээр тодорхой энэ “Үдийн цай” хөтөлбөрийг хангуулах чиглэл дээр “Үдийн цай” гэдэг хөтөлбөрийг яах вэ хийхэд хэцүү байгаад байгаа юм. Эхний ээлжид бид нар нийт хүүхдүүддээ сүү өгсөн Хятадын, Японы энэ туршлагуудыг бас нэвтрүүлэх чиглэлээр ингээд алхам алхмаар явъя. Улсын төсвийн нөхцөл байдал юмнууд бас хүндрэлтэй нөхцөл байдлууд байгаа учраас. Тэгэхээр энэ хүүхдийн яг сүү хөтөлбөрийг илүү нарийвчилж судлах тодорхой энэ ажлыг бас энэ тогтоолын төсөл дээр тусгуулбал яасан юм бэ гэсэн ийм 2 дахь санал байгаа.

Тэр орчныг сайжруулах менежменттэй холбогдолтой тэр заалт дээр тэр зуны хугацаанд энэ их, дээд сургуулиудыг болон 10 жилийн сургуулиудыг бас ашиглах чиглэлийн энэ заалтыг хэрвээ оруулах боломжтой оруулж өгөөч гэсэн.

4 дэх нь энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбогдолтой асуудлыг бас орхигдуулсан байна гэж байна. Тийм учраас ажлын хэсгийн ахлагч, дэд хорооны дарга маань бас яг энэ чиглэлийнхээ асуудлыг бас оруулж ирэх, оруулж ирээсэй гэж бодож байна. Ялангуяа их, дээд сургууль оюутны тухай би яриад байгаа юм. Их, дээд сургуульд дээд боловсрол эзэмших энэ боломжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд хүртэхэд төвөгтэй асуудлууд байна. Хэлэлцүүлгүүд зохион байгуулаад ингээд ажиллахад яг үнэндээ их, дээд сургуулиудад суралцахад хамгийн төвөгтэй асуудал нь нойл орох асуудал байна гэдэг ийм энгийн саналыг гаргаж ирж байгаа юм.

Тэгэхээр нийт 18-34 насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 2 хувь нь буюу 436 иргэд их, дээд сургуулиуд суралцаж байна. Үлдсэн 98 хувь нь гэртээ байгаа асуудлыг бид нар зайлшгүй анхаарах ёстой. Тэгэхээр энэ их, дээд сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг их, дээд сургуульд суралцах боломжийг бас хангуулах чиглэлээр хувийн туслахын үйлчилгээг нэмэгдүүлэе, сургалтын орчныг сайжруулъя, тусгай энэ тохируулгуудыг бас хийх энэ стандартуудыг бас боловсруулъя. Энэ чиглэлийн сайн дурын үйл ажиллагаагаар энгийн оюутнууд дэмжиж ажиллахад тодорхой кредитийн системээр тооцдог, сайн дурын үйл ажиллагааг нь бас дүгнэдэг энэ гаднын туршлагуудыг бас оруулах гэсэн нарийвчилсан ийм заалтуудаар оруулбал ямар вэ гэсэн ийм саналыг оруулж байгаа юм. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Баярлалаа. Гялс, товчхон саналуудаа бас хэлчихье. Тэгш хамруулах бодлогын энэ хэлтсийг эргэн байлгахтай холбоотой санал оруулна. Дараа нь түрүүний Ганхүлэг гишүүний хэлсэн тэр протез биш ээ, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хүүхдүүдийг, оюутнуудыг сургахтай холбоотой хүртээмжийн асуудлаар бодитой ажлуудыг энэ дээр бас оруулах ийм бодол хүсэлтэй байна.

3-д нь өнгөрсөн жил бид нар Боловсролын зээлийн сангийн журмын асуудлаар 1 жил ажиллахдаа 1 зүйлийг дутуу хийчихсэн байгаа. Тэр нь юу вэ гэхлээр протез, ортезоор сурдаг нөгөө тусгай хэрэгцээт боловсролоор сурдаг хүүхдүүд 17, 18 настай хүүхдүүд сонгогддоггүй юм байна. Энэ чинь дэд бакалавр юм байна, зарим нь магистр юм байна, ээж аав нар сурах юм байна, эсвэл Сувилахуйн сургууль төгссөн бакалавр суурьтай хүмүүс сурах юм байна гэдгийг өнгөрсөн жилийнхээ журмаас өнөөдөр харчихсан.

Тэгэхээр энэ хүн амын тоо нь тийм олон биш. Эдийн засагч, хуульч шиг хэдэн олон арваараа сурдаг мэргэжил биш. Нөгөө талд Монголд хэрэгтэй байгаа, дутагдаад байгаа учраас энэ мэргэжилтнүүдийнхээ суралцах эрхийг нь Боловсролын зээлийн сантайгаа уялдуулж нээж өгөхтэй холбоотой өөрчлөлт оруулмаар байна. Тэгэхээр энэ 3-ыг та бүхэн томъёолж ингэж бэлдэж надад өгөөч, туслаач гэдгийг бас хэлмээр байна. Ийм 3 зүйл дээр анхааръя гэж хүсэж байна.

Б.Найдалаа: Галбадрах гишүүн нэрээ татсан байна. Тийм болохоор гишүүд үг хэлж дууслаа.

Одоо тогтоолын төсөлтэй холбоотой санал хураалт явуулна. Санал хураалтад бэлдье. Тэгээд сая гишүүдийн гаргасан саналууд маш тодорхой найруулгын болон редакцын чанартай зарим нь ч агуулгын чанартай саналууд байна. Энийг ажлын хэсэг дээрээ нэг бүрчлэн сайн тусгаад яг тэр тусгасан төслөөр

нь санал хураана гэсэн үг. Ингээд санал хураалтад бэлтгэсэн үү манайхан? Гишүүд бэлэн орчихсон уу? Ганбаатар гишүүн ороогүй байна. Ганхүлэг гишүүн бас ороогүй байна шүү. Саяын найруулгыг редакцын засвар хийгээд найруулгыг нь эцэслээд тэгээд тэр хувилбараар нэмэлт тэрийг оруулаад Зулпхар гишүүн тээ. За тэгье.

Тэгэхээр “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлахыг дэмжье гэсэн саналаар санал хураалт.

Гишүүдийн 66.7 хувь дэмжиж тогтоолын төсөл батлагдлаа.

Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Идэвхтэй оролцсон гишүүддээ маш их баярлалаа.

15.48 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР